

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Мягмар гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	0
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-72

---

- 1.Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээлэл сонсох** 5-42
- 2.“Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл** 42-60
- 3.“Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл** 60-72

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны  
11 дүгээр сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, О.Саранчулуун, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ж.Баярмаа;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Д.Үүрийнтуяа, Б.Түвшин;

Байнгын хорооны дарга Л.Энхнасан хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 2 дугаарт хэлэлцэх горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

**Л.Энхнасан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг 2 дугаарт хэлэлцэхээр тогтов.

**Нэг.Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Батжаргал, мөн яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Д.Ренчиндорж, мөн газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга Ю.Отгонбилэг, Гэр бүлийн бодлогын газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга С.Рэгзэн, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Х.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны

Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Идэрбат, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, Ж.Баясгалан, Ц.Мөнхтуяа, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Батжаргал, мөн яамны Хөдөлмөрийн бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга Ю.Отгонбилэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 12 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.“Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Батжаргал, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Ц.Сүхбаатар, Р.Сансармаа, Б.Баяраа, Э.Энхжаргал, Х.Буянжаргал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Г.Банзрагч, мөн зөвлөлийн Тэтгэмжийн даатгалын сан хариуцсан аудитор, шинжээч Л.Ган-Өлзий, Тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт хариуцсан мэргэжилтэн Ч.Ганхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Тогтоолын төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Д.Ганмаа, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэбат, С.Зулпхар, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Г.Банзрагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон нар хариулж, тайлбар хийв.

**Л.Энхнасан:** “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 7  
Бүгд: 13  
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан Улсын Их Хурлын гишүүдийн санал хураалтын төхөөрөмж гацсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг, Т.Баясгалан, Ш.Зоригоо, Ж.Гэрэлмаа, Н.Одонгуа, мөн зөвлөлийн Ажлын албаны дарга Ц.Сарантуяа, мөн албаны аудитор Н.Хишигсүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Тогтоолын төслийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Ганмаа, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг, Н.Одонгуа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

**Л.Энхнасан:** “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 8  
Бүгд: 13  
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 57 минут үргэлжилж, 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 24 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 10 цаг 27 минут

### НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энхнасан:** Хурлаа эхэлье. Хүлээсэн гишүүддээ баярлалаа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Ариунзаяа гишүүн, Ганмаа гишүүн, Мөнхтуяа гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Зулпхар гишүүн, Нарантуяа-Нара гишүүн, Эрдэнэбат гишүүн, Баясгалан гишүүн, Идэрбат гишүүн, Сарнай гишүүн оролцож байна. Мөн өнөөдөр Баатархүү гишүүн чөлөөтэй байгаа. Бейсен гишүүн, Саранчулуун гишүүн гадаадад томилолттой байгаа. Болормаа гишүүн, Үүрийнтуяа гишүүн нар өвчтэй байгаа. Бусад гишүүд, ялангуяа тойргийн гишүүд өнөөдөр Ахмадын болон Үндэсний эрүүл мэндийн сангийн, Нийгмийн халамжийн сангийн асуудлыг сонсож байхад байхгүй байгаа нь харамсалтай байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52,4 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 11 сарын 19-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээр асуудал. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсоно.

2.Байнгын хорооны тогтоолын төсөл “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай”

3.Байнгын хорооны тогтоолын төсөл “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай” 3 асуудлыг өнөөдөр хэлэлцэх болно.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Идэрбат гишүүний микрофоныг нээнэ үү.

**Ц.Идэрбат:** Байнгын хорооны гишүүдэд энэ өглөөний мэнд хүргэе. Миний хувьд өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудалтай гэхээсээ илүүтэйгээр дараагийн хуралдаан дээр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд бас бэлтгэх үүднээс бас хэлж байгаа юм. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал дээр өргөн баригдсан хуулиуд Шинэ дэгийн хуулиар бол буцаан татагдаад эргээд Улсын Их Хуралд өргөн баригдах энэ процесс явагдаж байгаа энэ цаг үед бидний хувьд бол бас ачааллын хувьд харьцангуй гайгүй байгаа. Удахгүй энэ хуулиуд өргөн баригдаад ирэхээр Байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганы ачааллууд бол илүү ихэснэ.

Тэгээд энэ хугацаанд бид бас Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаатай, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн үйл ажиллагаатай танилцлаа. Тэгээд энэ дээр танилцсан 2 байгууллагын үйл ажиллагааг харахад

энэ танилцуулсан асуудалтай холбогдуулаад авч хэрэгжүүлэх арга хэмжээ нэлээн байна гэж ингэж харж байгаа. Бид нар Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийнхний тайлбарыг сонссон. Төвийнх нь 100 хэдэн хүнтэй, орон нутагт 21 аймаг, 9 дүүрэг нийлээд 60 хэдхэн хүнтэй хөл толгой нь эргэчихсэн юм шиг ийм байгууллага байна гээд, үүнээс авхуулаад бид бас цаашдаа авч хэрэгжүүлэх арга хэмжээ байна. Тэгэхээр Байнгын хороо энэ дээр дараа дараагийн хурлууд дээрээ бидний танилцуулсан арга хэмжээний танилцуулгаас цаашид авах арга хэмжээгээ бас ярьж, үр дүнг нь үздэг байхгүй бол болохгүй.

СЭМҮТ гэж Монголд ганц байгаа ийм эмнэлэг байна. Үнэхээр үйл ажиллагаа нь бас хэцүүдчихсэн юм байна. Манай Байнгын хороонд хамаарах 2 яамны хоорондын уялдаа холбоо бас хэрэгтэй юм байна. Тэнд эмнэлэг юм уу, сувилал нь мэдэгдэхээ больчихсон. 240, 250 хүн насан туршдаа тэнд сувилуулаад, тухайн эмнэлгийн үйл ажиллагаа нь доголдол үүсгэж байгаа юм. Энэ нь яг тэр СЭМҮТ-ийн үндсэн чиг үүрэг мөн үү, биш үү гэх мэтчилнээр ингээд авах арга хэмжээнүүд байна.

Нөгөө Шар хадны хурцын тасаг гэж ярьдаг тэр хүмүүсийн асаргаа сувилгаа хийдэг тэр хүмүүсийн цалин хангамжийн асуудал бас арай өөр түвшинд авч үзэхгүй бол болохгүй юм байна. Тэгэхээр Улсын Их Хурал төсвийн тодотголыг энэ 11 сар, 12 сард хэлэлцэхээр байгаа. Тэгэхээр тодорхой асуудлуудыг бид үр дүнд гаргахын тулд хөрөнгө мөнгөнийх нь эх үүсвэрийг шийдэхээс эхлүүлээд асуудлууд байгаа учраас Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулаад Байнгын хороонд танилцуулсан асуудал бас шийдэгдээд явдаг ийм зарчимтай байвал бас зүгээр юм уу гэж ингэж байх ёстой. Зүгээр юм уу ч гэж ер нь байх ёстой. Тэр утгаараа дараа дараагийн хурлаар энэ танилцуулгадсан 2 асуудал дээрээ бас анхаараач гэдэг ийм санал байна.

3 дахь нь бол 2024 оны 9 сарын 1-ээс Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Өнөөдөр бид нар Ахмад настны хуулийн хэрэгжилтийн асуудлыг сайд танилцуулах гэж байна. Яг үүнтэй уялдуулаад Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн үйл явцын талаар бид бас танилцуулга сонсох нь зүйтэй болов уу гэж бодож байгаа. Яагаад гэвэл энэ удаагийн батлагдсан Хүүхэд хамгааллын хуулийн нэг онцлог бол энэ хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хөрөнгө мөнгөний асуудал, орон тооны асуудал маш ихээр дутагдаж байсан үндсэн хүндрэлүүдийг бол шийдсэн. Гэхдээ шийдэхдээ улсын төсөв дээр дарамт тавигдах гэхээсээ илүүтэйгээр аймаг, сумын төсвөөсөө хүүхэд хамгааллын зардлыг тухайн шатны Засаг дарга Иргэдийн хурал нь өргөн барихдаа Засаг дарга нь иргэдийн хуралдаа өргөн барихдаа тусгачихсан байх ёстой гээд заачихсан байгаа. Одоо ингээд 12 сарын 5-ны өмнө аймгийн төсвүүд батлагдана. 15-ны өмнө сумын төсвүүд батлагдана. Тэгэхээр энэ Хүүхэд хамгааллын хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд нь заагдсан энэ санхүү хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудлууд тусгагдаж байгаа эсэх дээр ч гэсэн бид нар бас анализ хийх ёстой болов уу гэж ингэж бодож байгаа юм. Тэгэхээр дараагийн хурлаар энэ 3 асуудлыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Эрдэнэбатын микрофоныг нээж өгнө үү. Үгээ хэлнэ үү.

**С.Эрдэнэбат:** Өмнөх байнгын хороогоор бас яригдсан асуудал байгаа. Энэ Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын өнөөдөр дүрэм нь орж байх шиг байна. Энэ сантай холбоотой бараг 10 гаруй жил яригдаж байгаа өрийн асуудлууд

одоо хүртэл олон нийтээс хүлээлтийн байдалтай байж байгаа. Энх-Амгалан сайд бол энэ тал дээр бас өмнөх Байнгын хороо дээр ярьж байсан. Шүүх хуулийн байгууллагаас эхнээс нь авхуулаад энэ буруутай этгээдүүд энэ 10 жилийн өмнөөс яагаад үүссэн юм. Одоо ямар шатдаа байж байгаа юм гэдэг энэ өр төлбөртэй холбоотой асуудал дээр Байнгын хорооныхонд бас дараагийн хэлэлцэх асуудлаар тодорхой мэдээллийг явцын талаар бол урьдчилсан байдлаар бол танилцуулж өгөхийг хүсэж байна. Тийм учраас энийг бол албан ёсны бас протоколд тэмдэглүүлж, дараагийн хуралдаан дээр яг одоо ямар байдалтай байж байгаа юм, ямар барьцаа хөрөнгүүд байж байгаа юм. Миний сураг сонссоноор бол ер нь бараг ихэнх нь найдваргүй, борлогдохгүй, яах нь мэдэгдэхгүй ингээд бүр нэлээн хүндрэл дагуулаад ирчихсэн. Үүнтэй холбоотой ч гэсэн энэ даатгал юутай холбоотой олон нийтийн зүгээс бас маш их асуулт, санал ирэх юм. Тэгээд энэ талаар нь албан ёсоор Байнгын хорооны хорооныхоо хурал дээр бүгдээрээ нэг мэдээллээ аваад, тэгээд ямар дэмжлэг юу хэрэгтэй юм тэр талаас нь бас нэг яривал ийм саналыг оруулж байна.

**Л.Энхнасан:** Зүйтэй. Би бас Идэрбат гишүүний саналыг бол 100 хувь дэмжиж байна. СЭМҮТ-д очиход бол СЭМҮТ-ийн нөхцөл байдал, төсөв нэлээн хэцүү байсан. Тэгээд зөвхөн СЭМҮТ гэхгүй, ер нь Байнгын хорооны гишүүд ажиллаж танилцаж байгаа газруудтайгаа танилцсаны дараа ажил хэрэг болгож хамгийн түрүүнд бол сэтгэл зүйн асуудлын талаар хэлэлцүүлэг ер нь хийх нь зүйтэй юм байна гэсэн дараагийн бас манай Байнгын хорооны ажил болно гэж найдаж байна. Бусад асуудлуудаар бас манай Байнгын хорооны ажлын алба бол анхаарч дараа дараагийн хурлын дараалалд оруулаарай гэж үүрэг өгье.

Ингээд би өөрөө бас энэ хэлэлцэх асуудлаар нэг саналтай байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2 дахь асуудлыг 3 дахид нь сонсоод, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах журмыг бол 2 дахь асуудал болж сонсьё гэсэн саналтай байна. Гишүүд зөвшөөрч байна уу. Санал хураалт хийе. 63 хувиар дэмжигдсэн байна. Ганмаа гишүүн, Баясгалан гишүүн дэмжсэн. Эрдэнэбат гишүүн дэмжсэн.

Тэгэхлээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг хамгийн сүүлд нь сонсьё. Энх-Амгалан сайд маань 2 асуудлаа шууд дараалаад танилцуулах үүднээс ингээд өөрчлөлт орж байгаа шүү.

**Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын мэдээллийг сонсьё.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд. Ажлын хэсгийг оруулаарай. Рэнцэндорж Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Отгонбилэг Хөдөлмөрийн бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга, Рэгзэн Гэр бүлийн бодлогын газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга, Тамир, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Батжаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын хуримтлалын сангийн бодлогын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан танилцуулгаа хийнэ үү.

**Л.Энх-Амгалан:** Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Тэгээд өнөөдөр бас Байнгын хорооныхоо хурлаар Ахмад настны талаар хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, цаашдын зорилтын талаар бас мэдээлэл сонсох санал гаргаж, мэдээлэл хийх боломжийг олгосонд бас гүнээ талархаж байна. Юуны түрүүнд бас яг энэ чиглэлээр Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2022 оны 6 сарын 7-ны өдрийн энэ 11 заалттай ийм тогтоол гарсан. Энэ их сайн тогтоол гарсан. Оюунчимэг даргыг дарга байх үед гарсан. Тэгээд энэ тогтоолын хэрэгжилт ер нь ямархуу шатад байгаа вэ гэдэг чиглэлээр бид нар бас мэдээллүүд бэлдээд гишүүдэд энэ 11 заалтын дагуу Засгийн газарт өгсөн үүргийн дагуу хийгдэх ёстой ажлуудын гүйцэтгэлүүдийг бас ингээд ийм мэдээлэл болгоод бэлдчихсэн байж байгаа. Энийг бүх гишүүдэд тараах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

2-т нь өнөөдөр миний хийх гэж байгаа мэдээллээр энэ ахмад настны талаар хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, цаашдын зорилт гээд презентац бэлдсэн байгаа. Энэ презентацуудыг бас Улсын Их Хурлын гишүүдэд тарааж өгсөн байгаа. Тэгээд би өнөөдрийнхөө мэдээллийг танин мэдэхүйн гэхээсээ илүү өнөөдөр тулгамдаж байгаа асуудлууд, цаашдаа Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээ, энэ Ахмад настны тухай хууль маань ирэх оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлнэ. Ингээд хэрэгжиж эхлэхэд бид нар ер нь ямархуу бэлтгэлүүд хангаж байгаа юм бэ гэдэг асуудлуудаар мэдээлэл өгөх нь зүйтэй болов уу гэж бас бодож байна.

Мэдээж дэлхийн хүн амын 65 ба түүнээс дээш насны ахмадууд 2022 онд 10 хувийг эзэлж байсан бол, 2030 онд 12 хувь, 2050 онд бол 16 хувь гээд 1,6 тэрбум болж өснө гэсэн ийм тооцоо байгаа ерөнхий хандлагууд ер нь ийм дэлхийн хандлагууд ийм болсон байгаа.

Тэгээд Монгол Улсын хувьд бол 60 ба түүнээс дээш насны ахмадын тоо бол 2000 онд хүн амын 5,4 хувь, 2010 он 5,8, 2021 онд 9,7 байсан бол 2030 онд 11,9, 2050 онд 5 хүн тутам нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг үндэсний статистикийн газраас ийм тооцоонууд гаргасан байгаа. Манай улс 2023 оны байдлаар нийт 385 мянган ахмад настантай байна. Энэ бол нийт хүн амын 10,9 хувь гэсэн үг. Эмэгтэй 55, эрэгтэй, 60 наснаас дээш ахмадууд байгаа. Өнгөрсөн жил ДЭМБ-аас насны ангиллын шинэчлэл тогтоосон. Энийг бол бид нар ард иргэдэд тэр тусмаа ахмадууддаа бид нар ойлгуулах ёстой.

Юу гэхээр насанд хүрэгчдийг 25-64 нас болгосон байгаа. Ингээд ахмад настан 65-аас дээш насны ахмад настнаа дотор нь залуу ахмад буюу 65-74 нас, ахмад middle old гэдэг нь бол ахмад 75-84 нас, oldest old гэдэг нь өндөр настан буюу 85-аас дээш насны ахмадуудыг ингэж ангилна гэдгийг ДЭМБ-аас тогтоож, энийг бас улс орнууд цаашид ахмадын талаар явуулах бодлогодоо нэлээн өөрчлөлт оруулж байгаа ийм бодлогын бичиг баримтууд гарсан байгаа. Тэгээд хүн ам зүйн өөрчлөлт энэ ахмад настнуудын өсөж байгаа тоо өсөж байгаатай холбогдуулан ахмад настны нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тогтолцоонд өөрчлөлт хийх, ахмад настны хөдөлмөр эрхлэлт, урт хугацааны тусламж,

үйлчилгээ, ахмад настны хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээг сайжруулах шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бид нар ахмад настны талаар авч хэрэгжүүлэх зорилтуудаа тусгасан. Үүнд:

Нэгд бол ахмад настанд гэр бүлийн цогц төвөөр дамжуулан тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж идэвхтэй насжилтыг дэмжинэ гэдэг ийм зорилт туссан байгаа.

2-т нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд өмчийн төрөл бүрийн хэлбэрээс хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2-оос доошгүй хувийн орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой, аюулгүй, хүнд нөхцөл, байрнаас бусад ажлын байранд ажиллуулах зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлнэ гэдэг ийм зорилтыг хийсэн. Энэ нэг ийм олон жил хэрэгждэггүй ийм 2 хуулийн зохицуулалт яваад байдаг. 1 нь бол нөгөө 50 ба түүнээс дээш ажилтантай ахмадууд ажлын байрныхаа 2-оос доошгүй хувийг ахмад настныг ажиллуулна гэдэг энэ хуулийн заалт хэрэгждэггүй. Нөгөөдөх нь Ахмад настны сан байгуулах тухай хуулийн заалтууд ерөөсөө хэрэгждэггүй ийм 2 хэрэгждэггүй заалтыг ямар ч байсан бид нар ирэх 4 жилд хэрэгжүүлнэ гэдэг ийм зорилтыг Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт тусгасан байгаа.

Ахмад настныг шинэ ур чадварт сургах, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ. тэтгэврийн хэмжээг инфляц, хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулж жил бүр нэмэгдүүлнэ гэж бид нар заасан.

Ингээд 2023 онд Засгийн газар тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн 2014 оноос хойш 9 жилийн дараа бас ингэж шинэчилж баталсан байгаа. Шинэчлэн баталсан итгэлцүүрээрээ 488 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн бодож, үүнээс 164 мянган тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээ дунджаар 181 мянган төгрөгөөр нэмэгдэж, дундаж тэтгэврийн хэмжээ 687 мянгад хүрч, тэтгэврийн зөрүүг тодорхой хэмжээнд ойртуулсан ийм арга хэмжээ болсон. Энэхүү арга хэмжээнд нийт 200 орчим тэрбум төгрөгийг бас зарцуулсан байна.

Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин буурч дундаж наслалт нэмэгдсэнтэй холбоотойгоор насжих үйл явц идэвхтэй явагдах болсон. Энэ үйл явц Ази Номхон Далайн орнуудад илүү идэвхтэй явагдаж, тэдэнд тулгарч буй гол асуудлууд болоод байгаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Номхон далайн баруун бүсийн эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ахмад настны эрүүл мэнд, нийгмийн халамжийн хэрэгцээг цогц байдлаар урт хугацааны туршид тасралтгүй тусламж, үйлчилгээгээр хангах заалтыг хэрэгжүүлэхэд ахмад настны цогц тусламж, үйлчилгээг өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалт хийхийг зөвлөсөн байгаа. Үүний дагуу энэ зөвлөмжийн дагуу бид Ахмад настныхаа тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх зүйн шинэчлэлийг хийсэн байгаа.

Засгийн газраас ахмад настны эрхийг баталгаажуулж, хөгжлийг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн

бодлогын олон арга хэмжээ хэрэгжүүлж байна. Тухайлбал Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн зөрүүг ойртуулах, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой шийдвэр гаргасан. Энийг би бас сая та бүхэнд бас мэдээлэл өглөө. Энэ хүрээнд нийгмийн даатгалын багц хуулийг Улсын Их Хурлаар бас батлуулсан. Энэ хуульд тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, итгэлцүүрийг улсын дундаж цалин хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоож мөрддөг байхаар тусгасан. Үүний дагуу бид сая Улсын Их Хуралд өргөн барьсан 2025 оны улсын төсөв дээр ирэх жил бид нар улсын эдийн засгийн инфляцыг бол 6 хувь байхаар онилж байгаа. Энэ хүрээндээ бид нар тэтгэвэр тэтгэмжийн инфляцын түвшинтэй уялдуулж нэмэх анхны энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс 6 хувийн тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх төсвийг бас бид нар батлуулж авлаа. Энийг бас бид нар энэ журмыг Засгийн газраар бас батлуулсан байгаа. Энэ хүрээндээ бид нар 2025 оныхоо улсын төсвийг өргөн барьсан.

2024 оны 4 сараас Нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн алба хаастын тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн. Ингэснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 650 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 540 мянган төгрөг, дундаж тэтгэврийн хэмжээ 787 мянган төгрөгт хүрсэн байна. Ахмад настан нийгмийн даатгалын эсвэл нийгмийн халамжийн сангаас аль нэгээс тэтгэвэр авч тэтгэвэргүй ахмад настан байхгүй байгаа нь ахмад настны нийгмийн баталгааны чухал үзүүлэлтүүд байгаа.

Засгийн газрын 2024 оны 122 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг сард 375 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэрт нийт 7235 ахмад настан өнөөдрийн байдлаар хамрагдаж байна. Монгол Улсын 2025 оны улсын төсвийн тухай хуульд нийгмийн даатгал, нийгмийн халамжаас олгох тэтгэврийн хэмжээг тус бүр 6 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй ахмад настан буюу 10 хүрэхгүй жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн ахмад настан нийгмийн халамжийн тэтгэвэр авч байгаа. Ахмад настан нийгмийн даатгалын эсвэл нийгмийн халамжийн сангийн аль нэгээс тэтгэвэр авч тэтгэвэргүй ахмад настан байхгүй байгаа нь ахмад настны нийгмийн баталгааг үзүүлэхэд чухал үзүүлэлт болж байгаа. Энэ үзүүлэлтээрээ манай улс бол бас Азийн бусад улсуудтай харьцуулахад бол нэлээн нийгмийн хамгааллын чиглэл, тэр тусмаа ахмад настны нийгмийн хамгааллын чиглэлд хийгдэж байгаа хүрсэн том ололт гэж бас манайхыг дурддаг юм байна лээ.

2024 онд нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээ сард 375 мянган төгрөг байна. Мөн нийгмийн халамжийн сангаас байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэн бүрд 302 мянган төгрөгийн тэтгэмж олгож байна. Ингээд бид нар ер нь цаашдаа нийгмийн халамжийн сангаас олгож байгаа энэ асаргаа, сувилгаануудад зарцуулж байгаа, тэр тусмаа ахмад настануудад зарцуулж байгаа энэ халамжид зарцуулж байгаа энэ мөнгийг бид нар нэг сайн харах ёстой юм байна гэж бодож байгаа. Яг үнэхээр эзнээ олж чадаж байна уу. Зорилтот бүлэгтээ хүрч чадаж байна уу. Ахмад настныг асарч байгаа гэсэн иргэн дотор 302 мянган төгрөгийн тэтгэмж авч байгаа мөртөө яг тухайн ахмад настныг асардаггүй, халамжилдаггүй мөртөө бас ийм тэтгэвэр тэтгэмж авч байгаа ийм бас хэсэг хүмүүс байгаа. Энийг бас би удахгүй тоо хэмжээг нь зарлана. Аймаг сумаар нь зарлана.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд нийгмийн даатгал сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг тус бүр 6 хувиар нэмэгдүүлэх. Энд бол 263 тэрбум төгрөгийг нэмэхээр зарцуулсан байгаа. Нийгмийн даатгалын сангаас 2024 оны 9 сарын байдлаар 420 мянган хүн тэтгэвэр авч байгаа. Сарын тэтгэврийн дундаж хэмжээ 795 мянган төгрөг байна. Фридрих Эбертийн сангаас 2022 онд хийсэн ахмад настны нийгэм, улс төрийн оролцоо судалгаанд ахмад настнуудын 60 орчим хувь нь тэтгэвэр барьцаалсан зээлтэй байгаа нь тэтгэвэр барьцаалсан зээлийг ихэвчлэн сургалтын төлбөр төлөх, байр, автомашин худалдаж авах зэргээр ахмад настан өөртөө биш үр хүүхдэдээ зориулж авч байгаа нь судалгаагаар нотлогдсон. Тэтгэвэр барьцаалсан зээл нь ахмад настны амьжиргааг дэмжих бус эрхийг зөрчих, өрийн дарамтад оруулах, сарын тэтгэврээ банкны зээлийн төлбөрт суутгуулах, гар дээрээ тэтгэвэр авахгүй байх зэрэг нөхцөл байдал бол ахмадуудыг ядууралд өртөх гол нөлөө болж байна гэж бас энэ судалгаагаар гарч байгаа. Ингээд арилжааны банкнууд тэтгэвэр барьцаалсан зээлийг 24 сараар тэтгэврийг 100 хувь барьцаалж олгож байна. Иймд ахмад настны нийгмийн хамгааллын баталгааг хангах хүрээнд тэтгэвэр барьцаалсан зээлийн хугацааг 12 сар болгох, 24 сарыг богиносгоод 12 сар болгох. Ингээд Монголбанкны ерөнхийлөгчийн 2021 оны А277 дугаар тушаалаар батлагдсан өр орлогын харьцааг тогтоох аргачлалд өөрчлөлт оруулах, өр, орлогын харьцааг зохистой хэмжээнд хүргэхээр Монголбанканд ингээд албан ёсны хүсэлтүүдээ хүргүүлсэн байна. Ер нь ахмадын тэтгэвэр барьцаалсан зээлийн асуудал дээр төр ер нь нэг ийм зохицуулалт хийхгүй бол энэ бол маш хүнд асуудал болсон байна. Ер нь бусад улс орнуудад бол ахмадын тэтгэврийг барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн байдаггүй юм байна. Энийг бол хар зээл гэж нэрлэдэг юм байна. Тэгэхээр энэ дээр бид нар бас тодорхой төр анхаарлаа хандуулах ийм цаг үе нь болсон байна. Ийм нөхцөл байдал өнөөдөр Монгол Улсад бас үүссэн байна гэдгийг бас би Байнгын хорооныхоо гишүүдэд бас бүр онцолж хэлье гэж бодож байна.

Монгол Улсын Их Хурлаас Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 оны 6 сарын 5-ны өдөр батлаад, 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлж эхлэх гэж байна. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ахмад настанд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, сэргээн засах үйлчилгээ, хөгжлийн үйлчилгээг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдгээр үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх асуудлуудыг тусгасан. Мөн ахмад настанд тохиолдож байгаа эдийн засгийн хүчирхийлэл буюу тэтгэвэр, тэтгэмжийг зөвшөөрөлгүйгээр зарцуулах, барьцаат зээл авах, өмч хөрөнгийн дур мэдэн зарцуулах, ашиглах зэрэг асуудлыг зохицуулах зорилгоор Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулсан байгаа. Хууль хэрэгжсэнээр ахмад настныг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, хамтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох зэрэг өөрчлөлтийг оруулсан. Түүнчлэн ахмад настны хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээг сайжруулах, насжилтад бэлтгэх, ахмадуудад зориулсан шинэ төрлийн үйлчилгээг бий болгох цогц тогтолцоог бий болгох энэ эрх зүйн орчин нь өнөөдөр энэ хуулиараа нээгдсэн байгаа.

Өнөөдөр Монгол Улсад ахмад настны урт хугацааны тусламж үйлчилгээг ер нь цаашдаа яг ямар хэлбэрээр авч явах нь зүйтэй юм бэ гэдэг асуудлаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын integrated care for older people guidance буюу үнэлгээ

дээр суурилж ахмад настны үнэлгээ дээр суурилж сүүлийн үед кэйс менежмент гэж яриад байгаа юм байна лээ. Энэ кэйс менежмент дээр суурилж яг ахмад настны өөрийнх нь эрэлт хэрэгцээнд нийцсэн ийм үйлчилгээнүүдийг гаргаж ирэх нь зүйтэй юм байна гэсэн ийм зөвлөмжүүдийг бол өгч байгаа юм байна лээ. Одоогийн байгаагаар бол ахмад настны үйлчилгээ, сувилал энийг бол эрүүл мэндийн юугаар бол 5 ангилалд ангилаад байгаа. Энийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Азийн хөгжлийн банкнаас манайд хэрэгжиж байгаа энэ идэвхтэй ахмад настнуудыг дэмжих нийгмийн үйлчилгээний тогтолцоог сайжруулах энэ төслийн хүрээнд бол 3 ангилалд болгох нь зүйтэй юм байна гэсэн ийм зөвлөмжүүд байгаа.

Ингээд ахмад настны бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хам шинжийг IСOPE үнэлгээгээр илрүүлэх, үнэлгээнд суурилан эрүүл насжилтыг дэмжих, настанд тулгуурлаж байгаа асуудлыг шийдвэрлэх цогц үйлчилгээ үзүүлэх ийм зорилготой.

Үндэсний хэмжээнд ахмад настны цогц үнэлгээ хийх шаардлагатай бол кэйс менежментийн үйлчилгээнд хамруулахыг бид нар энэ зорих ёстой юм байна. Нийт 380 мянган ахмадууд маань өнөөдөр яг аль аль ахмадууд маань өнөөдөр яг аль ангилалд байгаа юм бэ. Аль ангилалд байгаа ахмадууд дээр бид нар аль аль эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээнүүдийг ямар хэлбэрээр өгөх ёстой юм бэ. Үүний тарифууд нь ямар байх ёстой юм бэ. Энэ үйлчилгээг бид нар хэн үйлчлүүлэх ёстой юм бэ гэсэн ийм тогтолцооны асуудал дээр бол нэлээн тийм том шинэчлэл хийх ийм зайлшгүй шаардлага өнөөдөр үүссэн байна гэж гарч байгаа юм.

Ингээд ахмад настны эмч нарыг уг нь ажиллуулах ёстой хуулиараа. Тэгээд ахмад настны эмч нар байдаггүй олон дүүрэг, аймгууд байдаг. Энэ дээр бид нар ирэх жил ер нь ингэж зовлон тоочиж сууж байхаар нэг тодорхой бодитой ажил энэ Хөдөлмөр эрхлэлтийн сангаасаа ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд тэтгэвэрт гараад 1 жил болсон эмч нараас энэ гринтологийн эмчгүй байгаа ахмад настны эмчгүй байгаа 7 дүүрэг, 12 аймагт ажиллуулах энэ туршилтын төслийг ер нь эхлүүлэе. Үүгээрээ цаашдаа дамжаад бид нар ахмад настныхаа ер нь цогц үйлчилгээг хийлгэх энэ тогтолцооны эхний алхмуудыг хийе гэж бас үзэж байгаа. Түрүүний миний дурдсан ахмад настны 3 түвшинд үнэлэх үндэсний кэйс менежментийн бас энэ туршилтын төслүүдийг бас ер нь эхлэх нь зүйтэй юм байна гэж бодож байгаа.

Ингээд ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг одоогийн байдлаар бол нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн гэж 2 ангилж тус тус Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мөн Эрүүл мэндийн сайдын тушаалаар бас ингэж хамтарч бас энэ тусламж, үйлчилгээг хүргэдэг. Энэ дээр би түрүүн хэлсэн нэмэлт хийсэн мэдээлэл дээр бид нар Азийн хөгжлийн банкнаас хэрэгжиж байгаа энэ төсөл их тийм сайн төсөл байгаа юм. Энэ дээр би бас Ариунзаяа сайддаа бас таларх ёстой. Ариунзаяа сайдыг сайд байх үед бас энэ хэлэлцээрүүд эхэлсэн. Ингээд өнөөдөр энэ Сонгинохайрхан дүүрэгт байгаа 1 хэлбэр. Энэ бол хувийн хэвшил ахмадуудад өдрийн үйлчилгээ, шаардлагатай байгаа сувилал энэ үйлчилгээг үзүүлбэл яг ямар хэлбэрээр үзүүлж байгаа юм гэдэг нэг ийм туршилтын төсөл. Нөгөөдөх нь Дархан-Уул аймагт ахмадын хөгжлийн төвөөрөө дамжиж, энэ үйлчилгээг үзүүлбэл яг ямархуу хэлбэрээр байна гэдэг маш сайн жишиг төсөл. 3 дахь нь бол Сэлэнгэ аймгийн Мандал сумд сумынхаа Эрүүл мэндийн төвөөр

дамжиж энэ ахмадын тусламж үйлчилгээг үзүүлбэл ямархуу Монголын хөрсөнд буухаар хувилбар байх вэ гэдэг энэ 3 хувилбаруудыг хэрэгжсэн хамгийн сайн төсөл байгаа. Энэ төслүүд дээр манай Энхтуяа гишүүн Их Хурлын гишүүд бас очиж танилцсан. Цаашдаа бид нар 2025 онд энэ төслүүдээ улам эрчимжүүлж, аймаг бүхэнд энэ үндэсний тогтолцоог бий болгох чиглэл рүү бас нэлээн бодлогын хүрээнд дэмжиж ажиллая гэсэн ийм бодолтой байна. Тэгээд мөн Азийн хөгжлийн банкны 2 дахь шатын бид нар хэлэлцээрүүдийг эхлүүлсэн. Энэ 2 дахь шатын хэлэлцээр дээр ямар ч байсан 6 бүсийн төвүүд дээр энэ ахмадынхаа жишиг төвүүдийг байгуулаад, цаашдаа төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ ахмадын асаргааны төв биш, яг ахмадын сувилал эрүүл идэвхтэй амьдрахад шаардлагатай байгаа өдөр тутамд ахмадуудын эрэлт хэрэгцээнд суурилсан ийм үндэсний ахмадыг дэмжсэн үйлчилгээг бий болгох энэ ажлуудыг бас эхлүүлэе гэж бас бодож байна.

Тэгээд нийт ер нь ахмадуудынхаа бас юуг тоолж үзлээ. Энэ ахмад нэртэй ордон, танхим 500 гаруй байдаг юм байна. Улсын хэмжээнд. Маш их том тоо. Тэгсэн мөртөө үндсэндээ яг үүгээр ингээд байнга ийм арга хэмжээнүүд нь тогтвортой үйл ажиллагаанууд нь явдаг уу, явдаггүй юу, алинаар санхүүжүүлдэг вэ гээд их тийм алаг цог болчихсон юм байна. Тийм учраас бол зарим асрамжийн үйлчилгээний тухайд улсын хэмжээнд 2024 оны байдлаар 12 асрамжийн газар байгаа юм. Үүний 12-ынх нь Батсүмбэрийн асрамжийн газар, аймаг, бүс, нутгийн түвшний 7, хувийн хэвшлийн 4 асрамжийн газар ажиллаж, эдгээрт 484 асруулагч асруулж байна гэж байгаа юм. Тэгэхдээ бид нар бол цаашдаа яг энэ хүнд хэлбэрийн асрах хүнгүй болчихсон хүмүүсийг мэдээж төр асраад асрамжийнхаа үйлчилгээг үзүүлээд явна. Гэхдээ өнөөдөр нөгөө миний түрүүний хэлсэн 500 орчим ахмад нэртэй байгаа энэ төвүүдийг бид нар ерөнхийдөө энэ ахмадуудын хүсэж байгаа тэр нийгмийн үйлчилгээнүүдийг бий болгох чиглэл рүү ер нь үйл ажиллагаануудыг нь тогтвортой болгох чиглэл рүү ийм ажлуудыг хийе. Энэ дээр бол ахмад настны эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэсэн гэрээр, гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар байнга асрах үйлчилгээ төрийн байгууллагын иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар дамжуулан гүйцэтгэх зэрэг энэ ажлуудыг бас ирэх жилээс бид нар туршилтын байдлаар хийе гэж бодож байгаа. Энэ хүрээнд бид нар 2025 онд нийгмийн халамжийн сангаас бол нийт 3500 орчим ахмадууд 3,3 тэрбум төгрөгөөр бас энэ тусламж үйлчилгээг хийе гэсэн бас нэг ийм урьдчилсан байдлаар ийм төлөвлөгөөнүүд хийж байна.

Ингээд бид нарт бас том боломжууд нээгдэж байгаа. Ямар боломжууд нээгдэж байгаа вэ гэхээр ААНОАТ-ын хууль хэрэгжиж эхэлсэн. Энэ шинэ хуулиар бол орлогын 1 хүртэл хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээр эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохируулсан тохируулгад орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулж ашиглах ийм хөрөнгө оруулалтуудыг хийсэн хувийн хэвшлүүдэд бол орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс татвараас хөнгөлөгдөнө. Тийм учраас бид нар бас Худалдаа аж үйлдвэрийн танхим, Татварын ерөнхий газар дээр бас бид нар томоохон аж ахуйн нэгжүүдтэй бас уулзалт хийж, ер нь аймаг дүүргүүд дээр та бүхэн бас энэ ахмад настны хөгжлийн төв, ахмад настанд үзүүлэх энэ асаргаа сувилгаануудын үндэсний тогтолцоог бий болгох чиглэл рүү бас энэ хөрөнгө оруулалтуудыг хийгээч гэсэн анхныхаа саналуудыг хүргүүлсэн. Маш их нааштай байгаа. Тэгээд цаашдаа бол ер нь төр өөрөө хийгээд явахгүй. Төр хувийн хэвшлийн түншлэлээр ахмад настныхаа үйлчилгээнийхээ төвүүдийг бий болгох нь зүйтэй юм байн гэж харж байгаа. Ингээд

ямар ч байсан нийт энэ ахмадуудынхаа төвүүдийн тооллогуудыг хийлээ. Газрууд нь маш их алдагдсан байдаг юм байна. Газрын тооллогуудыг нь бас хийлээ. Ингээд 11 нь орон нутгийн өмчит, 7 нь төрийн өмчийн байрлалтай байна. Яг энэ асуудлуудыг цаашаа ер нь аль нь яг шууд төрийн өмч юм, аль нь орон нутгийн өмчтэй байх юм. Ингээд төр орон нутагт нь яг ямар ямар үүрэг хариуцлагууд хүлээгээд явах юм бэ гэдгээ бас нэлээн ойлгомжтой тодорхой болгоё гэсэн байдлаар бас тодорхой шаардагдах хууль, эрх зүйн журмуудын өөрчлөлтүүдийг бас хийж байгаа гэдгийг бас би онцолж хэлье гэж бодож байна.

Ингээд сэргээн засах үйлчилгээг сайжруулах чиглэлээр Эрүүл мэндийн яамтайгаа хамтарч ажиллахаар бас хэд хэдэн удаагийн уулзалтууд хийгээд, хамтын ажиллагааныхаа замын зураглалуудыг бас зурж байна. Ингээд ахмад настан магадлан итгэмжлэгдсэн 17 орчим рашаан сувилалд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр бол сувилуулдаг байсан бол шинэ хуулиар байгалийн рашаангүй ч магадлан магадлан итгэмжлэгдсэн бүх сувилалд 60 орчим сувилалд хөнгөлөлттэй үнээр сувилуулах ийм боломжууд бас нээгдсэн. Ингээд бид нар бас аялал жуулчлалын компаниудтай бас тодорхой мэдээллүүд солилцож байна. Өвлийн аялал жуулчлалын хүрээнд өвөл байдаггүй, ашиглалт муутай байдаг энэ аялал жуулчлалын байгууллагуудын кемпүүд дээр бас ахмадуудыг өвөл эрүүл агаарт гаргах чиглэлээр хөнгөлөлттэй үнээр амарч цуглуулах бас ийм боломжуудыг бас хайя гэсэн чиглэлээр бас яриа хэлцлүүдийг бас хийж байгаа. Яг үнэнийг хэлэхэд бол өнөөдрийн явж байгаа 50 хувийн хөнгөлөлтөөр сувилалд байгаа энэ хөнгөлөлтийг бол боломжтой ахмадууд л хүртдэг юм байна лээ. Үр хүүхдүүд нь боломжтой. Тэгээд зун нь, өвөл нь ингээд сувилалд дамжаад явдаг ийм ахмадууд гарсан байна. Тэгэхдээ сайн. Би энийг буруутгахгүй байгаа. Гэхдээ яг энэ хөнгөлөлттэй энэ уг нь хөнгөлөлт бол яг нөгөө зорилтот бүлэг буюу амьжиргааны доод түвшнээс байгаа, асрах сувилал хүнгүй ахмадууд хүртэх ёстой хөнгөлөлтийг илүү боломжтой ахмадууд нь хүртээд байна л гэж ойлгож болно. Энэ дээр бас жаахан өөрчлөлтүүд хийх ёстой юм байна гэж харж байгаа.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хуульд дараах заалтуудыг тусгасан. Ахмад настныг авч ажиллуулж байгаа байгууллага ахмад настан өөрөөр хүсвэл тэтгэврийн даатгалын шимтгэлийн 8,5 хувийг төлөхгүй байх, 50 ба түүнээс дээш ажилтантай байгууллага 1 ахмад настныг авч ажиллуулах, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төсвийг нэмэгдүүлэх, тэтгэвэрт гарсан багш, эмч нарыг өөрийн хүсэлтээр үргэлжлүүлэн ажиллахыг дэмжих холбогдох Засгийн газрын гишүүд хамтран ажиллах энэ төлөвлөгөө баталж хэрэгжүүлэхээр бас хуулиар ийм үүрэг хүлээсэн байгаа. Энийгээ бас удахгүй бид нар батална.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2023 онд нийт 2250 ахмад настанд 5,4 тэрбум төгрөг зарцуулж, үүнээс 4 тэрбум төгрөгийн бас зээл олгосон байна. Энэ зардлыг бид нар 1,5-2 дахин нэмэгдүүлж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2025 онд төсөвт 1211 ахмад настанд 9,7 тэрбум төгрөгийн зээл, 1321 хүнд 6,4 төгрөгийн зөвлөх үйлчилгээнд зарцуулахаар бас төлөвлөсөн. Ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор 2012 оны Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгад аж ахуйн нэгж, байгууллага төсөв, үйл ажиллагааныхаа орлогоос цалингийн нийт сангийн 3 хүртэл хувиар бодож мөнгөн хөрөнгөөр ахмадын сан бүрдүүлнэ гэж заасан байгаа. Ингээд одоогийн байдлаар улсын

хэмжээнд бол яг ахмадынхаа санг байгуулаад явж байгаа. Нийт 4737 аж ахуйн нэгж байна.

Ингээд Ахмадын сан цалингийн 3 хувиар байгуулах энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа тул үйл ажиллагааны орлогоос гэсэн байсныг Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвтөө, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн сангийн нийт 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөөр ахмадын сан байгуулахаар ийм бас өөрчлөлтүүдийг хийж өгсөн. Ингээд энэ өөрчлөлтүүд хийсэн учраас өнөөдөр манай яамнаас ахмадын холбоотой хамтраад Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Ахмадын сан байгуулах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулаад байна. Ирэх 7 хоногийн Засгийн газрын хурлаар бараг орчих болов уу гэж бодож байна. Энэ журам маань ингээд батлагдчих бол 1 сарын 1-ээс Ахмадын сан маань байгуулагдаад явчих, нөгөө ахмадын сан байгуулсан байгууллагууд дээр аудит очоод аудит тавиад байхгүй шиг нэг ийм шинэ эрлүүдийг хайж байгаа.

Тэгээд Ариунзаяа гишүүн маань бас он гараад энэ Төсвийн байнгын хороо дээр байх нөгөө аудитын нийцлийн аудит бас хийлгэе гэсэн төлөвлөгөө дээр би оруулсан гэж ойлгосон тийм үү Ариунзаяа сайд аа. Ингээд ирэх 1 дүгээр улиралд бол бид нар Аудитынхаа ерөнхий газартай Ахмадын сан байгуулаагүй байгаа төрийн байгууллагууд дээр нийцлийн аудит хийх нь зүйтэй болов уу гэж бас ийм ажлыг бас төлөвлөж байна.

Өрх иргэдийг орон сууцжуулах арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан Үндэсний баялгийн сангийн хуулиар хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэхээр заасан байгаа. Ингээд энэ хүрээндээ бид нар үндсэндээ цаашдаа Үндэсний орон сууцжуулалтын хороо бас байгуулагдсан. Ерөнхий сайдаар байгуулагдсан хороо байгуулагдсан. Хорооны дэд даргаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд ажиллаж, бусад сайд нар энэ хороо дээр ажиллах болсон гол асуудал бол энэ ипотекийн зээлийн хүртээмжийг зорилтот бүлгүүд рүү хүргэх энэ үндэсний тогтолцоогоо хийх нь зүйтэй юм байна. Орлогод нийцсэн орон сууцуудын хэрэгжүүлэх ёстой юм байна гэдэг ийм хувилбарууд дээр бас бид нар ажиллаж байна. Энэ хүрээндээ бид нар ахмадуудад чиглэсэн ахмадуудын түрээсийн орон сууцын хэлбэрүүдийг гаргаж ирэх бас ийм боломжуудыг, ийм хувилбаруудыг, бас ийм тооцоо судалгаануудыг бас хийж байгаа гэдгийг бас би энэ ташрамд бас нэмэлт мэдээлэл болгоод хэлчихье гэж бодож байна.

Ингээд Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цаашид ахмад настанд чиглэсэн нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа.

2025 оноос хэрэгжүүлж эхлэх Ахмад настны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор Засгийн газрын тогтоолоор өмнө нь батлагдсан дүрэм журмыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулан санал авч, ирэх 7 хоногт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.



Ахмад настны тухай хуулийн өөрчлөлтийг сурталчлах ажлыг зохион байгуулж, Монголын ахмадын холбоотой хамтран ажиллаж бүсчилсэн сургалтыг 11 сарын 11-15-ны өдрүүдэд орон даяар зохион байгуулсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яамтай хамтран ажиллаж, холбогдох журам заавар, үнэ тарифыг бас батлахаар ажиллаж байна.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудтай татварын шинэ хуулийн зохицуулалтын хүрээнд хамтран ажиллах хэлэлцээрүүдийг бас бид нар эхлүүлж байгаа. Эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих цогц төвүүдийг байгуулах чиглэлээр олон улсын байгууллагуудтай бас бид нар хамтарч ажиллана. Би бас энэ дээр Азийн хөгжлийн банкны төслийг бас дурдахыг хүсэж байна.

Асаргааны хувилбарт үйлчилгээ, асрахуйн эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ. Ингээд эцэст нь бол миний түр түрүүний өгсөн ахмадын нэртэй байгаа үйлчилгээ сувилал үйлчилгээний газруудын энэ үйл ажиллагааг тогтвортой авч явах ийм шийдлүүдийг бас ирэх оноос хийж эхэлнэ гэсэн ийм бодолтойгоор бид нар ажлаа төлөвлөж байна.

Анхаарал тавьсан эрхэм Байнгын хорооныхоо гишүүдэд баярлалаа.

**Л.Энхнасан:** Танилцуулга хийсэн сайддаа нэлээн дэлгэрэнгүй сайхан танилцуулга хийлээ. Гишүүд асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Мөнхтуяа гишүүн. Бүгд орлоо. Булгантуяа гишүүнээр тасалъя. Энэ дэлгэц дээр гарахгүй байна. Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу.

**А.Ариунзаяа:** Ирцээрээ хамгийн түрүүнд ирсэн болохоор тэгээд хамгийн түрүүнд асуулт асууж байх шиг байна. Энх-Амгалан сайд миний юу асуух гэж байгааг ер нь бол мэднэ дээ. Тэгээд би өөрөө сайд нь байсан учраас хамаагүй бас асуулт асууж болохгүй байгаад байдаг. Нөгөө өөрөө байхдаа хийж байхгүй яасан юм гэдэг асуудал болчих гээд байдаг. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болж өөрчлөгдсөн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маань өөрөө ахмадын сангаа байгуулсан уу гэдэг 1 дүгээр асуудал.

2 дахь нь болохоор Ахмадын сан байгуулахад төсөвт уг нь бол суулгах ёстой. Сая 2025 оны төсөвт орж ирээгүй байсныг би чуулган дээр ч асуулт асуугаад энийгээ зохицуулаарай гэдэг байдлаар Сангийн сайдын цалингийн сангийн хэмнэлтээс Ахмадын сангаа байгуулах хэрэгтэй гэдэг энэ саналыг хэрэгжүүлэхийн тулд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ахмадын сан байгуулах журмыг шинэчлэх хэрэгцээ шаардлагатай байна гэдгийг бол хэлсэн. Тэгэхээр энэ журмаа ойрын хугацаанд та хэзээ оруулах вэ. Энийгээ бас энэ дээр ажиллаж байна уу. Төр бол өөрөө энэ баталж байгаа хуулиа хэрэгжүүлдэг байх гол үүрэгтэй гэж би үздэг. Тэгээд ахмадын сангийн талаар бол 2017 оноос хойш ахмадын холбоо байнга хэлж байна. Ахмадын сан байгуулагдахгүй байна гэдгийг бол хэлдэг. Тэгээд маш олон ахмадын асуудлыг байгууллага бүр өөрийнхөө, өөрөөс нь тэтгэвэрт гарсан ахмадууддаа анхаарчих юм бол төрийн ачаалал ч гэсэн тэр хэрээр уг нь бол багасах юм байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр 1 дүгээрт нийцлийн аудитын сэдвийг Нийгмийн бодлогын байнгын хороогоор Нийцлийн аудитын сэдэвт оруулъя гэдэг саналыг хураалгаж өгөхийг Энхнасан даргаас бас хүсэж

байна. Байнгын хорооны саналаар Төсвийн байнгын хороо дээр ирэх оны нийцлийн аудитын сэдэвт яг энэ төсөвт байгууллагууд ахмадын сан байгуулсан уу, үгүй юү гэдгийг шалгуулах боломжтой юм байна лээ. Би хувь гишүүнийхээ албан тоотыг явуулсан. Гэхдээ Нийгмийн бодлогын байнгын хорооны шийдвэрээр байвал их зөв юм байна лээ. Энийг бас санал хураалгаж өгөөч гэдэг хүсэлт байна.

Тэгээд журмын талаар асуухаас гадна Энх-Амгалан сайд аа энэ тэтгэврийн нас нь ойртсон байгаа төрийн албан хаагчдыг хамгаалах чиглэлээр ямар боломжууд байна вэ гэдэг дээр бас нэг харж үзэхгүй бол бид Хөдөлмөрийн хууль дээр ажил олгогчийн санаачилгаар тэтгэвэрт нь гаргаж болохгүй гэсэн хамгаалалт хийсэн боловч яг энэ улс төрийн шахалтаар тэтгэврээ тогтоолгохоос нь өмнө ажлаас нь гаргах, халах асуудал маш их байна. Насаараа ажиллачхаад 36 сарын тэтгэмжээ авч чадахгүйгээр хохирч байгаа маш олон төрийн албан хаагч байна. Энэ дээр төр өөрөө бас анхаарахгүй бол маш тийм хүнлэг бус шийдвэрүүдийг шийдвэр гаргагчид өөрсдөө .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайд хариулах уу.

**Л.Энх-Амгалан:** Манай Их Хурал чинь харин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хийж байсан 3 хүн маань гишүүн болсон. Номтойбаяр сайд, Булгантуяа сайд, Ариунзаяа сайд. Манай дэд сайд д байсан Зулпхар маань Улсын Их Хурлын гишүүн болсон учраас ер нь бол Улсын Их Хурлын Байнгын хороо дээр бол манай салбарын өмнө нь хийж хэрэгжүүлсэн, цаашдаа хийж хэрэгжүүлэх гэж байгаа асуудал дээр бол гишүүдэд илүү их тийм дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг тайлбарладагт би бас гүнээ талархаж байна. Энэ 4-төө тийм ээ.

Ахмадын сан дээр бол яг үнэхээр бидэнд нэг ийм гацаанд орчихсон байсан шүү дээ. Ямар ч шийдэл байхгүй болчихсон байсан. Ямар ч байсан ингээд Сангийн яам маань цаашаа харчихсан. Аудит нь бас тодорхой ахмадын сан байгуулсан зарим нэг юман дээр нь очоод аудит тавьчихдаг. Үүнээсээ болоод нэг ийм сайхан шалтагтай болсон байгууллагууд. Аудит тавьчихдаг гээд. Үүнээс болоод энэ ахмадын сан байгуулах ажил маань олон жил ужгирч шийдэгдээгүй ийм байсан. Одоо бол ямар ч байсан энэ ахмад настны тухай хуулиар ахмадын санг хэрхэн яаж байгуулах вэ гэдэг асуудал бол бас өмнөх хуулиасаа бодвол бас их ойлгомжтой болсон байгаа.

2 дахь асуудал бол журмын асуудал байгаа юм. Энэ зарим журам бол хуулиас давчихсан журмуудтай болчихсон хүмүүс шүү дээ бид нар чинь. Хууль дээр цагаан дээр хараар биччихсэн юмыг хэрэгжүүлэхдээ журмаар хэрэгжүүлнэ гээд, журмыг нь болохоор Сангийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нь баталж гаргана гээд. Тэгээд нөгөө Сангийн сайд нь ч гэдэг юм уу, салбар дундын зохицуулалтууд нэлээн тийм шаардагддаг учраас энэ дээр нэг тийм ойлгомжтой юунд хүрч чадаагүй байсан. Энэ журам дээр бид нар хамтарч суугаад, журмаа шинэчлээд, удахгүй Засгийн газар дээр энэ журмаа батлах гэж байна. Энэ журамд бол аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн байгууллагын ахмад настны тоо, цаашид нэмэгдэх ахмад настны тоо зэргээс хамааран ахмадын санг цалингийн сангийн хэдэн хувиар тогтоох асуудлыг 2 жилд 1 удаа байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлтэй хэлэлцэн тогтоох гэсэн бас ийм саналыг энэ энэ журам дээр бас оруулж байгаа. Ингэхээр энэ бол илүү их ойлгомжтой болох болов уу гэсэн ийм бодолтой бас байна. Ахмадын сан цалингийн 3 хувиар байгуулах энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа тул үйл ажиллагааны

орлогоос гэсэн байсныг төсвийн байгууллага тухайн жилийн төсөвтөө аж ахуй нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр ахмадын сан байгуулна гээд өмнөх хуулийн заалтуудыг бодвол илүү их тийм ойлгомжтой ийм заалтууд бас орчихсон байгаа шүү гэдгийг бас би 1 дүгээрт онцолж хэлье гэж бодож байна.

2 дугаарт бол энэ тэтгэврийн насандаа хүрчихсэн байгаа мөртөө ахмадуудыг уг нь Хөдөлмөрийн хуулиар бол өөрийнхөө хүсэлтээр л сонгох ёстой шүү дээ. Тэгэхээр мэдээж юу гэдэг юм. Энэ улс төрийн сонгуулийн дараа, орон нутгийн сонгуулийн дараа бас энэ төрийн албанд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албанд ажиллаж байгаа энэ хүмүүс дээр ийм шахалт дарамтууд үзүүлдэг. Хүний эрх нь зөрчигддөг энэ асуудал бас түгээмэл байна. Би бол тантай санал нэг байна. Тэгэхээр энийгээ цаашдаа бид нар хүний эрхийг хамгаалах хөдөлмөрийн хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлууд дээр бол мэдээж манай яам онцгойлон анхаарах ёстой. Энэ дээр бол би Төрийн албаны зөвлөл, Хэрэг эрхлэх газартай хамтарч удахгүй бас мэдээлэл, хяналт шинжилгээ, мониторингийн үйл ажиллагаагаа идэвхжүүлнэ. Бас шинээр хяналтын байгууллагын чиг үүрэг Засгийн газарт бий болсон. Ингээд хяналтынхаа төв байгууллага хамтарч энэ хуулийн хэрэгжилтүүдийг, тэр тусмаа нөгөө түрүүний миний хэлсэн 50 хүртэлх ажилтантай аж ахуйн нэгжүүд 2 хүртэлх хувь ахмад ажилтан ажиллуулна гэсэн хэрэгждэггүй энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх тал дээр бас нэлээн ажлууд бас төлөвлөж байгаа гэдгийг онцолж хэлье гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Ариунзаяа гишүүн тодруулъя.

**А.Ариунзаяа:** Энх-Амгалан сайд аа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ахмадын сангаа байгуулсан уу гэдэг асуултад хариулж өгнө үү.

2 дахь нь болохоор тэтгэврийн нас нь болчихсон хүмүүсийг шахаж гаргах нь яах вэ. Тэтгэврийн нас нь 2-ын хооронд хэдхэн сар, бараг ганцхан сар үлдчихсэн байгаа хүмүүсийг ажлаас нь халж байгаа асуудал бол үнэхээрийн харамсалтай. Эдгээр хүмүүсийг хамгаалж байгаа байгууллага байхгүй байна. Тэгээд л улс төр юм гэж бодоод л тэгээд л зарим нь бол чимээгүй явдаг. Зарим нь тэгээд л бүх насаараа ажилласан тэр 36 хүртэлх сарын тэтгэмжээ авч чадахгүй хохироод явж байгаа хүмүүс байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ шийдвэрийг гаргаж байгаа тэр байгууллагын удирдлага бол үнэхээрийн хүнлэг бус байна. Тэгэхээр энэ тал дээр яаж хамгаалж болох вэ гэж л асуугаад байгаа юм. Тэгээд энэ дээр бас анхаарах, тоон мэдээлэл бас гаргаж байх хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

**Л.Энхнасан:** Сайд хариултаа өгнө үү. Яаманд сан байгаа юу, байхгүй.

**Л.Энх-Амгалан:** Яаманд харин ахмадын сан Батжаргал дарга энэ дээр хариулчих уу. Манай яам ахмадын сангаа байгуулсан юм уу. Байгуулаагүй бол яагаад байгуулаагүй байгаа билээ.

**Л.Энхнасан:** Батжаргал даргын микрофоныг өгнө үү. 1 дүгээр микрофон.

**Б.Батжаргал:** Ариунзаяа сайдын асуултад хариулъя. Сангийн яамнаас 10 сард бүх төрийн байгууллагуудад чиглэл өгөөд, цалингийн сангийн хэмнэлттэй байгаа тохиолдолд ахмадын санг байгуулж болно гэсэн ийм чиглэл өгсөн байгаа.

Тэгээд манай яамны хувьд 11 сарын гүйцэтгэлээ харж байгаад 12 сард ахмадын санг тодорхой хувиар байгуулж эхлэхээр ажиллаж байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Ариунзаяа гишүүн тодруулга авъя гэж байна.

**А.Ариунзаяа:** Төрийн албаны цалингийн сангийн гүйцэтгэлийг аваад үзэхээр ер нь бол 95 хувьтай байгаад байдаг. Тэгэхээр байгууллагууд дээр хэмнэгдсэн цалингийн сангийн хөрөнгө бол байгаад байгаа юм. Тэгэхээр цалингийн сангийн хэмнэлтээр ахмадын сангаа байгуулаач гэдэг энэ Сангийн яамны саналыг журамдаа тусгаж өгч, аудитын байгууллагаас зөрчилтэйд тооцдоггүй байх талаар яам маань анхаарч шуурхай журмаа оруулж шинэчлээч гэдэг л ийм хүсэлттэй байна. Ирэх жилийн хувьд бид нар одоо ингэж ярьж байгаа юм чинь ирэх жилийн хувьд аудит хийгдээд ямар нэгэн ахмадын сан байгуулаагүй байна гэдэг дүгнэлт гарах юм бол хуулиараа олгогдсон хариуцлагын арга хэмжээнүүдийг ч гэсэн санал болгох, шаардах ийм ажлыг Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд бас хийх хэрэгцээ шаардлага байгаа байх гэж бодож байна.

36 сарын тэтгэмжтэй холбоотой хүмүүс их асуугаад байдаг. Энийг болих гээд байна уу гэсэн асуулт их байгаад байдаг юм. Энэ тал дээр Энх-Амгалан сайд 36 сарын тэтгэмжтэй холбоотой мэдээ мэдээллийг өгөхгүй юу.

**Л.Энхнасан:** Сайд хариултаа өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Хариуцлагатайгаар хэлье. Төрийн албанд, төрийн үйлчилгээний албанд ажиллаад, тэтгэвэр тогтоолгохдоо 36 сарын нэмэгдэл авдаг энэ тогтолцоо өнөөдөр хэвээрээ байгаа. 2025 оны улсын төсөвтэй уялдуулж ямар нэгэн байдлаар энэ хэмжээг багасгаж байгаа энэ зарим салбар дээр энэ тэтгэмж байхгүй болж байгаа гэсэн энэ цуу яриа байгаа. Энэ дээр бол би хариуцлагатайгаар сайдын хувьд энэ хариултыг өгье гэж бодож байна. Ер нь цаашдаа бид нар бас тэтгэврийн шинэчлэл хийгдэнэ. Энэ Их Хурлын тэтгэврийн шинэчлэл хийнэ. Цаашдаа бид нар энэ төрийн албан хаагчдын цалин хөлсний тогтолцоо, нийгэм хамгааллын чиглэлээр бас шинэ хууль, эрх зүйн орчныг бид нар бий болгоно. Энэ хүрээндээ бид нар ер нь цаашдаа бас Монгол Улсад төрийн албанд ажиллаж байгаа энэ хүмүүс бол хамгийн чадвартай, хамгийн мэдлэгтэй, хамгийн туршлагатай хүмүүсийг ажиллуулдаг ийм тогтолцоо байх ёстой болов уу гэж бас би бодож байгаа юм. Би та бүхэнд ганцхан жишээ дурдахад үр дүнгийн урамшуулал гэдэг урамшууллыг манай төрийн албан хаагч нар авдаг. Үр дүнгийн урамшуулал. Энэ үр дүнгийн урамшуулал бол уг нь үр дүн гаргасан хүн энэ үр дүнгийн .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайдын нэмэлт цагийг өгье.

**Л.Энх-Амгалан:** Гэтэл харамсалтай нь өнөөдөр үр дүнгийн урамшуулал манай нийт төрийн албан хаагчдын 96 хувь нь үр дүнгийн урамшуулал авдаг юм байна лээ. Үр дүнгээ тооцуулахгүйгээр үр дүнгийн урамшуулал авдаг. Ийм хавтгайрсан урамшуулал хүртэл хавтгайрсан ийм нөхцөл байгаа учраас бид нар ер нь цаашдаа энэ бүтээмж гэж ярих ёстой. Бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоо байх ёстой. Тийм учраас бол төрийн алба бол хамгийн бүтээмжтэй ийм алба байх ёстой. Тэгэхээр цаашдаа бид нар бүтээмжид суурилсан үр дүнд суурилсан цалин хөлс нийгмийн хамгааллын шинэ тогтолцооны эрх зүйн шинэчлэл хийх зайлшгүй шаардлага цаг үеийн шаардлагаас гарч ирж байна.

**Л.Энхнасан:** Нийцлийн аудит хийлгэх хүсэлтийг би Байнгын хорооны даргын хүсэлтээр Үндэсний Аудитын газар луу явуулъя. Энд бол санал авах шаардлагагүй. Тээшийгээ хүсэлтээ явуулчихъя. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хийсэн явдалд баярлалаа. Ер нь бол хэрэгжилт маш хангалтгүй байгаа. Өнөөдөр бид нар хууль, эрх зүйн орчин дээр маш олон өөрчлөлтүүдийг хийж ирсэн. Баахан нэмэлт, өөрчлөлт хийгээд л байдаг, хийгээд л байдаг. Хэрэгжилттэй холбоотой асуудал бол хангалтгүй байна гэж дүгнэж байгаа. Хууль бодлогын хэрэгжилт хангалтгүй байдалтай холбоотой асуудлууд байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуудлууд байна. Нийгмийн хамгааллын үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлууд, боловсролтой холбоотой асуудлууд, олон нийтийн оролцоо, мэдээллийн хүртээмжтэй холбоотой асуудлууд бас нэлээн их хэмжээгээр хөндөгдөж байгаа. Бид нар энэ хууль нь байгаад байдаг.

Гэтэл энэ хэрэгжилт хангалтгүй байгаа байдалтай холбоотой асуудлуудыг ер нь яах вэ. Орон нутаг, манай Хөвсгөл, Булган, Орхон гээд манай тойргийн хувьд бол бас ахмадуудтай бид нар олон удаа уулзаж явж байсан. Энэ эрүүл мэндийн хүртээмжтэй холбоотой асуудал дээр маш сэтгэл дундуур байдаг. Ахмад гээд тодорхой хэмжээнд гавьяаны амралт гэж өөрсдөө ярьдаг. Тэтгэвэрт гарчхангуут ер нь бол ингээд нийгмийн бүх харилцаанаас хаягдаж байгаа. Тэгээд бид нар энийг тодорхой хэмжээнд нь шийдвэрлэж өгөхгүй бол цаашдаа асуудлууд бол даамжирсаар л байна. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудыг бид нар шийдвэрлэхгүй бол болохгүй байна. Яг өнөөдөр ний нуугүй хэлэхэд авч байсан цалингаасаа доод түвшний доогуур хэмжээний тэтгэвэр аваад эхлэхээрээ шууд ядуурлын доод түвшин рүү орж байна шүү дээ. Тэгээд бид нар энийг цаашдаа яаж шийдвэрлэх ёстой юм. Хууль дээр яаж оруулах ёстой юм. Яах вэ, ингээд л тодорхой хэмжээний танилцуулгууд бас хийгдэж л байна л даа. Ямар ч байгууллагад харьяалагддаггүй ахмадуудаа бид нар яах юм. Энэ асуудлуудыг хэзээ шийдвэрлэж дуусах юм. Энийг бид нар нэг талдаа шийдвэрлэмээр байна. Энэ тэтгэврийн оролцоо орлогын баталгааг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлууд хууль дээр байна л даа. 8.3 Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээ хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцын өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ гээд заачихсан ийм заалтууд байна. Энэ нэмэлт тэтгэврийн хуримтлалын тогтолцоог дэмжих бодлого хэрэгтэй байгаад байгаа юм. Энэ хэрэгжиж эхлэх юм уу, хэрэгжиж эхлэхгүй юм уу. Зөвхөн инфляцтай холбох байдлаар нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр олгогддог хэлбэр үргэлжлүүлээд явагдах ёстой юм уу.

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахтай холбоотой асуудал мөн л хуулийн 7 дугаар зүйл дээр ахмад настанд үйлчилгээ үзүүлэх гээд заачихсан байдаг. Энэ ахмадуудад зориулсан нарийн мэргэжлийн оношилгоо, урьдчилан сэргийлэх эмчилгээний хөнгөлөлттэй үйлчилгээг хуульчилж өгмөөр байгаа юм. Энийг хуульчилж өгөхгүйтэй холбогдуулаад зүгээр нэг хуулийн зүйл заалтаар тодорхой хэмжээнд тусгаад өгчихөөр үзүүлнэ л гээд заачихсан. Энэ ерөөсөө хэрэгжихгүй байгаатай холбоотой асуудал. Хэрэгжилтийг үнэлэхээр үнэлгээ нь гарч ирдэггүйтэй холбоотой асуудал. Яагаад гэхээр зүгээр л үйлчилгээ

үзүүлнэ л гээд заачихсан учраас үйлчилгээг үзүүлж байна уу, үзүүлэхгүй байна уу гэдэг дээр л дүгнэлт хийгээд байгаа болохоос биш үйлчилгээ нь .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт 1 минут өгнө үү.

**Б.Бат-Эрдэнэ:** Үйлчилгээг үзүүлж байгаатай холбоотой энэ үнэлгээтэй холбоотой асуудлуудыг бид нар хөндмөөр байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой асуудлуудыг бид нар бас хуульчилж өгмөөр байна. Ахмад настай иргэдийн нас туршлагад нь тохирсон ажилд зуучлах хөтөлбөрийг бид нар хуульчилж өгмөөр байна. Би ингээд хууль гээд яагаад яриад байна гэхээр нөгөө журам чинь өөрөө хэрэгжихгүйтэй холбоотой асуудлууд нөгөө талдаа байгаад байна л даа. Тэгэхээр бид нар хуультай холбоотой асуудал энэ гэр бүл болон нийгмийн оролцоог дэмжихтэй холбоотой асуудлууд. Ялангуяа түрүүн Энх-Амгалан сайд өөрөө хэлсэн. Тэгэхээр бид нар энэ гэр бүлийн эдийн засгийн дарамт, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах тусгай заалтуудыг бас бид нарт хуульд оруулж өгөхгүй бол болохгүй байна л гэж харж байгаа юм.

Цаашдаа бид нар энэ Ахмадын сан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлуудыг хянах механизм эх үүсвэрийг нь хуульд тодорхой хэмжээгээр тусгаж өгөх шаардлагатай байгаад байгаа юм. Түрүүн тэтгэвэр барьцаалсан зээлийг 24 сарыг 12 сар зайлшгүй болгох шаардлагатай байна гэж хэлсэн. Нөгөө үхтэл үр харам гэдэг шиг ахмадууд маань нэг талдаа өөрсдөө л өгч л байгаа байх л даа.

**Л.Энхнасан:** Нэмэлт 1 минутыг өгье.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр энэ тэтгэвэр барьцаалсан зээлийг 24 сарыг 12 сар болгохтой холбоотой асуудал үнэхээр та хэд судалгаа шинжилгээгээ зөв хийсэн юм уу. Энийгээ зөв тооцсон юм уу гэдгийг асуух гэж байгаа юм. Нөгөөдөх нь ахмад настны цогц үйлчилгээ гээд түрүүн Энх-Амгалан сайдын танилцуулга дээр гарсан л даа. Тэгээд энэ ахмад настны цогц үнэлгээ дээр хэдүүлээ амьдралын чанарын үнэлгээгээ хийхгүй юм уу. Энэ амьдралын чанарын үнэлгээтэй холбоотой маш олон асуудлууд хөндөгдөнө шүү дээ. Энийг уг нь хийж байж бид нар тухайн халамж байдаг юм уу, хөдөлмөр эрхлэлт байдаг юм уу, зөв явж байна уу, байндаа тусаж байна уу, үгүй юу гэдэг 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал бол нийгмийн хүртээмжтэй холбоотой асуудлууд энэ дээр давхар хөндөгдөнө шүү дээ. Тэгээд энэ амьдралын чанарын үнэлгээг бид нар энэ ахмад настны цогц үнэлгээ дотор оруулж өгөх боломж байхгүй юу. Энэ чанарын үнэлгээг бид нар хийснээр маш олон бодлого стратеги зөв тодорхойлогдох... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайд асуултад хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Ариунзаяа сайд аа, та өөрөө ахмадын сангаа байгуулсан юм байна. Таны тушаал байна. Тийм учраас манай яам бол ахмадын сангаа таны тушаалаар байгуулагдсан Ахмадын сан байгаа юм байна шүү.

2-т нь Бат-Эрдэнэ гишүүн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гээд хэлж байна. Тэгэхээр аль хуулийг харин хэлээд байгаа юм бол энэ чинь хэрэгжээгүй хууль шүү дээ Бат-Эрдэнэ гишүүн ээ. 1 сарын 1-ээс хэрэгжих гэж байгаа хууль. Тийм учраас хэрэгжээгүй хуулийг хангалтгүй, хэрэгжилт хангалтгүй байна гэж

дүгнэх нь яг ямар юм бол би сайн ойлгохгүй байна. Магадгүй зүгээр өөр хэрэгжиж байгаа хуулийн хэрэгжилтийг хангалтгүй байна гэж таныг хэлж байна гэж би ойлгож байна. Бид нар хууль хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлуудыг хангаж байгаа. Тэгээд энэ хууль маань бол 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлнэ.

2-т нь ер нь бол тантай санал нэг байгаа. Ахмадын чиглэл рүү явуулж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийн асуудлууд, хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд, нийгмийн хамгааллын асуудлууд бол үнэхээр хамгийн сэтгэл түгшээсэн ийм л асуудлууд болж байгаа. Ахмадуудын орлогын асуудлууд. Тэгэхээр энэ бол тогтолцооны асуудал. Ганц Засгийн газар гарч ирээд шийдчих тухай асуудал биш. Энийг бол бид нар тогтолцоогоор нь шинэчилж байж бид нар тэтгэврийн тогтолцооны шинэчлэл ярьж байгаа. Энэ хүрээндээ бол бид нар ахмадын хүмүүс насан туршдаа ажиллаад НДШ-ээ төлөөд, тэгээд тэтгэвэрт гарахдаа ямар ч байсан амьдралд нь хүрэлцэхүйц хэмжээний ийм тэтгэвэртэй болох л ийм л тогтолцоог бид нар сонгох ёстой. Энэ тогтолцоо бол нөгөө олон давхарт тэтгэврийн тогтолцоо гэж нэрлэдэг юм байна лээ.

Тэгээд энэ чиглэл рүү бас би удахгүй Улсын Их Хурал дээр хувийн буюу сайн дурын даатгалын хуулийг өргөн барина. Үүнтэй уялдуулж бид нар ер нь тэтгэврийн олон давхар тогтолцооныхоо шинэчлэлийг хийх, нөгөө миний улсын төсөв батлуулах үеэр яриад байсан нийгмийн даатгалын сан дээр ирсэн улс төрийн шийдвэрээс популист шийдвэрүүдээс гарсан 4,7 их наядын ачаалал алдагдал биш шүү. Энийг бид нар бас зөв нийгэмд тайлбарлахгүй бол нийгмийн даатгалын сан маань 4,7 их наядын алдагдалд орчихсон гэж бас ойлгоод байгаа юм л даа. Энэ алдагдалд ороогүй. Энийг нийгмийн даатгалын сан дээр нэмэлт санхүүгийн ачаалал өгөхүйц хэмжээний ийм улс төрийн популист шийдвэрүүд хуулиуд батлагдсан учраас нэмэлт 4,7 их наядын ачаалал үүссэн юм байна. Цаашдаа энэ ачаалал үүсээд нэмэгдэж байна. Цаашдаа улсын төсөв дээр бас энэ ачаалал бол маш их том ачаалал болох ийм төсөөлөл байгаа шүү гэдгийг бас бид нар хаана хаана зөв ойлгох нь зүйтэй болов уу гэж бодож байгаа.

Манай ахмадуудын хэлж байгаа нэг үг бол бид нар ер нь хүнсээр өлсөөгүй, хүнээр өлсөж байна гэдэг асуудлыг л хэлээд гээд байгаа шүү дээ. Хүнсээр өлсөөгүй хүнээр өлсөж байна. Энэ яг юу гэж хэлээд байна вэ гэхээр ингээд нийгмийн харилцаанд бид нар ормоор байна. Тийм ээ, ингээд нэг тэтгэвэрт гарахаараа яг хуучин шиг зүгээр нэг ач гучаа хараад, эсвэл ингээд нэг ийм цоожтой хаалганы цаана ингээд байж байдаг ийм нийгмийн тогтолцоо байж болохгүй л дээ. Тийм учраас бид нар энэ Ахмад настны тухай хууль өнөөдөр энэ дэлхий нийтээрээ энэ насжилт нэмэгдэж байгаа үед бол ахмад настны чиглэлээр явуулах төрийн бодлого, нийгмийн үйлчилгээнийхээ бодлогыг бид нар тогтолцооны хувьд эргэж харахаас өөр ямар ч арга байхгүй үүнээс өөр сонголт байхгүй болов уу гэж бодож байгаа.

Одоо жишээ нь та ахмадуудын эрүүл мэндийн үйлчилгээний асуудлыг ярьж байна. Өнөөдөр үр дүнд суурилсан санхүүжилтэд эрүүл мэндийн салбар нь шилжчихээр ахмадуудыг үздэг нөгөө эмч нарын тариф нь хамгийн бага тариф юм байна. Ганмаа доктор мэдэж байгаа байх 60 мянга гэнэ үү. Тэгэхээр чинь цагийн 60 мянга гэхээр чинь нөгөө эмч нар нь ахмадууддаа үзэх сонирхолгүй, өндөр төлбөртэй эрүүл мэндийнхээ үйлчилгээг үзүүлээд явах ийм сонирхолтой болчихоод байгаа байхгүй юу гэх мэтчилнээр ингээд бид нар энэ тогтолцооны хувьд харж үзэх энийг зөв тохируулах энэ тохиргоонуудыг хийхгүй бол нэг зүйл хийхээр нөгөө

зүйлээ ингээд үгүйсгэчихдэг, хүртээмжийг нь багасгачихдаг нэг ийм зүйл бас байж болохгүй гэж бас би бодож байна.

Тантай санал нэг байна. Амьдралын чанарын үнэлгээг бид нар цаг алдалгүйгээр хийх ёстой. Ер нь ингэж байж бид нар энэ халамжийн бодлогоо зорилтот бүлэг рүүгээ чиглүүлэх. Энэ бол манай Засгийн газрын гол бодлогуудын нэг байгаа тэг байгаа. Тэгэхээр цаашдаа энэ өрхийн орлогыг тооцоолж байгаа аргачлал ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайдын нэмэлт цагийг өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Өрхийн орлогыг тодорхойлж байгаа энэ аргачлалууд, энэ амьдралын чанарын үнэлгээ гэж таны ярьж байгаа энэ үнэлгээ, энэ Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас бид нарт санал болгож байгаа энэ ахмадуудын яг нөгөө эрүүл, идэвхтэй амьдрах чадвар дээр үнэлсэн энэ насны ангиллууд гэх мэтчилэнгээр ангиллуудыг бид нар бас бий болгож байж. Яг ахмадуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн эрүүл мэндийн цогц үйлчилгээний тогтолцоог л бид нар бий болгох ёстой юм байна гэж харж байна 1 дүгээрт.

2 дугаарт бол тэр тэтгэвэр барьцаалсан зээл бид нар гэнэт нэг өдөр гаргаж ирээд хийчхэж байгаа асуудал биш ээ. Энэ бас өнөөдөр ч бас хийгдчихсэн асуудал биш. Тооцоо судалгаа хийж байна. Ер нь 24 сарыг 12 сар болгох ёстой юм байна. Азийн хөгжлийн банк болон олон бодлогын зөвлөмж өгч байгаа байгууллагууд бас ингэж зөвлөж байгаа. Ер нь бол эцэг эхчүүдийнхээ, өвөө эмээгийнхээ зээлийг аваад амьдардаг. Оюутныхаа сургалтын төлбөрийг төлүүлчихдэг эсвэл машин аваад уначихдаг ийм бас празит бүлэг байж болохгүй шүү дээ.

**Л.Энхнасан:** 1 минут тодруулга.

**Б.Бат-Эрдэнэ:** Өнөөдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал дээр хэлэлцэж байгаа асуудал дээр Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл ирүүлэх таны мэдээллийг сонсохоор заасан байгаа. Би Ахмад настны тухай хууль буюу 2017 оны 1 сарын 26-ны өдрийн таны мэдээлэл хийж байгаа хуультай ч холбоотой асуудлыг л хөндөөд байна гэж ойлгож болно.

Бид нар ялангуяа энэ Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өнөөдөр мэдээлэл сонсож байгаа учраас болж байгаа процесс, хэрэгжихгүй байгаа заалтуудтай холбоотой асуудлууд ярьж байгаа болов уу л гэж ойлгоод байгаа юм.

Тэгээд та өөрөө ч бас түрүүн хэлсэн. 50 ба түүнээс дээш ажилтантай байгууллага 1 ахмад настныг авч ажиллуулах ёстой. Ажиллуулахгүй байна. Ахмадын сангаа ажиллуулахгүй байна. Өнөөдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч гэсэн ахмадын сангаа ажиллуулаагүй л байгаа юм байна. Ингээд санкцгүй болохоор энэ хуулийн хэрэгжилтүүд чинь явахгүй байна л даа. Тэгээд бид нар энэ 50 ба .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайдын микрофоныг өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Тантай санал нэг байна. Энэ өмнө нь хэрэгжиж байсан хуулиудын хэрэгжилт ер нь яагаад хэрэгждэггүй юм бэ? Ер нь Монгол Улсад



байгаа энэ 600, 700 хууль чинь яагаад хэрэгждэггүй юм бэ гэхээр ерөөсөө л хэрэгжүүлэх тэр механизм буюу санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нь тавьж өгдөггүй. Тэрийг хэн хэрэгжүүлэх ёстой вэ гэсэн тэр хүмүүсийг үүрэгжүүлж санхүүгчдийг нь хийж өгдөг учраас л бид нар хууль батлаад л байдаг. Хууль нь хэрэгждэггүй ийм л нэг ийм зовлон Монголын зовлон гэх юм уу. Ийм зовлонтой л болчихоод байгаа ард түмэн шүү дээ. Тэгээд бид нар бол цаашдаа энэ хуулийн хэрэгжилтийг хангах ёстой. Засгийн газар бол хуулийг хэрэгжүүлэх ийм үүрэгтэй. Тэгэхээр ямар ч байсан энэ саяын Ахмад настны шинээр батлагдсан энэ хууль маань бол тодорхой энэ хууль дээр орсон заалтуудыг хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэх ёстой энэ хариуцлагатнуудад бас нэг хариуцлага тооцдог болсон. Зөрчлийн хуулиар хариуцлага тооцдог болсон бас нэг ийм том дэвшил болсон байгаа. Тийм учраас бол ирэх онд бол тал талдаа цөмөөрөө .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Идэрбат гишүүн асуултаа асууна уу.

**Ц.Идэрбат:** Сайдын танилцуулгыг сонслоо. Тэр ахмад настны тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал дээр үнэхээр маш тийм харгис тогтолцоо шүү дээ. Бүхэл бүтэн 2 жил гар дээрээ 1 ч төгрөг авахгүй болтол нь зээл өгдөг ийм юм Монголд л байдаг юм байна шүү дээ. Тэгээд энэ чинь 2018, 2019 оны үед л намайг сумын дарга байхад л явж байсан л ийм л юм. Тухайн үед бол энэ чинь 6 саяын зээл өгөөд 1 саяыг нь банк аваад, 5 саяыг нь гар дээр өгөөд тэгээд л 2 жил юу ч байхгүй. Тэгээд түлэх түлээгүй, даралтын эмээ авах мөнгөгүй ахмадууд маш их байдаг. Тэгэхээр ер нь дэлхийд байхгүй ийм тогтолцоог бид заавал байлгах албатай юу. Үнэхээр өөртөө зориулах тэр санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй болсон тэр тохиолдлыг нь жоохон нээж өгөөд л бусдыг нь бол хаагаад явбал яасан юм бэ гэсэн ийм л бодол байдаг юм шүү дээ. Тэгээд үр хүүхдэдээ тэрийгээ хэлж чадахгүй тэгээд л зайлуул их л хэцүү юм туулдаг юм даа. Тэгэхээр энэ дээр ер нь нэлээн сайн үзэж судалмаар юм билээ. Тэр яах вэ үхтэл үр харам гэж Монгол философи байгаа. Тэр дээрээ тулгуурлаад л яваад байдаг юм байна лээ.

2 дугаарт энэ ахмад настанд очих ёстой мөнгө очихгүй байна. Асаргааны мөнгө янз янзын мөнгөнүүд нь очихгүй байна гэдэг ч бас ер нь ганц асаргаа ч биш, ер нь яах вэ танай яамтай холбоотой Хүүхэд хамгааллын хуулийг яригдаж байх үед хүүхдийн мөнгийг нь авч идчихээд, хүүхдэдээ анхаарал тавьдаггүй, хүүхдээ хаяад явчихдаг эцэг эхчүүд бас их байдаг юм байна лээ шүү.

Сая Сэтгэцийн эрүүл мэндийн төв дээр очиход тэр хүмүүсийн мөнгийг бас группийн мөнгө есэн бусын мөнгийг нь бүгдийг нь авчхаад жилдээ нэг ч эргэж очдоггүй, сэтгэцийн эрүүл мэндийнхэн араас нь гуйгаад байхад ирдэггүй ийм тохиолдлууд бас байдаг юм байна лээ. Тэгэхээр ер нь яг төрөөс олгож байгаа энэ мөнгө зорилтот бүлэгтээ, хүндээ, эзэндээ очиж байгаа эсэх дээр бид бас нэлээн сайн анхаарах ёстой юм болов уу. Энэ дээр ер нь цаашдаа яах юм бэ гэсэн нэг асуулт.

2 дугаарт энэ цалингийн сантай холбоотой асуудал дээр бид хүнд тайлбар тавихад ичмээр шүү дээ. Нэг хууль дээрээ ав гэххээд, нөгөө нэг төрийн байгууллага нь очоод акт тавиад байна гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Ялангуяа орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд бол энийгээ тэгээд 1 сайн муу хийдэг юм шүү дээ. Ялангуяа энэ дээрээсээ томилгоотой, босоо удирдлагатай агентлагууд чинь огт тавьдаггүй. Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар тавиагүй л явж байх жишээтэй. Бид ахмадынхаа энэ мөнгийг шийдээгүй байтал

энэ хүүхэд хамгааллын хууль дээр цалингийн 1 хувьтай холбоотой зардлыг хүүхэд хамгаалал дээрээ тавина гээд бас тусгачихсан байгаа. Тэгэхээр ер нь Үндэсний аудитын газартай энийгээ ер нь нэг цэгцэлчхэж болдоггүй юм уу. Айхтар тийм хэцүү биш юм шиг л санагдах юм. Тэгээд тийм хуульд нь өөрчлөлт оруулах ёстой бол оруулаад ингээд явбал яасан юм бэ гэж.

Сүүлийн асуулт бол энэ ирээдүйн ахмадуудад анхаарах хамаарах асуудал байгаа. Энэ бол нөгөө хувийн нийгмийн даатгалын сангийн хууль дутуу, ажлын хэсэг гараад явж байгаа. Энэ ер нь ямар шатдаа яваа вэ гэсэн ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайд асуултад хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Идэрбат гишүүн маань бол бас сумын Засаг дарга, Аймгийн Засаг даргаар орон нутагт их олон жил ажилласан. Орон нутгийн удирдлагад ажилласан хүн учраас бол үнэхээр энэ орон нутгийн жаргалан зовлонг сайн мэддэг гишүүн л дээ. Тэгээд үнэхээр үнэн шүү дээ. Энэ ахмадууд бол яг л тэр түлээний мөнгөгүй болчихсон. Нөгөө даралтын эмийн мөнгөгүй болчихсон. Хүнсээ л яаж ийж залгуулж байгаад л ийм байна шүү дээ. Одоо манай энэ нийт тэтгэвэр авагчдыг чинь бараг үндсэндээ 57 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байгаа байхгүй юу. 57 хувь нь. 100 хүн нь тэтгэвэр авч байлаа гэхэд 57 нь хамгийн доод хэмжээний тэтгэвэртэй. Тэгсэн мөртөө тэр тэтгэврээ зээлчихдэг. Барьцаалаад зээл авчихдаг. 2 жилийн турш ингээд зээл авчхаад, яах вэ дээ Монголчуудын философи. Бүгд л ярьдаг. Үхтэл үр харам. Гэтэл тэр хүн чинь, тэр ахмадууд чинь амьдрах ёстой шүү дээ. Тэгээд ингээд ахмадуудынхаа тэтгэврээр барьцаалуулж зээл авчхаад байдаг ийм угжны хурга шиг болчихсон ийм үе байж болохгүй шүү дээ. Барьцаалаад машин аваад уначихдаг. Барьцаалаад оюутны зээлүүдээ төлүүлчихдэг. Барьцаалаад мал авчихдаг. Барьцаалаад хурдан морь авчихдаг ийм амьдрал байгаа шүү дээ бид нарын дунд. Тийм учраас дэлхий нийтэд байдаггүй энэ тогтолцоо заавал ч үгүй байлгах гээд энэ банкнууд ер нь мөнгө хүүлж болох бүх л юмаараа мөнгө хүүллээ шүү дээ. Одоо болоо юм биш үү. Тэгээд л ерөөсөө тэгээд бүх юмаар ингээд барьцаалаад бүгдийг нь нөгөө Должингийн таргалсан Дагдангийн турсан 2 тэнцэнэ гэдэг шиг энэ банкнуудын таргалсан, манай ахмадуудын турсан 2 бол яг тэнцэнэ шүү дээ. Өнөөдөр тэтгэврийн зээл яг л ийм хэмжээнд хүрчхээд байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар энэ дээр үнэлэлт дүгнэлт хийхээс өөр арга байхгүй. Төр л юм бол энэ дээр оролцох ёстой гэж би ойлгож байгаа.

2 дугаар асуудал бол тэр нөгөө сан байгуулах асуудал дээр бол ахмадын сан байгуулах асуудал дээр ямар ч байсан дорвитой өөрчлөлт гарсан. Одоо Сангийн яам маань манлайлж ажиллаж байгаа. Сангийн яам маань тийм учраас Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бүх төрийн байгууллагуудад энэ ондоо багтаж Ахмадын сангаа байгуулах чиглэлүүд бас өгсөн байна лээ. Энэ бол маш том дэвшил. Ингээд удахгүй хамтарсан журам Засгийн газраар орж батлагдана. Ингээд ирэх жил манай Байнгын хороо хууль болон журмын хэрэгжилт дээр аудиттайгаа хамтраад ингээд бид нар хяналтаа тавиад явчихвал ямар ч байсан энэ олон жилийн шилний цаанаас мөхөөлдөс долоолгосон энэ Ахмадын сан байгуулагдаж, ахмадууд маань харьяалалгүй түрүүн Бат-Эрдэнэ гишүүн маань бас ярилаа. Харьяалалгүй ахмадуудын асуудлыг хөндлөө. Ямар ч байсан Монгол Улсад 1 ч харьяалалгүй ахмад гэж байж болохгүй. Ер нь харьяалалгүй ахмад гэдэг ойлголт чинь бол маш харгис ойлголт шүү дээ. Тийм учраас бол ахмад бүхэн бүртгэлтэй, ахмад бүхэн өөрийнхөө авах ёстой тэр нийгмийн хамгааллаар

үйлчилгээгээ авах л ёстой гэж би ойлгож байна. Энэ чиглэлээр бол манай яамныхан эх өгөгдлийг боловсруулж байна. Ер нь цаашдаа бид нар энэ халамжийн хуулийг өргөн барина. Мөн тэтгэврийн шинэчлэлийн хуулийг буюу хувийн сайн дурын тэтгэврийн хуулийг удахгүй Улсын Их Хуралд бид нар өргөн барих гэж байна. Энэ хууль өргөн баригдсанаар Монгол Улсад олон давхар тэтгэвэр буюу ирээдүйн ахмадуудыг манай Идэрбат гишүүний ярьж байгаа ирээдүйн ахмадууд маань бол нэг эх үүсвэрээр биш, олон эх үүсвэрээр тэтгэврээ авч амьдралд хүрэлцэхүйц тэтгэвэртэй болох ийм тогтолцоотой болох энэ шинэчлэлийг л цөмөөрөө хамтарч хийе ээ л гэж бодож байгаа.

**Л.Энхнасан:** Идэрбат гишүүн тодруулга.

**Ц.Идэрбат:** Тийм. Миний нөгөө 2 дахь асуулт нь хүүхдийн мөнгийг нь аваад хүүхдэдээ анхаарал халамж тавьдаггүй, ахмадуудынхаа мөнгийг аваад ахмадууддаа анхаарал тавьдаггүй ийм асуудлууд байгаа. Тэгээд энэ дээр ер нь бид цаашдаа яг яамаар юм.

2 дугаарт таны танилцуулга дээр сэтгэцийн өвчтэй ахмадуудын асаргааны газар байгуулна гэсэн зүйл сая танилцуулга дээр бас байна л даа. Тэгэхээр энэ нөгөө СЭМҮТ дээр эмчлэгдэн сувилагдаж, асрагдаж байгаа 240 хэдэн хүний асуудал энэ рүү чиглэж байгаа юу гэдгийг би бас тодруулж асууя. Яагаад гэвэл бүхэл бүтэн үндэсний төвийн үйл ажиллагааг зөвхөн энэ асуудал ингээд л доголдуулчаж байгаа юм байна лээ л дээ. Тэгэхээр төсөв хөрөнгийнх нь асуудал аль шатандаа яваа юм. Зураг хөрөг нь ямар шатандаа яваа юм. Байнгын хорооны тийшээ очсон гишүүд бол энэ дээр онцгой анхааръя гээд байгаа юм. Тэгээд би тодруулж байгаа юм.

**Л.Энхнасан:** Сайдын микрофоныг өгье. Сайд хариултаа өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Ер нь энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч хамгаалж байна гээд тэтгэмж авч байгаа ахмад настнуудыг асарч хамгаалж байна гэж тэтгэвэр тэтгэмж авч байгаа энэ хүмүүсийн тоогоо бид нар сайн болгомоор юм байна лээ. Нягталмаар юм байна лээ. Нөгөө халамж хавтгайрсан гэдэг чинь бол эндээс үүсэж байгаа л асуудал. Саяын бид нар хүнсний талоныг яг жинхэнэ тоолоход тэгээд ямар үр дүн гарав. Үүнтэй л адилхан байхгүй юу. Сая мэргэжлийн боловсролыг бид нар буцааж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд авахад Боловсролын сайдад байхад би буцааж авахад 7200 хүүхэд давхардсан. МСҮТ-д сурдаггүй хүүхдүүд 200 мянган төгрөг авдаг байсан шүү. Яг үүнтэй адилхнаар ерөнхийдөө бид нар Монголын төр л юм бол ерөөсөө энэ их өгөгдлийн тоогоо бид нар нягталмаар юм байна. Их олон жил гүйцэтгэлээр нь ингээд л нэг тоогоо аваад санхүүжүүлээд явчихсан тийм л юм байна лээ. Тийм учраас цаашдаа бид нар энэ төсвийн үр өгөөж .../минут дуусав/

**Л.Энхнасан:** нэмэлт 1 минут өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Төсвийн үр өгөөж халамжид зарж байгаа мөнгөнүүд эзэндээ очиж байгаа үр өгөөжөө өгч байгаа энэ үнэлгээнүүдийг хийж байж үр дүнд суурилсан ийм санхүүжилтүүд явах ёстой юм байна. Үүнээс өөр сонголт байхгүй юм байна л гэж харж байгаа. Удахгүй халамжийн хуулийг Улсын Их Хурал дээр өргөн барина. Энэ дээр нэлээн нээлттэй хэлэлцүүлгүүд хийгдэх болов уу. Энэ

дээр нэлээн олон мэдээллүүд тодорхой болно. Халамж авдаггүй ямар хүмүүс халамж авдаг гэдэг мэдээллүүд тодорхой болно.

2 дахь асуудал бол тэр сэтгэцийн эрүүл мэндийн өвчин зовлонтой байгаа ахмадуудад бид нар бас тодорхой эмчилгээ үйлчилгээг хүргэх. Ганцхан манай яамны асуудал биш л дээ. Эрүүл мэндийн яамтай хамтарч байгаад бас үүний хүртээмжүүдийг чанарыг нэмэгдүүлэх чиглэл рүү байшин барилга гэхээсээ илүү арай нэг тийм үйлчилгээг нь гэрээр гэдэг юм уу, явуулын үйлчилгээнүүд бас бий болгох нь бас зөв хэлбэрүүд юм байна гэж бас ийм хамтарсан ийм үйлчилгээнүүд ярьж байгаа. Байшин барилгын асуудал бид нар одоохондоо яриагүй байна.

**Л.Энхнасан:** Бид бас СЭМҮТ рүү очоод яг нөхцөл байдлыг үзсэн болохоор энэ дээр нэлээн анхаарал тавьж ажиллана уу. Яагаад гэвэл бол тэр 244 хүмүүс бол бүр урт хугацааны турш тэр эмнэлэгт амьдардаг. Гэр нь болчихсон гээд хүмүүс байна лээ. Тэгээд СЭМҮТ-ийн эмнэлэг өөрөө 550 ортой гэхэд 43 хувийг нь бол зөвхөн тэр байнга оршин суудаг тэр өвчтөн бол хамаг орыг нь эзэлчихсэн. Тэгэхээр сайд бас энэ дээр анхаарч ажиллахыг хүсье. Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу.

**С.Эрдэнэбат:** Ахмадуудын талаар хэлэхэд манай нийт ахмадуудын маань 80 хувь нь тэтгэвэр нь дөнгөн данган хүрч ядсан л байдалтай л байгаа. 785 мянган төгрөг гэж. Асаргааны тэтгэмж, тэтгэвэр авч байгаа хүмүүс маань харахад 375 мянга буюу Улаанбаатар хотод Монгол Улсад амьжиргааны баталгаажих доод түвшин нь 420 мянга байгаа. Тэгэхээр өөрөө өөрийнхөө наад захын хэрэгцээг хангаж чадахгүй тэтгэврийг бид нар бас өгч байгаа. Яах вэ, сүүлийн жилүүдэд бас нэмээд дөхөөд, дөхөөд энэ шүү дээ. Хуучин бол бүр бага байсан. Тийм учраас энэ тал дээр бол цаашдаа ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлэх чиглэлээр тэтгэврийн ачаалал гэдэг энэ сангийн ачааллаас болоод бас чаддаггүй ийм асуудлууд байгаа. Насаараа 30, 40 жил ажиллаад ийм бага тэтгэвэр авч байгаа ийм хүмүүс бол дийлэнх нь байдаг.

2 дугаарт энэ гэрээр үйлчлэх үйлчилгээ гэдгийг их сайжруулмаар юм байна лээ. Ахмадуудыг тэр гэрээр нь очиж эм тариаг нь хийж өгдөг, гарч чаддаггүй хөөрхий тэргэнцэртэй хэвтэрт байж байдаг энэ хүмүүст эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тэр хорооны гэдэг юм уу нэг ийм том байшин бариад тэнд ирж ажил гээд байхаас илүүтэйгээр гэрээр нь үйлчилгээ үзүүлэх. Би бас энийг сонирхож үзэж байсан юм. Нийслэл Улаанбаатар байна уу, хотод байна уу, юу байна уу энэ орон сууцын сан гээд нэг юм байгаад байдаг. Ахмадууд энэ талаар их их өргөдөл гаргаад байдаг юм. Заавал тэр олон хүнд бүгдэд нь өгч чадахгүйгээс хойш энэ орон сууцын хотхон эс үгүй бол юу болгонд хамгийн ойрхон тэр хороо дүүрэгт ахмадуудыг тэр чөлөөт цагаа өнгөрөөх, тэр ганцаардлын өвчин гэдэг зүйлийг л маш их ярьдаг юм байна лээ. Би сая 10 сард ахмадуудтай төлөөлөлтэй очоод үйлдвэрчний эвлэлийн голцуу төлөөллийн байгууллагуудын ахмадуудтай уулзахад ахмадууд бол ганцаардлын өвчин маш их байна гэдэг энэ зүйл байгаа.

Тийм учраас бид нар хүн хэрэгтэй байна гээд түрүүн бас хүмүүс хэллээ. Хүнээр өлсөж байна гэж. Энэ боломжуудыг нь бид нар байгаа боломж дээрээ тааруулаад бол хийх нь их чухал байна гэж.

Хоёрдугаарх нь огт ахмадгүй байгууллагууд байна шүү дээ. Хамгийн ахмад настай хүн нь 45-тай тийм олон хэдэн мянган ажилтантай. Тэд нарын цалингийн сангийн 3 хувийг тэгээд юунд зарцуулах юм. Ахмадууд нь байхгүй байгууллагатай

болохоор. Энийг нь давхар хийж өгөхгүй болохоор томоохон групп компаниуд ахмадууд бараг байхгүй шүү дээ. Энэ тал дээр нь бас юу яахгүй бол энэ 3 хувийн ахмадын сангийн асуудал дээр бас ингээд зүйлүүд байгаа юм. Дээрээс нь харьяалалгүй ахмадууд маш олон байдаг юм. 1990 оны хувьчлалаар мянга мянгаараа л хөөрхий харьяалалгүй, байгууллагууд нь дампуураад л өмчийг нь бол тараагаад л дууссан ийм зүйлүүд байдаг. Тэгэхээр харьяалалгүй ахмадууд дээр анхаарал хандуулаад, сая сайд бол сайн тоолъё гэж байна. Энэ бол бас бидний бас хийх ёстой ажлын нэг.

Сувилал гээд нэг зүйлийг бас тавьсан манай ахмадууд маань. 30 мянган төгрөг 1 хүнийг 1 өдөр сувилахад. 30 мянган төгрөгөөр өнөөдөр 1 таваг хоолны л мөнгө шүү дээ. 3 хоолтой сувилалд хэвтүүлнэ гэдэг бол яг үнэндээ бол хуураад л өнгөрөөдөг зүйл байгаа. 10 жил гаруй болсон. Тэгээд сүүлдээ 7 хоног болсон гэж байгаа юм. Нэмэлт 1 минутаа авчихъя.

**Л.Энхнасан:** Сайд асуултад хариулна уу. Нэмэлт үү. Үргэлжлүүлээд Эрдэнэбат гишүүдэд 2 минут.

**С.Эрдэнэбат:** Тэгэхээр энэ ахмадуудыг сувилах энэ мөнгийг яагаад нэмдэггүй юм бэ. Энэ чинь 10 жил боллоо шүү дээ. Килограмм мах бараг 4 мянга, 5 мянга байх үед л 30 мянган төгрөг болгож байсан санаад байх юм. Тэгээд энэ тал дээрээ тавихгүй бол нөгөө сувиллын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд нь энэ мөнгөнд нь тааруулаад 30 мянгаар өдөр 3 хоолтой, тэгээд сувилгаа эмчилгээ гэхээр энэ бол яг үнэндээ сувилал биш болж чадаж байгаа байхгүй юу.

Түрүүн сайд бас хэллээ. Зөв олж харсан байна. Яг нөгөө зорилтот бүлгийн хэсгийн хүмүүс тэр сувиллууд дээр бас очиж үйлчлүүлж чадахгүй бас тохиолдлууд бас байдаг юм гэдгийг бол хэлмээр байна. Дээрээс нь ахмадууд маань энэ Хүүхэд харах үйлчилгээг бол хамгийн их гүйцэтгэдэг хүмүүс шүү дээ. Ач зээгээ хардаг, үр хүүхдүүдийнхээ хүүхдүүдийг хардаг. Тэгээд энэ хүмүүст тэр хүүхэд кэйр үйлчилгээ хийж үзүүлж байгаа, асрахуй эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэх энэ тал дээр бол бас ахмадуудынхаа энэ хувь нэмрийг үнэлэх тал дээр бол анхаарах хэрэгтэй байна гэж. Ахмадын байгууллагууд асар их ахмадуудтай байгууллагуудаа яаж дэмжих вэ. Зарим нь мянган ахмадтай, 2 мянган ахмад .../минут дуусав/

**Л.Энхнасан:** 1 минут нэмж өгнө үү.

**С.Эрдэнэбат:** Сая дутуу өгчихлөө.

**Л.Энхнасан:** Тэгэхээр ийм зүйлүүд дээр бас бид нар анхаармаар байна. Тэгээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бас тэгээд нэмэх гээд зүтгээд байдаг шалтгаан нь юу вэ гэхээр ахмадуудынхаа эрүүл мэндийг даатгаж байна гэхээр бид нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1-2 хувиар даатгадаг юм. Маш багаар. 12, 13 мянган төгрөгөөр. Тэгээд эргээд үйлчилгээ үзүүлье гэхээр тэр сан нь хүрдэггүй. Давхар нэг ийм хүндрэлийн цикл рүү орчихдог учраас энэ тал дээр нь бас бид нар анхаармаар байгаа юм. Тийм учраас энэ ахмадуудын эмчилгээ сувилгаа энэ тэр гэдэг юмыг Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтраад, тэгээд хамгийн ойрхон үйлчилгээг үзүүлж болох түрүүн тэр Ариунзаяа сайд санаачилсан гэх шиг боллоо. Тэр өрхийн эмнэлгүүд болон сумын Эрүүл мэндийн төвүүдтэй нийлүүлж байгаа тэр сувилгаа эмчилгээг нь үзүүлдэг

бас ийм үйлчилгээг ч гэсэн харж үзэх нь бол илүү зохимжтой байж магадгүй гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд ажилладаггүй маш олон сувилал байгууллагуудыг бас дэмжих нь их чухал юм байна лээ. Заавал шинэ байшин барина гэхээсээ илүү хоосон байж байдаг өвөлдөө ажилладаггүй ийм газруудтай хамтраад ажиллаад, ахмадуудаа сувилж дэмжих тал дээр бол .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Би зүгээр нэмээд сая асрамжийн газар ярьсан болохоор тэр нөгөө 2003 онд ажиллаж байсан Асрамжийн газар байсан. Тэр яагаад ер нь хаагдчихсан юм бэ. Сайдын микрофоныг өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Үнэхээр үнэн. Ахмадууд маань насан туршдаа залуу насандаа ажиллаж хөдөлмөрлөчхөөд, шударгаар ажиллаж, хөдөлмөрлөчхөөд, тэгээд ажилласан жил, авсан цалингийнхаа хэмжээтэй уялдуулахад 45 хувиар бага тэтгэвэр тогтоолгоод байдаг ийм тогтолцоотой явж байгаа. Энэ бол өнгөрсөн хугацаанд бид нарын л сонгож авсан ийм тогтолцооны гажуудал гэж хэлж болно. Тэгэхээр ер нь цаашдаа бол энэ тэтгэврийн шинэчлэлийг дэлхий нийтээр ярьж байгаа 3 зарчим л ярьдаг юм байна лээ.

1 дүгээрт нь тэтгэврийн тогтолцоо, тэтгэвэрт тавих, тэтгэвэр тогтоох аргачлал бол шударга байх ёстой. Шударга байх ёстой.

2 дугаарт бол авах гэж байгаа тэтгэвэр нь амьдралд хүрэлцэхүйц байх ёстой

3 дугаарт нь бол энэ тэтгэврийн сан, тэтгэврийн тогтолцоо өөрөө тогтвортой байх ёстой гэсэн ийм 3 зарчим дээр үндэслэж л тэтгэврийн шинэчлэлүүд хийгддэг юм байна лээ. Тийм учраас бол удахгүй бид нар Улсын Их Хурал дээр сайн дурын буюу хувийн тэтгэврийн даатгалын хуулиа өргөн барина. Үүнтэй уялдуулж бид нар тэтгэврийнхээ Монгол Улс олон давхар тэтгэврийн тогтолцоо руу шинэчлэлүүд нь алхам хийхээс өөр ийм сонголт бид нарт байхгүй болсон.

Тэтгэврийн тогтолцоог 2 янзаар зэрэг хийдэг юм байна. Нэг нь бол тогтолцоо, олон давхар тогтолцоог бий болгодог. Нөгөө нь одоо байгаа тэтгэвэр тогтоолгож байгаа насыг нь бодож байгаа. Ажилласан жилийг нь бодож байгаа энэ параметрууд гэж ярьдаг юм байна лээ. Энэ параметруудээ сайжруулах ийм тогтолцоо, шинэчлэлийг зэрэг хийж байж бас тодорхой тэтгэврийн шинэчлэл бас үр дүнд хүрдэг ийм туршлагауд бусад улс оронд байна. Тийм учраас удахгүй бид нар ер нь маш ойрын хугацаанд Улсын Их Хурал дээр Монгол Улс цаашдаа тэтгэврийн ямар тогтолцоотой явах вэ гэдэг энэ сонголт дээр нэлээн ухаанаа уралдуулах хэрэгтэй болов уу гэж бас бодож байна.

2-т нь гэрээр үйлчлэх үйлчилгээ гээд энэ олон нийтийн оролцоонд тулгуурласан энэ үйлчилгээнүүдийг бий болгох ёстой гэж энэ маш зөв. Их сайн санал санаачилгууд их байгаа юм байна лээ. Түрүүн бас Азийн хөгжлийн банкнаас хэрэгжиж эхэлсэн тэр ахмад настанд үзүүлэх цогц үйлчилгээний тогтолцооны жишиг төслүүдийг бас би жишээ болж дурдсан. Яг сумын Эрүүл мэндийн төвөө дагуулаад хийж болж байна. Ахмадын төв өөрөө дангаараа хийж болж байна. Хувийн хэвшил өөрөө бас энийг хийж болж байна гэсэн ийм олон хэвшлүүд ийм олон хувилбарууд байгаа учраас энэ хувилбарууд дээр бид нар бас нэлээн сайн

жишиг төслүүдийг ирэх онд бас төлөвлөж байгаа гэдгийг онцолж хэлье гэж бодож байна.

Ер нь тэгээд бид нар энэ өөртөө байгаа хөрөнгөгүйн зовлон биш хөрөнгөтэйн зовлон л манайд байгаа юм байна л гэж би хараад байгаа шүү дээ. Маш их олон байшин барилга байдаг. Залуучуудын төв, хүүхдийн төв, ахмадуудын төв хоорондоо ерөөсөө энэ ажлын уялдаа хангагдаж байгаа юмнууд ерөөсөө байхгүй. Тийм учраас нэгэнт л төр гэж байгаа бол энэ байгаа байгаа байр байшингуудаа дундаа ашиглах чиглэл рүү бид нар явах зайлшгүй байгаа. Хэрэв энэ байр байшингуудын асуудлуудаа бид нар зөв менежмент хөрөнгийн менежмент зөв хийж чадах юм бол энийгээ дагасан тэр өдрийн үйлчилгээнүүд, өдөр өнжүүлэх үйлчилгээнүүд гэх мэтчилний ахмадуудын өнөөдрийн хүсээд байгаа энэ нийгмийн үйлчилгээнүүдийг бол гаргаж ирэх ийм бүрэн боломжууд, сууриуд нь дэд бүтцүүд нь бас өнөөдөр байна гэж харж байгаа. Улаанбаатар хот маань бол цаашдаа “20 минутын хот” гэдэг энэ шинэ концепцууд гаргаж ирж байгаа. Энэ хүрээндээ энэ хот төлөвлөлтүүдийн хүрээнд ч гэсэн цаашдаа томоохон хорооллууд, гэр хорооллуудыг барихад, дахин төлөвлөхөд бол энэ ахмадуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй амьдрах энэ боломжуудыг дэмжих бас нэг ийм зөөлөн дэд бүтцүүдийг бид нар хийж өгөх ийм шаардлага бас байгаа юм байна гэж бодож байна.

Өөр нэг зүйл бол энэ цоо шинээр Монголд бараг бид нар ер нь хэмжиж үзээгүй асрахуйн эдийн засаг Caring economy гэдэг маш чухал асуудал юм байна. Энийг бид нар ер нь бодлогын түвшинд манай Байнгын хороо ч гэсэн бас ер нь энэ дээр анхаарлаа хандуулж, яг энэ асрахуйн эдийн засаг чинь манай Монголд хамгийн том эдийн засаг болчихсон юм байна. Тэр нь манай өнөөдөр Жи Ди Пи ДНБ-д яаж нөлөөлж байгаа юм. Аль нь төлбөртэй байх юм, аль нь төлбөргүй байх юм гэх мэтчилэнгээр энэ чинь өөрөө их том эдийн засгийн том бодлого байдаг.

**Л.Энхнасан:** 1 минут нэмье.

**Л.Энх-Амгалан:** Энэ чиглэлээр бас бид нар НҮБ-ын харьяа байгууллагуудтай бас нэлээн тооцоо, судалгаануудыг хийж эхэлье. Монголд өнөөдөр асрахуйн эдийн засаг ер нь байгаа бол ямар хэмжээний эдийн засаг байгаа юм. Энэ эдийн засаг дээр хэдэн хүний оролцоо байгаа юм гэдэг асуудлуудыг бид нар бас ийм хэмжиж үзэх нэг хэмжүүртэй болох ёстой. Нөгөө талаасаа бас нөгөө Gig economy гээд бас цоо шинэ бид нарын ойлгодоггүй, тэгсэн мөртөө ийм шинэ эдийн засгийн харьцаанууд ороод ирлээ. Тэгэхээр энэ чиглэлээр бид нар энэ Gig economy буюу гиг эдийн засаг, асрахуйн эдийн засгийн асуудлууд дээр бас бодлогоо тодорхойлох ийм цаг нь бас болсон юм байна гэж харж байна. Эрдэнэбат гишүүнтэй энэ дээр бол бас санал нэг байна.

**Л.Энхнасан:** Батжаргал дарга хариулна уу 1 дүгээр микрофон. Сувиллын тариф.

**Б.Батжаргал:** Гишүүний асуултад хариулъя. Сувиллын тарифын асуудлууд дотроо бас олон янз байгаа. Үйлдвэрлэлийн ослын сангаас олгож байгаа сувиллын тарифыг бол бид нар 2024 онд шинэчлээд батлаад, мөрдөөд эхэлчихсэн байгаа. Ахмадын сангийн сувиллын тарифыг бол зайлшгүй нэмэгдүүлэх шаардлага байгаа. Энэ бол хуучнаар мөрдөгдөж байгаа. Одоо өргөн

мэдүүлж шинээр батлагдсан хуулийн хүрээнд дагаж орох, батлах журмууд дээрээ энэ тарифын асуудлаа шинэчлэн баталж оруулна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баясгалан гишүүн асуултаа асууна уу.

**Ж.Баясгалан:** Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ ахмад настны талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ ямар чухлыг бол одоо харж байна шүү дээ. Бид нар ерөөсөө асуулт давхцахгүйгээр бүгдээрээ асууж байна. Тэгээд маш олон арга хэмжээг бол хэрэгжүүлэхээр төлөвлөсөн юм байна. Бас талархуштай юмнууд бол маш их байна. Тэгээд энэ дундаа нөгөө нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн талаар л сайдаасаа бас тодруулж асуумаар байна л даа. Нийгмийн халамжийн тэтгэвэр авч байгаа хүн бол 2025 онд 397 мянган төгрөг авах юм байна. Төсөвт тийм ээ. Харж байгаа байнгын асаргаа шаардлагатай хүнийг харж байгаа иргэн маань, асарч байгаа иргэн маань болохлоор 302500 тэгэхээр энэ 2 маань нийлээд чиг ер нь яг мөнгөн дүнгээрээ бол 700 мянга л болж байна шүү дээ тийм биз дээ. 700 мянга. Тэгэхээр энэ чинь бол үнэхээр түрүүн хэлж байна л даа. Энэ дунд бол энэ мөнгийг авдаг хэр нь асардаггүй хүмүүс их байгаа. Энэ тооцоогоо зөв гаргая. Хавтгайрсан халамжийг учрыг нь олъё гэж байгаа бол маш зөв. Үнэхээр асрахгүй байгаа хэр нь тэр хүмүүсийг хасах нь бол 1 дэх асуудал, 2 дахь асуудал нь үнэхээр асаргаа үзүүлж байгаа тэр хүмүүстээ асаргаа үзүүлнэ гэдэг маань өөрөө бол хөдөлмөр эрхлэлт гэж би бол ойлгож байгаа. Энэ бол хүн асарна гэдэг бол угаасаа 24 цагийн ажил байдаг. Тэгээд яг хөдөлмөр эрхлэлт болж өгдөг өөрөө асаргаа үзүүлж байгаа хүн. Тэгэхээр асаргаа үзүүлж байгаа хүний маань энэ 302500 гэдэг бол яагаад ингээд хөдөлмөрийн хөлснөөс доор байгаа юм бэ. Энийг ямар арга хэмжээ авах вэ. Ямар бодлого баримтлах вэ сайд аа. Энэ дээр нэг асуулт байна.

2 дахь асуудал нь бол Ахмадын сан 2023 онд 4737 аж ахуйн нэгж шинээр байгууллаа гэж байна. Тэгвэл энэ дундаа дахиад л өөрөө уг нь төр манлайлах ёстой. Хуулийн хэрэгжилт дээр бол төр өөрөө манлайлах ёстой. Хувийн хэвшлүүдээ дарамтад оруулах биш, татварын дарамтад оруулах биш хөдөлмөр эрхлэх нөхцөлөөр хангасных нь төлөө дахиад тэд нарыг ингэж илүү их ачаалал үүрүүлэхээсээ өмнө төр маань энэ дээр өөрөө хэр их ачаалал үүрч байгаа юм бэ. Хэр их арга хэмжээ авч байгаа юм бэ. Энэ нийт аж ахуйн нэгжийн хэд нь хувийн өмчит, хэд нь төрийн өмчит компани байгаа юм. Бид нар нөгөө тоогоо олохгүй байгаа шүү дээ. 117, 107, 127 гээд төрийн өмчит компаниудаас хэд нь яг ийм сангаа байгуулсан бэ гэдэг энэ 2 асуултыг асууя.

**Л.Энхнасан:** Сайдын микрофоныг өгнө үү. Асуултад хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Ахмадын сан байгуулсан тэр 4700 аж ахуйн нэгжээс хэд нь яг төрийн байгууллагууд хэд нь хувийнх гэдгийг манайхан Отгонбилэг дарга надад мэдээллээ нэгтгээд өгчхөөрэй. Энэ нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудал бол үнэхээр өнөөдөр яг л ингээд хавтгайруулж олгодог нэг ийм хуучин тогтолцоо явж ирсний л өнөөдөр ингээд гай байгаа юм л даа. Яг нөгөө зорилтот бүлгүүддээ ерөөсөө хүрч чадахгүй байгаа. Өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож байгаа тэтгэвэр тэтгэмжийн асуудлууд, нийгмийн баталгааны асуудлууд ч гэсэн ерөөсөө л зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй л байгаа нэг ийм асуудал байгаа юм. Тэгэхээр одоо бид нар энийг өнөөдөр 1 өдөр гоё өргөс авсан юм шиг эсвэл 2025 оны төсвөөр ингээд бүгдийг нь нэмнэ гэж бол үнэхээр байхгүй. Бид нарт ийм эдийн засгийн чадах боломж ч байхгүй. Одоо бид нар энийг



яаж өөрчлөх вэ гэхээр тогтолцооны шинэчлэл л би хийх ёстой гэж ойлгож байгаа Баясгалан гишүүн ээ. Тийм учраас Нийгмийн халамжийн тухай хуулийг өргөн барих гэж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай хуулийг өргөн барих гэж байна. Ингээд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн багц хуулиудыг бас бид нар өргөн барих гэж байна. Энэ хүрээндээ ямар ч байсан бид нар энэ цаашдаа Монгол улс ерөөсөө яг энэ нийгмийн халамжийн тогтолцоотойгоо явах юм уу, тогтолцоотой явбал яг ямар нийгмийн халамжийн тогтолцоотой байх юм. Нийгмийн халамж гэх үү, нийгмийн дэмжлэг гэх үү. Нөгөө цалинтай ээжээс авхуулаад л яагаад цалинтай ээж гэгчихсэн мөртөө цалингийн хэмжээнд цалин нь биш байгаа юм бэ гэдэг шүүмжлэл ч хүртэл нийгмээс гарч ирж байна. Энэ бол үнэн. Зөв шүү дээ. Цалинтай ээж л юм бол цалин л гэж байгаа юм бол яагаад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ байж болохгүй юм гэх мэтчилнээр ингээд нийгмээс гарч ирж байгаа энэ олон шүүмжлэл энэ хүлээлтүүдийг бид нар энэ эрх зүйн шинэчлэлээр л хийх ёстой гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр хамгийн түрүүнд бид нар энэ тогтолцооны шинэчлэлүүдээ хийх хэд хэдэн хувилбаруудыг бид нар бас энэ хуультайгаа хамтарч өргөн барина. Бараг ирэх сард энэ хуулийг бид нар өргөн барьчих болов уу гэж бодож байна. Тэгээд ямар ч байсан энэ нийгмийн халамжийн тэтгэврийн асуудлууд, байнгын асаргаа шаардлагатай байгаа иргэнд олгож байгаа энэ иргэдийн тэтгэмжийн асуудлууд, ингээд нийгмийн халамжийн сангаас олгож байгаа бусад энэ амралт сувилал, протез ортотетын хөнгөлөлт энэ тэр гэх мэтчилэнгээр нийт бараг энэ чинь 212 тэрбум төгрөг 2024 оны байдлаар зарцуулагдсан байгаа юм. Тэгэхээр энэ маань үнэхээр яг хүрэх эзэндээ хүрч чадсан байна үү. 1 дүгээрт, 2 дугаарт бол яг тэр өөрийнх нь хүсэж байгаа үйлчилгээний чанарыг чанартай үйлчилгээ үзүүлэхэд тэр тариф нь хүрч байна уу гэх мэтчилнээр ийм санхүү, эдийн засгийн тооцооллын төсвийн энэ бүх тооцооллуудаа хийж байгаад ингээд бид нар хүссэн, хүсээгүй ийм бодлогын буюу тогтолцооны өөрчлөлт хийж байж л энэ асуудлууд зөв шийдлээ олох болов уу л гэсэн ийм бас хүлээлттэй байгаа.

Ахмадын сан дээр бол төр манлайлах ёстой гэдэг дээр би таналтай санал нэг байна. Төрийн байгууллагууд, төр манлайлах ёстой гэдэгт. Тэгэхдээ манайд нэг ийм зовлон байна Баясгалан гишүүн ээ. Яг ингээд ийм төрийн ажлыг чөдөрлөөд байдаг хэд хэдэн ийм суурь хуулиуд байгаа юм. Төрийн албаны тухай хууль байна, Тендерийн хууль байна. Битгий юм хийгээрэй гэсэн хуулиуд шүү дээ. Битгий юм хийгээрэй гэсэн хуулиуд. Яг тэрэнтэй адилхнаар манай аудитынхан бас ингээд хуулийн хэрэгжилт дээр их тийм сонин дүгнэлтүүд хийгээд, баахан торгуулиуд тавьчихдаг. Үүнээс айгаад ерөөсөө тодорхой зардлуудаа гаргаж чаддаггүй ийм зовлон байгаа учраас ямар ч байсан ирэх онд та бүгдтэйгээ хамтарч байгаад энэ ахмадын хуулийн хэрэгждэггүй байсан заалтыг хэрэгжүүлэх энэ журам, механизмуудыг л цөмөөрөө хамт бий болгоод ингээд явах юм бол бас ч гэж тодорхой үр дүнд гарах ийм боломжууд бас байгаа болов уу л гэж бас би харж байна.

Тэр байгууллагуудыг ялгасан тоогоор нь Отгонбилэг дарга тийм ялгасан тоо байна уу. Тэрийг хэлээд өг.

**Л.Энхнасан:** Отгонбилэг дарга 7 дугаар микрофон.

**Ю.Отгонбилэг:** Гишүүний асуултад хариулъя. Яах вэ, нөгөө нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээний хувьд болохоор 2021 онд бол яг асаргааны тэтгэмж 84500 төгрөг олгодог байсныг ингээд 302500 төгрөг болгож

тодорхой хэмжээнд нэмэгдүүлсэн байгаа. Яг асаргааны тэтгэмжийг бол тухайн гэр бүлийнх нь хүнд бас дэмжлэг үзүүлэх, эм тарианы дэмжлэг үзүүлэх байдлаар бол анх 2008 оноос олгож эхэлсэн. Яг ийм тэтгэмжийг бол бас Герман, Канадад олгодог байгаа. Тэгэхээр цаашдаа бол яах вэ, нөгөө хувийн туслах үйлчилгээ бас асаргааны хувилбарт үйлчилгээг бол давхар хэрэгжүүлэхээр бас хууль журамд тусгаад ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Ахмадын сангийн тухай асуултад нь бас хариулаад өгнө үү.

**Ю.Отгонбилэг:** Ахмадын сангийн хувьд болохоор 2012 оноос эхэлж энэ ахмадын сангийн тухай хуульд тусгасан боловч ингээд сайд хэлсэн янз бүрийн шалтгаанаас бас хэрэгжихгүй байсныг хэрэгжүүлж хэлж байгаа. Тэгээд ахмадын санд бол яах вэ 3 хүртэл хувиар гэхихсэн тухайн байгууллагад ахмад настан байхгүй тохиолдолд тухайн байгууллагынх нь нийт ажилчдын хурлаар хэлэлцэж байгаад хэчнээн хувиар ахмадын сан байгуулж болох вэ гэдгээ хэлэлцэж, яг ахмадын санд зарцуулах мөнгөө бол тооцоолж гаргах ийм боломжтой байгаа. Тэгэхээр энийг бол энэ журамд шинээр тусгаж өгч байгаа. Ийм учраас юу гэдэг юм ирээдүйд 40-өөс дээш настай хэчнээн ахмад байна. Тэтгэвэрт гарах хөтөлбөрт нь бэлтгэх ч гэдэг юм уу тийм чиглэлээр 0,1 хэчнээн ч хувиар бол тухайн байгууллага бол өөрсдөө ажилчдынхаа хурлаар хэлэлцээд бол бас тогтоох боломжтой байгаа. Тийм учраас байгууллагуудад аль болох .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Баясгалан гишүүн тодруулж асууя.

**Ж.Баясгалан:** Гол нь би нөгөө тэр доторх юуг нь асуугаагүй. Ерөөсөө хэчнээн компани байгаа вэ. Тийм мэдээлэл байгаа юу л гэж асуугаад байгаа шүү дээ. Төрийн өмчит компаниас хэдэн компани энэ санг байгуулсан юм бэ гэдгийг л асууж байгаа шүү. Тэгэхээр энэ дээр яг тэр тэдэн компани, эсвэл ерөөсөө 1 ч компани хэрэгжүүлээгүй байгаа бол 1 ч компани хэрэгжүүлээгүй байгаа гэдэг тэр хариултыг өгчхөөрэй.

Энх-Амгалан сайдын хувьд бол яг санал нэг байна. Түрүүний ярьсантай бол. Тэгээд асрах үйлчилгээний тухай хуулийн ажлын хэсэг бас би өөрөө ахалж байгаа. Тэгээд энэ дээр бас яамны зүгээс мэргэжилтнүүдээ өгөөд хамтарч ажиллаж байгаад баяртай байгаа. Мэдээж энэ талаараа бид нар судалгаагаа хийж байгаад энэ хуулийг бол ямар ч байсан анхдагч хууль бол өргөн барина гэж бодож байгаа. Тэгээд яг тэр тоог нь хэлээд өгөөрэй. Байхгүй бол яг байхгүй гэдгээ хэлээд өгчхөөрэй.

**Л.Энхнасан:** Сайдын микрофоныг өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Яг үнэнийг хэлэхэд ерөнхий 1 тоогоор л явсан. 4760 гээд. Үүнээсээ хэд нь жишээ нь боловсролын салбарын байгууллага гэхэд чинь 2600 орчим байгууллагууд байдаг шүү дээ. Цэцэрлэг, сургуулиуд ороод. Тэгээд тэрнээсээ ялгаж салгаад одоо үндсэндээ бол бид нар их өгөгдлийн платформ гэж хөгжүүлж байна. Ер нь энэ манай салбар өөрөө их өгөгдөл дээр суурилж байж энэ бүх тоонууд, зарж байгаа энэ төсвүүд, төсвийн хэрэгжилтүүд их тодорхой болох ёстой юм байна лээ. Энэ дээр удахгүй яг өнөөдөр Монгол Улсад чинь бүртгэлтэй байгаа 90 гаруй мянган аж ахуйн нэгж байгаа. Тогтмол үйл ажиллагаа явуулдаг, НДШ төлдөг компани бол 50 хэдэн мянга байдаг юм. Тэгээд 50 хэдэн мянга. Тэндээс төрийн байгууллагууд чинь бол 4600 орчим байдаг байх. Нөгөө тайлан

балансаа гаргаад байгаа нь. Эндээс бид нар нэгтгээд энэ тоонуудаа ялгаад, тэгээд ойрын хугацаанд тодорхой болох болов уу л гэж би бодож байна.

**Л.Энхнасан:** Тэгэхээр тоо бол яг одоогоор тодорхой биш юм байна гэж ойлголоо. Тэгэхээр сайд энэ тоогоо Байнгын хороонд гаргаж өгнө үү. Тэгээд ер нь энд анхаарах хэрэгтэй байна. Сайдын саналтай, гишүүдийн саналтай бол санал нэг байна. Энэ төрийн байгууллага болгон яам өөрөө эндээ бас манлайлж ажиллах хэрэгтэй байна. Асрахуйн эдийн засгийг бол нөгөө ажлын хэсэг байгуулчихсан байгаа. Баясгалан гишүүн ахалж ажиллаж байгаа. Бид нар энэ дээрээ бас анхаарч ажиллана. Мөнхтуяа гишүүний микрофоныг өгнө үү. Асуултаа асууна уу.

**Ц.Мөнхтуяа:** Бид өнөөдөр их чухал сэдвээр ярилцаж байна. Тэтгэвэр тойрсон асуудал, түүнийг тогтоох итгэлцүүрийн тухай нэг асуулт байна. Гол санаа нь хийж байсан ажил мэргэжил, ажилласан жил нь яг адилхан байхад хэзээ тэтгэвэрт гарснаасаа хамаараад тэтгэвэр бас өөр байна. Жишээлбэл боловсролын салбар дээр авч үзэхэд 2024 онд тэтгэвэрт гарсан багш нар 1,4 сая төгрөгийн тэтгэвэр авч байхад, 2023 онд гарсан ахмад багш 1,3 сая, 2022 онд гарсан ахмад багш 1,2, 2012 онд тэтгэвэрт гарсан багш бол 900 мянган төгрөг гэх мэт ийм зөрүүтэй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ жил бүр итгэлцүүрээ шинэчилж, тэгшитгэж явахгүй бол зөрүү гарсаар байна. Үүн дээр бол ахмад багш нар маань бас нэлээн гомдолтой явдаг юм байна лээ. Яг адилхан ажил мэргэжил, яг адилхан жил ажиллачхаад өөр өөр тэтгэвэр аваад байна гэдэг дээр.

2 дугаар асуудал бол 2024 оны 6 сарын 5-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан Ахмад настны тухай хууль 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх юм байна. Тэгэхээр багш нар маань бас ахмад багш нар маань ажиллаад байгаа шүү дээ. Багшийн хомсдолоос үүдэлтэй. Тэгээд энэ ахмад багш нар дээр болохоор нэмэгдлүүд, хичээл заах цагийн норм, нэмэгдэл, нэмэгдэл хөлс харилцан адилгүй маш замбараагүй явж байгаа. Энэ дээр Боловсролын сайдтай хамтраад Энх-Амгалан сайд ямар ажил хийж байна вэ, ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдгийг бас сонирхож асууя.

3 дугаарт энэ өрх иргэдийг орон сууцжуулах арга хэмжээний хүрээнд ахмад настнуудын орон сууцын судалгаа гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд байдаг уу. Орон сууцгүй ахмадууд бол маш олон байгаа шүү дээ. Жишээлбэл манай боловсролын салбарын ахмад багш нар бол маш хүнд нөхцөлд амьдарч байгаа шүү дээ. Ихэнх нь үр хүүхдийнхээ гэрт ч юм уу, түрээсийн байр, гэр хороололд, гэрт амьдарч байх жишээний. Тэгэхээр бид нар аргацаасан биш нэг яг дорвитой, бодитой ахмад настнууд дээрээ нэлээн сайн бодлогоо явуулах хэрэгтэй байна. Энх-Амгалан сайд бол бас их зөв ярьж байна л даа. Хэрэгцээгүй халамжийг халаад, яг хэрэгцээтэй хүмүүст нь халамжаа хүргэе гэдэг бол маш зөв. Энийг бол маш их дэмжиж байгаа. Тийм учраас энэ ахмад настны орон сууцын асуудал дээр их анхаарч ажиллаач гэдгийг л хүсмээр байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Би бас нэмээд Мөнхтуяа гишүүнтэй яг адилхан асуудлаар нөгөө маш их олон Байнгын хорооны даргад өргөдөл ирж байгаа. Ялангуяа энэ итгэлцлийн талаар 238 дугаар тогтоол дээр хязгаарлалт тавьсан байна. Энэ хязгаарлалтаа хянаж үзэх юм уу. Ер нь ганцхан багш гэхгүй эмч, аж үйлдвэрийн энэ гавьяатнууд, тэргүүний ажилчид, инженер техникийн ажилчид, үйлдвэр байгууллага хуучин нөгөө сайд, дэд сайд хийж байсан 80, 90 дөхсөн ийм өндөр

настнууд байна. Энэ цөөн ахмадууд байна. Энийг хэзээ асуудлыг нь шийдэх юм бэ. Ер нь шийдэхээр энэ саяын дүрэм журамд шинэчлэлт оруулна гэж байна. Энэ дүрэм журамд шинэчлэлт оруулах дээрээ энэ 238-ыг шинэчлэх юм уу гэсэн бас нэмээд асуулт асуучихъя. Баярлалаа. Сайдын микрофоныг өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Тэтгэврийн итгэлцүүрийн цаана дандаа мөнгө явдаг. Би зөвхөн 1 жишээ дурдъя. Түрүүн бас би хэлсэн. 2023 онд тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг бид нар 9 жилийн дараа шинэчилж баталсан. 2014 оноос хойш энэ ямар ч энэ тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр ерөөсөө шинэчилж батлагдаагүй байсан. Ингээд шинэчлэн баталсан итгэлцүүрээр 488 мянган тэтгэвэр авагчдын тэтгэврийг шинэчилж бодоод, үүнээс 164 мянган тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээ дунджаар 181 мянган төгрөгөөр нэмэгдсэн байхгүй юу. Энэ дээр бол хамгийн их том өгөөжийг хүртсэн хүмүүс бол Мөнхтуяа гишүүн ээ, манай боловсролынхон, эрүүл мэндийнхэн. Би ч гэсэн бас боловсролын салбарыг 3,5 жил удирдсан хүн. Энэ боловсролын яг бага тэтгэвэртэй байсан багш нарын тэтгэвэр яг ямар хэмжээнд хүрсэн гэдэг надад бас баримжаа байгаа шүү дээ. Надад тоо ч байна. Сум аймгаараа. Тэгэхээр мэдээж цаашдаа бол энэ тэтгэврийн шинэчлэлийн хүрээнд бид нар бас энийг ингэж авч үзэх ёстой. Саяын Байнгын хорооны даргын хэлж байгаа, тэр дурдаж байгаа тэр асуудал ч гэсэн яг л эргээд санхүүжилт шаардаад байгаа юм. Яг тэр хүмүүсийн нөгөө тэр тэтгэврийн итгэлцүүрийг яг энэ хэмжээнд нь, авч байсан тэр өндөр цалингийнх нь хэмжээнд нь тэдээр тэтгэврийг нь бодоход дахиад 230 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай болчихоод байгаа юм. Түрүүний итгэлцүүр шинэчилсэн шинэчлэл 200 тэрбум төгрөгийн өртөгтэй байсан. Дахиад бид нар итгэлцүүр хөдөлгөх юм бол хамгийн багадаа 230 тэрбум төгрөгөөр хөдөлгөнө. Тэгэхдээ энэ 230 тэрбум төгрөг хэдэн хүний тэтгэврийг ямар хэмжээгээр нэмэх вэ, энэ нь эргээд нөгөө тэтгэврийн доод хэмжээ, тэтгэврийн дээд хэмжээ дээр ямар асуудлууд үүсгэх вэ гээд яг үнэнийг хэлэхэд бол тэтгэврийн итгэлцэл энэ тэрийг бид нар тогтолцоогоо сайн харж байж хийхгүй бол нэг ийм гал унтраасан, хойд хормойгоо авч урд хормойгоо нөхсөн, эс үгүй бол улс төрийн шахалтаар хийсэн ийм итгэлцүүрийн хөдөлгөөнүүд л ирээдүйд тэтгэврийн сан дээр их том ачааллууд үүсдэг юм байна гэдэг ийм гашуун сургамж бид нарт байгаа учраас энийгээ бид нар тэтгэврийнхээ шинэчлэлийн хүрээнд л маш сайн ярих ёстой болов уу л гэж би бодож байгаа юм.

**Л.Энхнасан:** Энэ дээр хийж байгаа тооцоолол, судалгаа байгаа юу сайд аа.

**Л.Энх-Амгалан:** Байна. Бид нар энэ тэтгэврийн шинэчлэлийг олон давхар тэтгэврийн шинэчлэл, одоо байгаа нөгөө тэтгэврийнхээ параметруудийн бодож байгаа параметрууд буюу энэ индексүүдээ илтгэлцүүрүүдээ яаж хөдөлгөх вэ гэдэг дээр Дэлхийн банктай бид нар зөвлөх үйлчилгээг аваад сууж байна. Гэхдээ өнгөрсөн 20 хэдэн жилийн турш бол бид нарт 27 удаа Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк бодлогын зөвлөмж өгсөн юм байна лээ. Та нар тэтгэврийнхээ шинэчлэлийг ингэж хий гэж. Харамсалтай нь тэгээд бид нар дандаа өгсөн саналаас нь эсрэг ийм улс төрийн шийдвэр гараад явсан учраас л өнөөдөр ийм нөхцөл байдал үүссэн юм байна л гэж харж байгаа. Одоо ерөнхийдөө Дэлхийн банкны 3 том актуарчууд тэр прост гэдэг нэг ийм тэтгэврийн тооцоолол боддог ийм платформ байдаг юм байна. Тэгээд энэ прост дээр бас нэлээн хэд хэдэн сценарууд бодож байгаа. Тэгээд энэ 12 сарын дундуур ерөнхийдөө эхний сценаруудыг бид нар танилцуулна гэсэн ийм юу төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

**Л.Энхнасан:** Бусад асуултад хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Ахмад настны орон сууцын тооцоо судалгаа байна уу гэж байна. Ер нь бол Монгол Улс энэ орон сууцын тооцоо, орон сууцынхаа статистик судалгаа үл хөдлөхийн юу чинь 5 жил тутам байх Ариунзаяа сайд аа тээ. Нөгөө үл хөдлөх, орон сууцын тооллого чинь 5 жил тутам хийж байгаа. Үүгээр нэг хийдэг. Гэхдээ одоо ямар ч байсан бид нар энэ орон сууцжуулалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх энэ хүрээндээ манай яам, Статистикийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн газар нийлээд бид нар ямар ч байсан улсын хэмжээний орон сууцны хэрэгцээ шаардлагуудыг гаргаж байна. Монгол Улс өнөөдөр 980 мянга орчим, 986 мянга орчим өрхтэй. 986 мянган өрхөөс яг өнөөдрийн орчин үеийн стандарт шаардлага хангасан орон сууцад амьдарч байгаа өрхүүд гэхэд дөнгөж 300 мянган хүрэхгүй л өрх байгаа юм байна лээ. Цаад талд нь бол 600 гаруй мянган өрхүүд бол орон сууцын шаардлага хангаагүй ийм орон сууцад, амины орон сууцад, эсвэл гэр хороололд амьдарч байна гэдэг ямар ч байсан нэг ийм тоот болсон. Одоо цаашаа бид нар энийг ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайдад 1 минут.

**Л.Энх-Амгалан:** Тэгэхээр одоо яг энэ орон сууцын эрэлт хэрэгцээгээ зөв тодорхойлохын тулд орлогод нийцсэн хямд төсөр орон сууцуудын бодлогыг яаж явуулах вэ гэж бодлогоо зөв тодорхойлохын тулд тоо зөв байх ёстой. Тийм учраас ерөнхий нэгдсэн тоогоо гаргаж ирээд, төрийн албан хаагч нарынхаа орон сууцын эрэлт хэрэгцээ, өнөөдрийн орон сууцын байдлын тоонуудыг бас нэгтгэж байна. Ахмадуудынхаа бас орон сууцын эрэлт хэрэгцээнүүдийн тоонуудыг нэгтгэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ бас орон сууцын тоонуудыг нэгтгэж байна. Залуу гэр бүл 1-3 хүүхэдтэй дөнгөж гэр бүл болсон буюу анх удаа орон сууц авах хэрэгцээ шаардлага хүмүүсийн тоонуудыг бид нар үндсэндээ нэгтгэж байна. Ингээд бид нар цаашдаа бол орлогод нийцсэн буюу зорилтот бүлэгт нийцүүлсэн орон сууцуудын ямар ямар хувилбарууд байх юм. Энэ дээр ямар ямар орон сууцын ипотекийн зээлийн бүтээгдэхүүнүүд байх юм бэ гэдэг бодлогоо ойрын хугацаанд тодорхой болгож ингэж зарлана. Тэгэхдээ би нийгэмд их том хүлээлт үүсгэмээргүй байна. Мөнхтуяа гишүүн ээ. Тэгээд ахмадуудаа бүгдийг нь орон сууцтай болгочихно эсвэл бүгдийг нь түрээсийн орон сууцад болгочихно гэдэг ийм том хүлээлт үүсгэмээргүй байна. Хамгийн гол нь бид нар зорилтот бүлэг рүүгээ л .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Тодруулга. Мөнхтуяа гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхтуяа:** Ер нь бол ахмад настнуудын орон сууцын судалгаа байна уу л гэж асуусан. Хэдэн ахмад орон сууцад орох шаардлагатай байгаа юм бэ. Энийг бол хийж эхэлж байгаа юм байна гэж ойлголоо. Тэр ажиллаж байгаа ахмад багш нарын цалин их өөр өөр байгаад байгаа байхгүй юу. Энэ дээр багш нар маш их асуудал хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар төлөвлөлт, төлөвлөгөө гаргаж ажиллах гэж байна вэ гэдгийг л асуусан юм.

**Л.Энхнасан:** Сайдын 1 минутыг нь өгнө үү. 2 минутад хариулна.

**Л.Энх-Амгалан:** Яах вэ, энэ бол боловсролын салбарын асуудал л даа. Тэгэхдээ өөрөөсөө асуудлыг бултуулж байгаа хэлбэр биш шүү. Зарим сайд нар шиг. Яг энэ бол нэгэнт багш нарын хомсдол бий болсон учраас хүссэн хүсээгүй бид нар ахмадуудаа үр бүтээлтэй, удаан хугацаанд ажиллуулах хүссэн хүсээгүй нийгмийн шаардлага улс орны эрэлт хэрэгцээ байна. Тийм учраас бол бид нар энэ

ахмад настнуудаа дөнгөж гарч байгаа ахмадууддаа зориулсан ахмад настнуудад зориулсан тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж эхэлж байгаа. Энэ дээр тодорхой үр дүн гарч байгаа. Яг цагийн хөлсийг хэдэн цагийг заагаад яг ямар тарифтай явах вэ гэдэг бол Боловсролын сайдын асуудал. Манай яамны асуудал бол нийт Монгол Улсын цалин хөлсний тогтолцоо, нийгмийн баталгааны асуудал бол манай яамны асуудал байгаа. Сая Эрдэнэбат гишүүн 1 жишээ ярьж байх шиг байна. Ахмадаар ажиллуулахад нэмэгдэл цалинг нь хасаад хаячхаж байгаа. Жишээ нь эрүүл мэндийн салбарт чинь сувилагч маш их дутагдалтай байгаа шүү дээ. Тэгээд тэтгэвэрт гарсан сувилагч цаашаа сувилагчаар үргэлжлүүлээд ажиллахад нөгөө нэмэлт цалингуудыг нь хасаж байгаа ийм асуудлууд бас байгаа байхгүй юу. Аудитын чиглэлээр гэх мэтчилнээр ингээд нэг ийм салбар салбар дээр ийм үзэмжээр хандаж байгаа ийм асуудлууд бас байна. Энийг бол нэг мөсөн цэгцлэх ийм хэрэгцээ шаардлага бас байгаа болов уу л гэж би бодож байна.

**Л.Энхнасан:** Ганхүлэг гишүүн асуултаа асууна.

**М.Ганхүлэг:** Өдрийн мэндийг хүргэе Байнгын хорооны гишүүддээ. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуудлыг танилцуулга мэдээллүүдийг авлаа. Асуултууд ер нь нэлээн бас давхардсан. Тэгэхдээ бас саналуудаа хэлье гэж бодож байна. Ахмадын тэтгэврийн зээлийн сарыг багасгах тухай 24 байгааг 12 болгох тухай асуудал яригдаж байгаа юм байна. Тэгээд энийг бас их сайн судлах ёстой болов уу гэсэн ийм саналтай байна. Яах вэ Монголын нөхцөл байдал, санааг бол нэлээн сайн ойлгож байна. Гэхдээ бас энэ дээр тэр өр, орлогын харьцааг тохируулах байдлаар 100 хувь зээл олгож байгаа асуудлыг бол харин нэлээн бас нухацтай авч үзээд, хугацааны хувьд бол бас энэ чинь бас 2 жил гэдэг бол бусад зээлүүдтэй харьцуулахад бас их тийм урт биш ийм хугацаа байгаа. Зарим ахмадууд бас тодорхой авсан зээлээрээ бизнес хийх, өөр бас томоохон янз янзын бас ажлууд хийх энэ тэр гэдэг юмнууд бас байдаг. Нөгөө талаасаа банк бусын зээлүүд рүү бас шилжих вий дээ гэдэг ийм эрсдэлүүд бас гарч ирж магадгүй. Одоо арилжааны банкнууд дээр байгаа арай бага хүүтэй байгаа хүү нь дахиад 2, 3 дахин өссөн ийм зээлүүд рүү бас орох эрсдэлүүд үүсэх вий. Яах вэ, нийгмийн нөхцөл байдал одоогийн байгаа энэ байдлыг бид нар хүчээр шийдэх гээд байгаа ийм алхам бас харагдаад байна. Тэгэхээр энэ тал дээр үндсэн суурь асуудлыг нь бид нар шийдээгүй байж ингээд хүчлэхээр нөгөө үндсэн асуудал маань бас шийдэгдэх үү, үгүй юу гэдэг дээр их сайн судлаарай гэдэг энэ талаас нь би бас сануулж хэлмээр байна.

Бид нар ахмадын асуудал ярихаараа тэтгэврийг нэмэгдүүлэх тухай, яг хөрөнгө санхүүтэй холбогдолтой тухай асуудлыг л голчлоод яриад байгаа. Сүүлийн 8 жилийн хугацаанд Засгийн газар бас орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, тэтгэврийг бас нэмэгдүүлэх чиглэл дээр нэлээн бас ахиц гаргаж ажилласан. Одоо үндсэндээ энэ ахмадад үзүүлж байгаа үйлчилгээ стандартуудынхаа тухай, тэгээд энэ 1 сарын 1-ээс орж нэмэлт, өөрчлөлтөөр явж байгаа энэ асуудалтай хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдолтой асуудал дээр яг энэ тодорхой хөрсөн дээрээ буух ийм зохицуулалтууд ер нь хэр байгаа вэ. Жишээлбэл яг шинжлэх ухаанчаар ахмад настан, тэтгэврийн насны ахмадууд маань 7 хоногтоо тэдэн цагийн дасгал хөдөлгөөн хийх ёстой. Ийм ийм соёлын үйлчилгээнд хамрагдах ёстой, спорт сэтгэл зүйн талаар 1 ахмад настанд үзүүлэх стандарт гэдэг нэг зүйл гаргаж ирээд, тэрнийхээ дагуу тухайн сум, орон нутгийн спорт заал, соёлын төв эдгээр газруудыг яаж тэр стандартад нийцэхийн төлөө ажиллуулж болох вэ гэдэг ийм ерөнхий

төрийн үйлчилгээг илүү менежмент, зохион байгуулалтаар удирдах байдлаар нь шийдэх шийдлүүдийг шинэ бас энэ нэмэлт, өөрчлөлт дээр хэр тусгаж оруулж байна вэ. Энийг цаашдаа анхаараад ингээд бас нийтлэхдээ энэ соёлыг, дадлыг бас энэ ахмадуудын хувьд бол хэвшүүлээд явах боломжууд.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Сайд хариултаа өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Ганхүлэг гишүүнтэй санал нэг байна. Мэдээж ахмадын зээлийн хугацааны асуудлууд, хүүгийн асуудлууд, магадгүй ингээд хүүг нь богиносгочихоор нөгөө банк бус руу, ломбард руу өндөр хүүтэй эрсдэлд ороод ахмадууд маань одоогийн байгаагаасаа илүү их эрсдэлд орчих вий дээ гэсэн ийм болгоомжлол байгаатай бол би тантай санал нэг байна. Гэхдээ яах вэ энэ бол нийт ахмадуудаас гарч байгаа юу байгаа юм. Судалгаа бид нар бас энэ банкнуудтай хамтраад ер нь ахмадууд ахмадын зээл аваад зээлээ яг юунд зарцуулдаг юм бэ гэдэг нэг судалгаа би тэрийг танд хүргүүлье. Тэгээд яг юунд зарцуулдаг юм. Тэгэхээр илүү яг өөртөө биш, үр хүүхдүүдийнхээ эрэлт хэрэгцээнд машин худалдаж авахад нь, орон сууц худалдаж авахад нь, сургалтын төлбөрүүдийг нь төлөхөд нь ч гэдэг юм уу ийм байдлаар зээл аваад, арилжааны өндөр хүүтэй зээл аваад өөрөө амьдрах өрхийнхөө орлогоос ингээд юм хумслаад байдаг, тэгээд өөрөө хүндэрчихдэг ийм зовлон нийтлэг байгаа учраас энэ дээр тодорхой хэмжээнд би бас зохицуулалт байх ёстой болов уу гэсэн байдлаар бас хандаж байгаа. Тодорхой эрсдэлүүд байхыг үгүйсгэхгүй. Энэ дээр бас манай шийдвэр гаргахын өмнө одоо энэ чинь шийдвэр нь бас гарчхаагүй байгаа шүү. Манайхан чинь ингээд аягүй бол энэ Байнгын хорооны хурлаар ийм шийдвэр гарчихлаа гээд бас буруу ташаа мэдээллүүд явах вий дээ гэж бодож байна. Энэ Монгол банктай хамтарч бас энэ зохицуулалтуудыг хийхээр судалж байгаа. Судалгааны түвшинд явж байгаа асуудал юм байгаа юм шүү гэдгийг бас би онцлоод хэлчихье гэж бодож байна.

Тэгээд ерөнхийдөө бид нар энэ ахмад настнууд дээрээ ерөнхий 1 юм ярихаасаа илүү энэ ахмад настан дотроо өөрөө ийм зорилтот бүлгүүд байгаа учраас энэ зорилтот бүлгүүдийг л зөв тодорхойлох нь л хамгийн түрүүний хийх ёстой ажил юм байна гэж бодож байгаа юм. Тэгээд энэ хүрээнд хамгийн сайн хийгдсэн ажил бол Азийн хөгжлийн банкны төслөөр хэрэгжиж байгаа идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээний цогц үйлчилгээг бий болгох гээд энэ их сайн загвар манай Монгол Улсад бий болж байгаа юм байна лээ. Тэгээд үүний хамгийн гол зүйл бол яг ахмад настныг дотор нь 3 ангилаад, ангилахдаа эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар алдалт гэдэг юм уу, өрхийн орлого, сэтгэцийн эрүүл мэндийн байдал гэх мэтчилнээр ингээд их зөв ангилаад, тэгээд аль аль ангилал дээр нь яг ямар ямар эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн үйлчилгээнүүдийг бий болгох вэ гэдэг чиглэлээр их тийм сайн туршлагууд хэрэгжчихсэн байгаа учраас энийгээ бид нар цаашаа ер нь нэлээн хөрсөн дээрээс буулгаад Монгол хувилбартай болгоод ингээд аваад явах ийм том боломжууд бас бид нарын өмнө байгаа. Энэ чиглэлээр бид нар ирэх жил нэлээн тийм хэд хэдэн туршилтын төслүүдийг бас хэрэгжүүлнэ. Энэ чиглэлээр цаашдаа бид нар бас Хөдөлмөр эрхлэлтийн сангаас ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэл рүү, бас урьд өмнө бас тэр болгон эзнээ олоогүй. Тэгэхдээ яг өнөөдөр нийгмийн эрэлт хэрэгцээнд шаардлагатай байгаа нийгмийн олон нийтийн оролцоонд суурилсан ийм нийгмийн үйлчилгээнүүдийг бас хийгээд, бий болгоод ингээд туршаад явъя гэсэн бас иймэрхүү төлөвлөгөөтэй байгаа гэдгээ бас би хэлье гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Нэмэлт цаг.

**М.Ганхүлэг:** Орон нутгийн иргэдтэйгээ уулзаад ингээд явахаар бол ахмадууд маань босож ирээд нэг ахмадын байртай болгоод өгөөч гэдэг хүсэлтийг л маш их илэрхийлээд байгаа. Залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болохоор бас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гээд, тэгэхээр нийгмийн бүлэг тус бүрд зориулсан бид нар ийм байгууламжийг хийгээд явах төсөв, нөхцөл ямар байгаа билээ гэдэг ч юм уу асуудалтай байгаад байна л даа. Тэгэхээр миний санаа бол яг энэ нийгмийн үйлчилгээг үзүүлэх ёстой байгууллагуудаа нэлээн тодорхой болгоод спорт заал, соёлын төвүүдийнхээ хэрэгцээ юмнуудыг ингээд гаргаад хэчнээн хувьд нь ахмадууддаа яг үйлчилгээ үзүүлэх юм бэ энэ тэр гэдгийг нь жоохон стандартжуулах байдаг юм уу. Энэ чиглэлийн ажлыг нь дэмжих чиглэлийн ийм яг тодорхой заалт агуулгуудыг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дамжуулаад хийх гэж байгаа ийм тодорхой төлөвлөгөө юмнууд бас байгаа юу. Гол нь бид нар энэ байгаа нөөц бололцоогоо ашиглах, тэгээд энийгээ буцаагаад хэмжих нөхцөл нь бас тодорхой байвал ингээд бас сайжруулаад явах боломж нь бас бүрдэх гээд байгаа юм болов уу л гэсэн ийм санаатай л байгаад байгаа юм л даа.

**Л.Энхнасан:** Сайд хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Харин энэ 1 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх гэж байгаа Ахмад настны тухай хууль дээр бол яг энэ олон төрлийн ахмадын эрэлт хэрэгцээ дээр суурилсан бүх төрлийн нийгмийн үйлчилгээнүүдийг бас гаргаж ирж байгаа юм. Энэ дээр бол нөгөө ахмадуудын чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх, урлаг спорт, соёл, соён гэгээрүүлэх ажлууд бас орно. Ахмад настнуудад үзүүлэх урт хугацааны цогц тусламжийн үйлчилгээг хөгжүүлэх эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих чиглэлээр ийм олон нийгмийн үйлчилгээнүүд гарч ирж байгаа. Энэ хүрээнд бол нийгмийн халамжийн сангаас энэ 2025 онд яг энэ хэлбэрийн үйлчилгээг гаргаж ирэхэд 4,9 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвтөө тусгасан явж байгаа. Тэгээд энэ 4,9 тэрбум төгрөг одоогийн байдлаар давхцуулсан тоогоор бол 57 мянга орчим ахмадуудад бас нийгмийн үйлчилгээнүүдийг, шинээр бий болгож байгаа нийгмийн үйлчилгээнүүдийг хүргэе. Тэгэхдээ бол мэдээж энэ бага дүн. Цаашдаа нэлээн эрэлт хэрэгцээ дээр нь суурилж чадах юм бол энэ нийгмийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх ийм бололцоо бий. Улсын хэмжээнд 500 гаруй ахмадын нэртэй.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт минутыг нь өгье.

**Л.Энх-Амгалан:** Улсын хэмжээнд 500 гаруй ахмадын өргөө, ордон, төв, танхим гээд ийм нэртэй юмнууд байгаа мөртөө яг ингээд тогтмол ажилладаг уу гэдэг бол 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал дандаа хүүхдийн, залуучуудын, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гээд өмчлөөд байдаг асуудал байж болохгүй гэж бодож байгаа юм. Одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 6 аймаг дээр маш сайхан том төвтэй болсон. Мэдээж хамгийн түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ бид нар үйлчлэх ёстой. Гэхдээ тэр байр савыг илүү их ахмадууд руугаа чиглүүлээд, дундаа ашиглах чиглэлээр заавал ч үгүй нийгмээс тусгаарлаж ахмадууд нь тусдаа, хүүхдүүд нь тусдаа, залуучууд нь тусдаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь тусдаа гэсэн ийм тусгаарласан бодлого бол байж болохгүй. Энэ дээр бол сум дээр байгаа Соёлын төв ч гэсэн энэ суманд амьдарч байгаа бүх насны хүмүүстээ ч гэсэн яг тэр насных



нь онцлогт тохирсон эрэлт хэрэгцээнд тохирсон ийм л үйлчилгээнүүдийг явуулах хэрэгтэй гэж би бодож байгаа юм. Тийм учраас энэ салбар дундын зохион байгуулалтууд маш их чухал. Салбар дундын зохион байгуулалт дээр үндэслэж ийм цогц үйлчилгээ гэж бид нар яриад байна шүү дээ. Цогц үйлчилгээ. Энэ үйлчилгээнийхээ тогтолцооны загваруудыг л .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Булгантуяа гишүүн сая чөлөө аваад явлаа. Тэгэхээр асуулт асуухгүй юм байна. Би сайдаас нэг асуулт асуумаар байна. 2, 3 хоногийн өмнө тоот сайдад хаягласан байгаа. Сүүлийн үед нөгөө олон нийтийн сүлжээгээр Цэргийн албан хаагчийн тэтгэврийн насыг нэмнэ. Тэдний 1 удаагийн тэтгэмж улсын төсөвт дарамт болж байна гэсэн ийм мэдээлэл нэлээн олон нийтийг талцуулаад, тэгээд бас манай Байнгын хорооноос ч гэсэн салбарын хүмүүс маань ингээд ийм бодлого барих гэж байгаа юм уу. Энэ талаар мэдээлэл өгөөч гэж байна. Тэгээд та энэ энэ дээр бас тодорхой мэдээлэл өгөөд, энэ дээр ер нь ямар ажил төлөвлөж байгаа юм. Холбогдох судалгаа, тайлан, мэдээлэл байна уу. Энэ ер нь сонгууль болсны дараа л дандаа ийм мэдээ, гардаг. Тэгээд их олон цэргийн хүмүүс бол энэ мэдээллээс болоод ажлаасаа гардаг ийм сөрөг дагавар бас их байна. Тэгээд энэ дээр сайд бас нэг тайлбар хийж өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Цэргийн албан хаагчдын хүчний байгууллага буюу цэргийн албан хаагчдын тэтгэвэр тэтгэмжийн эрх зүйн асуудал бол тусдаа хуультай шүү дээ. Тусдаа хуулиар зохицуулагддаг. Тийм учраас бол энэ хууль дээр ямар нэгэн тийм үг үсгийг энэ 2025 оны улсын төсөвтэй уялдуулсан өөрчлөлтүүд юу ч гараагүй. Ямар нэгэн байдлаар нас хөдөлгөх, ямар нэгэн байдлаар авч байгаа цалингийнх нь 85 хувиар тооцдог аргачлал индексүүд өөрчлөгдсөн байх. Ямар нэгэн байдлаар тэтгэвэрт гарахдаа авдаг 36 сар нь богиноссон, богиносгож байгаа гэх мэтээр хий хоосон яриа нийгэмд их гарсан. Энийг бид нар залруулсан. Энийг залруулаад Батлан хамгаалахын сайд, Хууль зүйн сайд, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч буюу бүх хүчний байгууллагад бид нар ингээд албан бичгээр энэ мэдээллийг хүргүүлсэн байгаа. Тийм учраас ямар нэгэн байдлаар энэ 2025 оны улсын төсөв батлахтай уялдуулж, эсвэл Улсын Их Хуралд өргөн барих гэж байгаа тэтгэврийн шинэчлэлтэй уялдуулж одоогийн байдлаар гарч байгаа насны хэмжээ, тэтгэвэр тогтоолгож байгаа аргачлалын тоо, авах нэмэгдлүүд дээр бол ямар нэгэн байдлаар засвар хийсэн, хассан, нэмсэн зүйл бол байхгүй шүү гэдгийг бас өнөөдөр энэ Байнгын хорооны хурал дээр хариуцлагатайгаар бас хэлье гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Тэгэхээр асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Яах вэ, би зүгээр нэг ийм юм бодож суулаа л даа. АНУ Өнөөдөр Ерөнхийлөгч нь хэдэн настай вэ гэхээр 78 настай хүн байгаа юм. АНУ-ын 78 настай Ерөнхийлөгчийн хийсэн анхны томилгоо нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь Susie Wiles гээд эмэгтэй 67 настай байгаа юм. Тэгээд энэ хөгжингүй улс орнуудыг аваад үзэхлээр Японы Улсын Их Хурлын дундаж нас нь бараг 50, 60 байгаа шүү дээ. Тэгээд бусад энэ өндөр хөгжилтэй улс орнуудыг аваад үзэхээр маш идэвхтэй нийгмийн гол бас цөм ачааллыг үүрч явж байгаа хүмүүс бол 50, 60 насны хүмүүс байгаад байгаа байхгүй юу. Гэтэл манай Монгол Улсын хувьд угаасаа л яах вэ, орчин нөхцөл, ажлын нөхцөл, байгаль цаг уурын нөхцөл бүх юм нь хүнд учраас дундаж наслалт нь хүртэл их бага байдаг. Тэгээд тэтгэврийн нас нь хүртэл бас их эрт. Сая цэргийн тэтгэврийг бол ярилаа. Цэргийн

тэтгэврийн хувьд эмэгтэйчүүд 42 настай, эрэгтэйчүүд 47 настай тэтгэвэрт гардаг. 4 ба түүнээс дээш хүүхэдтэй бол эмэгтэйчүүдийн хувьд бараг 50 настай тэтгэвэрт гардаг. Ер нь бол эмэгтэйчүүд 55, эрэгтэйчүүд 60, төрийн албанд бол 65 хүртлээ ажиллаж болно гэх мэтчилэн энэ бодлогууд байгаад байгаа. Манай Монголчуудын хувьд бол аль болох л төрөөс өгч байгаа тэтгэвэр тэтгэмж нь байгаа бол аль болох л эрт гарахыг бол бас их бодож байгаа нь нэг талдаа үнэхээрийн хүнд нөхцөл ажилладаг учраас аль болох эрт гавьяаны амралттай гаръя гэдэг энэ нөхцөл байдаг нь бол ойлгомжтой. Гэхдээ хэдүүлээ бас бусад хөгжингүй улс оронтой адилхан ийм идэвхтэй амьдралыг бий болгож байж, эрүүл амьдралыг бий болгож байж сая бас урт удаан наслах боломж нь бүрдэх юм. Тэгээд энэ ахмадын сангийн хамгийн гол ач холбогдол нь өөрөө юу юм бэ гэхээр ер нь бол тухайн тэтгэвэртээ гарч байгаа ахмадууддаа байгууллагаас нь анхаарч нийгмийн идэвхт нь анхаарч амраадаг, сувилалд гаргадаг бүхий л нийгмийнх нь хүндрэлүүдийг нь шийдвэрлэдэг. Харьялалгүй ахмадууд бол тухайн газар нутаг дэвсгэрийн Засаг дарга, хороонд харьяалагдаж Тамгын газар нь энэ асуудлуудыг шийдвэрлэдэг ийм хуулийг 2017 онд батлаад, тэгээд одоог хүртэл дорвитой хэрэгжихгүй. Төр нь өөрөө хэрэгжүүлэхгүй байгаа юм чинь аж ахуйн нэгж, байгууллагууд нь хувийн хэвшил бүр ч хэрэгжүүлэхгүй байх нь бол ойлгомжтой байгаад байгаа юм. Тэгээд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын 8 хүрэхгүй хувь нь одоогийн байдлаар Ахмадын сан байгуулсан байна. Тэгэхээр цаашлаад энэ хуулийг юуны тулд гаргадаг юм бэ гэхээр хуулийг хэрэгжүүлдэг байх тал дээр бол анхаарах ёстой. Төр өөрөө хэрэгжүүлэхгүй байгаа бол бусдаас энэ хэрэгжилтийг нь бас нэхэн шаардах үггүй болчихоод байгаа учраас ядаж төсөвт байгууллагууд энэ жилдээ энэ цалингийн сангийн хэмнэлтээрээ байна уу, үл ажиллагааны орлогоосоо байна уу, төсөвтөө суулгаад байна уу хамаагүй 3 хүртэл хувиар энэ Ахмадын сангаа байгуулах хэрэгтэй байна гэдгийг дахин дахин хэлээд байгаа юм. Тэгээд үүн дээр бас Сангийн яам ч манлайлж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч манлайлж байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд ч гэсэн энэ асуудал дээрээ бас анхаараад, өөрсдөө ч гэсэн төд удахгүй манай монгол ухагдахуунаар ахмадын тоонд орчихно шүү дээ. Төд удахгүй. Би хэрэвзээ дахиад 1 хүүхэд гаргачих юм бол 6-хан жилийн дараа тэтгэвэрт гарах, тэтгэврээ тогтоолгох насанд хүрээд, ахмадуудын тоонд орох боломж нь бүрдчихээд байна. Тэгэхээр ердөөсөө энэ ахмад гэдэг чинь ердөөсөө тийм хол юм биш ээ. Тэгэхээр үүндээ бас анхаарч тал бүрдээ энэ асуудалдаа анхаарч яваасай гэдгийг бас энэ үгэндээ хэлэх гэсэн юм. Бүгдээрээ хамтдаа хичээе.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Тэгээд түрүүн бас дурдсан нөгөө Ахмад настны хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонслоо. Тэгэхдээ бас Ариунзаяа гишүүний хэлж байгаачлан Ахмадын сангийн бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой аудитын байгууллагад бол нийцлийн аудит хийлгүүлэх бичгийг бол Байнгын хорооноос явуулъя. Мөн энэ Ахмадын сан байгуулах энэ ажил дээр төрийнхөн өөрсдөө манлайлж оролцоорой. Тэгээд Сангийн яам болон бусад яам энэ үүрэг чиглэл өгсөн гэсэн байгаа. Энэ ажлаа эрчимжүүлж ажиллаарай. Ингээд Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсож дууслаа. Сайддаа баярлалаа. Ажлын хэсэгт бас баярлалаа.

12.35 цаг.

Дараагийн асуудалдаа орьё.

**“Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.**

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.15-д Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-д заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална гэж заасны дагуу Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн даргаас ирүүлсэн тоотын дагуу Байнгын хороод өнөө өнөөдрийн хуралдаанаар ингээд хэлэлцэж байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулна уу. Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Сүхбаатар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэд дарга, Сансармаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Баярмаа нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Баяраа уучлаарай. Баяраа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Энхжаргал Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Буянжаргал Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батжаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Банзрагч Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, Ган-Өлзий Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Тэтгэмжийн даатгалын сан хариуцсан аудитор, шинжээч, Ганхуяг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны Тогтоол, шийдвэрийн биелэлт, хяналт хариуцсан мэргэжилтэн. Эдгээр ажлын хэсэг ирсэн байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Энх-Амгалан сайд маань Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн төслийг танилцуулна.

**Л.Энх-Амгалан:** Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.15 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-д заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална гэж, 35.16 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно гэж тус тус заасан.

Хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, урамшууллын хэмжээг батлах, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч, даатгуулагчийн төлөөллийн байгууллагын гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах журмыг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын төслийг боловсрууллаа.

Дүрмийн төсөлд Мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөлийн бүтэц, гишүүдийн сонгон шалгаруулалт явуулах дүрэм, журам, урамшууллын хэмжээг батлах зохицуулалтуудыг тусгалаа.

Байнгын хорооны дүрэм, журмын төслийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаан, Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн болно.

Энэ дээр ийм байгаа юм гишүүд ээ. Шинэ батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар үндсэндээ хуучин үндэсний зөвлөл байсан. Ингээд энэ үндэсний зөвлөл нь үргэлжилж ажиллана. Тэгэхдээ энэ үндэсний зөвлөлийг яаж сонгон шалгаруулах юм бэ гэдэг энэ дүрмийг уг нь бас Нийгмийн бодлогын байнгын хороогоор батлах ийм зохицуулалттай учраас өнөөдөр оруулж ирж байгаа юм. Тэгэхдээ Үндэсний зөвлөл нь өөрөө дотроо ийм 2 хороотой болж байгаа. Шинэ хуулиар. 1 нь бол мэргэжлийн хороотой болж байгаа. Мэргэжлийн хороо гэдэг нь мэргэжлийн хороо нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Энэ эрсдэлийн удирдлагын 3, актуар тооцооллын 2, хөрөнгө оруулалтын 2, аудитын 2 гишүүнтэй ажиллана гэдэг ийм мэргэжлийн хороотой болж байгаа. Тэгээд яагаад ийм мэргэжлийн хороотой болж байгаа юм бэ гэхээр ерөнхийдөө энэ нийгмийн даатгалын сангийн засаглалын асуудлууд, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргах зэрэг шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх нэг ийм мэргэжлийн хороотой байхыг бид нар хуулиараа хийсэн.

Тэгээд та бүхэнд мэдээлэл болоход Үндэсний хороо хуралдаад энэ мэргэжлийн 9 гишүүнээ бид нар сонгосон байгаа. Ингээд мэргэжлийн 9 гишүүн маань цаашдаа бол яг Нийгмийн даатгалын ерөнхий газрын засаглалыг сайжруулах, нийгмээс маш их шүүмжлэлтэй байгаа, өнөөдөр тодорхой эрсдэлд орчихсон байгаа арилжааны банкнууд дээр мөнгө байршуулсан асуудлууд гэх мэтчилнээр бид нарт ийм гашуун сургамжууд байгаа учраас цаашдаа бол хуучин бол энэ мэргэжлийн хороо буюу дарга нь шууд шийдвэр гараад, аль банканд хэдэн төгрөгийг ямар хүүтэйгээр байршуулахыг шууд шийдчихдэг ийм тогтолцоо байсан бол энийгээ засаж, мэргэжлийн хороо 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаад, тэгээд эрсдэлийн удирдлага актуар тооцоолол, хөрөнгө оруулалт, аудитын гишүүдийн зөвлөмжөөр үндэслэж Үндэсний зөвлөл шийдвэрээ гаргадаг болсон байж байгаа. 1 дүгээрт давуу тал нь.

2-т нь олон нийтийн хяналтын зөвлөл байгуулагдаж байгаа. Олон нийтийн хяналтын зөвлөл нь бол нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих зорилготой ажиллана. Ингээд үйл ажиллагаандаа улс төрийн болон бусад ашиг сонирхлоос ангид байж шударга ёс, тэгш байдлыг эрхэмлэх, хараат бусаар ажиллах, бодит байдалд нийцсэн, хөндлөнгийн дүгнэлт, зөвлөмжүүдийг өгөх ийм зорилготой ийм 2 хороотой болохоор хуульд заасан. Энэ хуулийг бид нар хэрэгжүүлэх үүднээс өнөөдөр Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлөө үндэсний зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд байгуулсан. Одоо бол та бүхэнд өнөөдрийн Байнгын хорооны хурлаар энэ үндэсний зөвлөлийн дүрмийг батлуулахаар энэ саналыг оруулж ирж байгаа юм. Ингээд Үндэсний зөвлөлийн дүрэм, Үндэсний зөвлөлийн хуралдаан, Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг, үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийн эрх, үүрэг, үндэсний зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт, хариуцлага гээд ийм зүйлүүдийг зохицуулсан Үндэсний дүрмийг бас та бүхэнд давхар мэдээлэл болгож хүргэсэн байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Журамтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ганмаа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн хамгийн түрүүнд ирсэн болохлоор асуултаа асууна уу.

**А.Ариунзаяа:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Энх-Амгалан сайд томилогдсоноос хойш нэг анзаарсан зүйл нь нийгмийн даатгалын сан ер нь яагаад их өндөр ачаалал үүссэн бэ гэдгийг олж харсан байх. Тэгээд тэр нь өөрөө юу юм бэ гэхээр ердөөсөө л энэ улс төрийн шийдвэрүүдээс болж өндөр ачаалал үүссэн байдаг. Уг нь бол нийгмийн даатгалын тогтолцоог бие даасан байдлаар хөгжүүлэх гэж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг бас гаргасан байдаг. Хуулиараа ч уг нь бол тэтгэврийг хэрхэн яаж нэмэгдүүлэх вэ, хэрхэн яаж олгох вэ, тэтгэврийн насыг хэрхэн яаж тогтоох вэ гэдгийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтоож байж, тэгээд сая дараа нь төсөв нь Улсын Их Хурлаар орж ирж байдаг. Гэтэл одоог хүртэл ямар тогтолцоо явсан бэ гэхлээр улс төрийн шийдвэр гараад, тэгээд араас нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хуульд нь нийцүүлэх гэж араас нь шийдвэрүүдийг гаргаж явдаг ийм тогтолцоо нэгэнтээ үүсчихжээ. Тэгэхээр цаашлаад энэ нийгмийн даатгалын тогтолцоог нь яг онолынх нь хувьд өөрөөр нь хөгжүүлэхийн тулд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бие даасан байдлыг бол бас баталгаажуулах хэрэгтэй юм. Тэгээд яг цаасан дээр баталгаа нь байгаа ч гэсэн яг амьдрал дээр ердөөсөө байдаггүй асуудалд анхаарах хэрэгтэй. Тэгээд үүн дээр Энх-Амгалан сайд үнэхээрийн бие даасан байдлаар нь явуулж чадах уу. Тэгээд хамгийн гол нь сайд нь өөрөө яг энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөө ахалж байдаг нь өөрөө эргээд өөрөө өөртөө чиглэл өгөөд байдаг, өөрөө өөртөө зөвлөмж өгдөг, өөрөө өөрийгөө эргээд хянадаг ийм тогтолцоо байгаа нь ер нь бол бас онолын хувьд буруу юм гэдгийг бас онцолж хэлмээр байгаа юм.

Нийгмийн даатгалын сан хэрхэн яаж үүсдэг вэ гэхээр мэдээж шимтгэлээс, иргэдийн төлж байгаа шимтгэлээс үүсэж байгаа. Энэ чөлөөт санг бол арвижуулах чиг үүргийг нийгмийн даатгал хариуцаж байгаа. Энэ нийгмийн даатгалын чөлөөт санг арвижуулах чиг үүрэг нь бол хуулиараа хэдхэн санхүүгийн хэрэгсэлд зөвшөөрөгдсөн байдаг. Монголбанк санхүүгийн хэрэгсэлд оруулах, Монголбанкны бонд, Засгийн газрын үнэт цаас, арилжааны банкны хадгаламжийн хүү зэрэг ийм боломжуудтай байгаад байдаг. Тэгээд харамсалтай нь намайг сайдаар ажиллаж байхад энэ шийдвэр гарсан. Сүүлийн 3, 4 жилийн хугацаанд бол төрийн санд байршуулаад ямар ч хүү бодогдохгүй, инфляцад идэгдүүлээд байгаа нь бол өөрөө хуулиар хүлээсэн үүргээ буюу иргэдийн төвлөрүүлж байгаа санг арвижуулах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа гэж үзэж байна. Тэгээд энэ дээр цаашдын бодлого яг энэ хуулиараа олгогдож байгаа шийдвэрүүдээ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл шийдвэрийг гаргах юм бол Сангийн яам үүн дээр гацаа ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмж 1 минут өгье.

**А.Ариунзаяа:** Сангийн яам энэ дээр та нар банканд арилжааны банканд байршуулаад алдагдал хүлээсэн учраас ердөөсөө л баталгаатай төрийн сан дээрээ л байж байх үүрэгтэй, байж байх хэрэгтэй гэдэг ийм саналаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арвижуулах энэ чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байх дээр ийм хаалт болчихоод байна л даа. Тэгэхээр уг нь бол энэ бодлогоо цаашид яаж та шинэчлэх вэ. Үнэхээрийн бусад улс орнуудтай адилхан жишээлбэл Сингапур байдаг юм уу, Норвеги байдаг юм уу тэтгэврийн сан нь хамгийн том хөрөнгө оруулагч болсон байдаг л даа. Тэгээд үүгээрээ дамжуулаад бас

иргэдийнхээ тэтгэврийн хэмжээг нь нэмэгдүүлэх энэ бодлогыг бол хэрэгжүүлж байдаг. Тэгэхээр манай улсын хувьд бол энэ бодлого маань алдагдаад, тэгээд цаашдаа энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бие даасан байдал болон чөлөөт үлдэгдлийг хэрхэн яаж арвижуулах вэ гэдэг ийм асуулт тавья.

**Л.Энхнасан:** Энх-Амгалан сайд хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл яаж ажиллах вэ, ямар бүрэлдэхүүнтэй байх вэ, ямар асуудлууд шийдэх вэ, эрх, үүрэг нь юу байх вэ гэдэг асуудал бол сая Улсын Их Хурал дээр батлагдсан Нийгмийн даатгалын багц хуулиар ингээд ийм тодорхой хуулиар зохицуулалтууд хийгдчихсэн байж байгаа. Үүнийхээ хүрээнд өнөөдөр энэ Нийгмийн даатгалынхаа үндэсний зөвлөлийн ажиллах дүрмийг Байнгын хороогоороо батлуулахаар оруулж ирж байна. Ер нь бол зөв асуудал хөндөж байгаа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл бол бие даасан байх ёстой. Ямар нэгэн тийм улс төрийн хараат бус байгууллага байж болохгүй. Энэ бол төсвийн мөнгө биш. Энэ бол даатгуулагчийн, ажил олгогчийн төлж байгаа шимтгэлээс бүрдэж байгаа сан учраас бол энэ сан дээр төрийн оролцоо бол аль болохоор бага байх ёстой гэж бодож байгаа. Тийм учраас заавал ч үгүй ер нь цаашдаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд даргалах албагүй. Албагүй. Гэхдээ өнөөдрийн хийсэн хуулийн зохицуулалт нь ийм байгаа учраас ингээд энэ хуулиараа энэ бол би шилжилтийн үеийн зохицуулалтууд гэж харж байгаа. Яагаад шилжилтийн үеийн зохицуулалт гэж харж байгаа вэ гэхээр одоо бид нар энэ тэтгэврийн шинэчлэлийнхээ асуудлыг Улсын Их Хурал дээр оруулж ирнэ. Тогтолцооны асуудлуудыг ярина. Үүнтэй үүдээд цаашдаа ер нь суурь тэтгэвэр бий болбол суурь тэтгэврээ хэн нь хариуцаж явах юм. Одоогийн байгаа албан журмынхаа энэ тэтгэврийн тогтолцоо, дахиад дээрээс нь хувийн сайн дурын тэтгэврийн тогтолцоонуудыг орж ирэхэд аль алин дээр нь ямар хөрөнгийн менежментийг хэн хийх вэ гэдэг асуудал угаасаа тогтолцооны асуудалтай хөндөгдөж гарч ирнэ.

Өнөөдөр хийсэн өнөөдрийн бид нарын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд л бид нар үндэсний зөвлөлөө байгуулаад өмнөхөөсөө бодвол бид нар маш том дэвшил гарсан. Ямар дэвшил гарсан бэ гэхээр ямар ч байсан мэргэжлийн хороотой анх удаа болж байна. Хуучин үндэсний хорооны гишүүд хуралдаад аль банк дээр ямар мөнгийг, ямар хүүтэйгээр байршуулах вэ гэдгийг Монголбанкнаас 1 лавлагаа аваад л ингээд шийдчихдэг. Үүнээс болж маш их, өнөөдрийн байдлаар 160 орчим тэрбум төгрөгийн эрсдэл өнөөдөр бодитойгоор үүсчээд байж байгаа ийм нөхцөл байдлууд үүсэж байна. Ийм гашуун сургамж байгаа учраас бид нар энэ үндэсний хороонд хөрөнгийн менежменттэй холбоотой шийдвэр гаргахад мэргэжлийн холбоо буюу тэр актуарчууд, хөрөнгө оруулалтын компаниудын мэргэжилтнүүд орж зөвлөгөө өгч, энэ зөвлөгөө дээр үндэслэж Үндэсний хороо шийдвэрээ гаргах ийм л зохицуулалтууд, ийм шинэ механизмтай болсон. Энэ бол маш том дэвшил гэж би ойлгож байгаа. Нөгөө талаас нь олон нийтийн хяналт зайлшгүй чухал. Тийм учраас олон нийтийн хяналтын зөвлөлүүд, зөвлөлтэй болж гарч ирснээрээ бол өнөөдөр энэ нийгмийн даатгал дээр байгаа нийгмийн даатгалын энэ шимтгэл хураамжийн асуудлууд, энийг хэрэгжүүлж байгаа асуудлууд, хөрөнгийн менежментийн асуудлуудыг бол ингээд тогтолцооны хувьд ингээд олон нийтэд ил тод, шуурхай, нээлттэй байлгах энэ тогтолцоо руу шилжих ёстой.

Ер нь бол энэ тэтгэврийн сангийн өөрчлөлт чинь хийгдэж байж тодорхой санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээл бий болно. Хөрөнгийн зах зээл бий болж байж урт удаан хугацааны institutional investor гэж ярьдаг энэ хөрөнгө оруулалтууд гарч ирж байж, одоо олон жилийн өмнө бид нарын шийдэж чадаагүй байгаа орон сууцын асуудлууд, ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцооны асуудлууд, дэд бүтцийн том төслүүдийг хийх, санхүүжүүлэх энэ Засгийн газрын урт хугацааны бондын асуудлууд гэх мэтчилэнгээр энийг ингээд санхүүжүүлдэг ийм тогтолцоо нь өөрөө энэ тэтгэврийн шинэчлэлээс шалтгаалж байж цаашдаа хөрөнгийн зах зээл хөгжих үү, хөгжихгүй юу, эс хөгжих үү гэдэг асуудал явдаг учраас бол энийг бид нар энэ тогтолцооных нь хувьд харах ёстой юм байгаа юм л гэж би харж байгаа юм.

**Л.Энхнасан:** Ариунзаяа гишүүн тодруулъя.

**А.Ариунзаяа:** Энх-Амгалан сайд аа, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл одоо яг хаана байршиж байна вэ. Намайг байхад Төрийн сан дээр байсан. Одоо тэгээд ядаж инфляцын түвшинтэй тухайн жилийн үнээс хэрхэн яаж хамгаалж байгаа вэ гэдэг асуултад тодруулж өгнө үү.

**Л.Энхнасан:** Сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ бол их тийм бас толгой өвтгөсөн асуудал юм байна лээ. Хэн ч очоод айгаад шийдвэр гаргаж чадахаа больчихсон л юм байна лээ шүү дээ. Тэгээд одоо аль нэгэн арилжааны банканд нь байршуулчихвал дахиад нөгөө юм нь давтчих вий гээд бүгд шийдвэр гаргаж чадахаа больчихсон юм байна лээ. Тэгээд энэ чинь бол даатгуулагчдын хөрөнгө учраас бид нар айгаад, ингээд эрсдэлээс айгаад тэгээд, өгөөж өгөх ёстой, мөнгийг нь өсгөж өгөх ёстой үүрэг хүлээчихсэн мөртөө бид нар ингээд мөнгийг нь өсгөж өгч чадахгүй байж болохгүй байж болохгүй л дээ. Тэгэхээр мэдээж өнөөдрийн байдлаар бол 2-хон сонголттой л болчихсон шүү дээ. Нэгд нь бол Засгийн газрын бонд авна. Нөгөөдөх нь Монгол банкны, Төв банкны үнэт цаасыг авна. Ийм хоёрхон сонголт. Тэгэхээр ер нь яах вэ, Нийгмийн даатгалын шинэ багц хуулиар бол бас тодорхой хөрөнгийн зах зээл дээр орж ирэх, хөрөнгө оруулах энэ зохицуулалтууд нь бас шинээр орж ирсэн. Тэгэхдээ энэ бол тодорхой хэмжээнд зохицуулалтууд маш сайн журмаар Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Төв банктэй хамтарч байж энэ тогтолцоонуудыг хийх ийм.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт минутыг нь өгье.

**Л.Энх-Амгалан:** Ийм тогтолцоо бид нар хийх ёстой юм байгаа юм. Ингэж байж бид нар шийдвэр гаргах ёстой юм. Өнөөдрийн байдлаар ямар ч байсан Засгийн газар 300 тэрбум төгрөгийн бонд аваач гэсэн хүсэлт хүргэсэн учраас бид нар Засгийн газрын 300 тэрбумын бондод байршуулъя гэсэн ийм шийдвэр гарч байгаа. Тэгэхдээ энэ бол бас Үндэсний хороо дээрээ бид нар шийдвэрээ гаргачихсан. Сангийн яамтай бид нар хүүгийн хэлэлцээрт орж байна. Цаашдаа бол энэ сонголтүүд их олон байгаасай гэж бас бодож байгаа. Тэгээд энэ сонголтыг хийхийн тулд энэ мэргэжлийн хороонууд нь бид нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгдөг тэр актуар тооцооллуудаа өгдөг өгөөж хөрөнгийн өгөөжийнхөө тооцооллуудыг өгдөг нэг ийм тогтолцоо руу шилжих эхний бас их зөв алхам болж байгаа гэдгийг бас хэлье гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Ер нь энэ сантай холбоотой үүсэх эрсдэлийг удирдах урт хугацааны тооцоолол юм уу, стратеги ер нь боловсруулсан юм байгаа юу. Энэ дээр сайд бас нэмээд хариулчихъя.

**Л.Энх-Амгалан:** Би ингэж харж байгаа. Ерөнхийдөө яах вэ үндэсний хороо, үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний зөвлөл дээр мэргэжлийн хороо, мэргэжлийн удирдлагаар ажиллана. Тэгэхдээ энийг бол би түр хугацааны шийдлээ л гэж харж байгаа юм. Цаашдаа ер нь энэ тэтгэврийн тогтолцоогоо бид нар шинэчилсний дараа энэ НДЕГ-ынхаа бүтэц, зохион байгуулалт засаглалын асуудлуудыг задлах ёстой гэж ойлгож байгаа. Энэ бол төрийн захиргааны ийм байгууллага байх ерөөсөө шаардлага байхгүй. Энэ бол цэвэр хөрөнгийн менежментийн компани асепт менежмент гэж ярьдаг энэ компани бол зохион байгуулагдах ёстой.

Тэгэхээр манай яаман дээр хуримтлалын сан бас ирсэн. Тэгэхээр хуримтлалын сангийн эхний ээлжид 400 тэрбум төгрөгийг ямар ч байсан ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа. Ирэх жилд 500 орчим тэрбум төгрөгийг бас ипотекийн зээлийн хүртээмжийг оруулна. Тэгэхдээ үүний нөгөө хуулиараа Баялгийн сангийн тухай хууль дээр хуримтлалын сангийн хөрөнгийн жилийн өгөөж нь тухайн жилийн бодлогын хүүгээс багагүй байна гээд заачихсан учраас бол энэ бодлогын хүүгийн зардлыг Монгол .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна уу.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Энэ чинь одоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, журам гэдэг асуудал мөн биз дээ тээ. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг асуусан чинь хууль нь хэрэгжээгүй байна гээд хариулаад яваад байсан. Энэ дүрэм журамтай холбоотой асуудал дээр ийм 2, 3 зүйл байна. Үндэсний зөвлөл дараах үүргийг гүйцэтгэнэ гээд 3.2.9 хүртэл үүрэгжүүлчихсэн байна л даа. Энэ дээр нийгмийн даатгалын бодлого стратегийг боловсруулах, батлах гэдгийг үүрэгжүүлж оруулж болох уу.

2 дугаарт даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлыг үүрэгжүүлж оруулж болох уу. Яах вэ, энэ дүрмийнхээ 1.3 дээр даатгуулагчийн эрх, ашгийг хамгаалах гэдэг үг, үсэг бол орсон байна. Үндсэн зарчим дээрээ, баримталж ажиллаж ажиллах зарчим дээрээ. Тэгэхдээ энийг Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг дээр оруулж өгмөөр санагдаад байна л даа. Энэ даатгуулагчийн эрх, ашгийг хамгаалаагүйтэй холбоотой асуудлаас үүдэлтэй л ер нь бол нийгмийн даатгалын сантай холбоотой олон асуудлууд үүсэж хөндөгдөж байгаа шүү дээ. Хэн нэгэн луйварчин, сангийн тонуулчид нь эндээс хождог биш, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэл дээр энэ үндэсний зөвлөл бол ажиллах ёстой болов уу нөгөө талдаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ заалтуудыг оруулж өгөх бололцоотой юу. Ер нь бол зүгээр одоогийн байгаа заалтуудыг харахаар нэлээн ерөнхий заалтууд л байгаад байна л даа. Тэгэхээр энэ дээр ийм тухайлсан заалтуудыг оруулах боломж байгаа юу гэдгийг би асуух гэсэн юм. Тэгээд дараа нь тодруулъя. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Энх-Амгалан сайд хариулна. Батжаргал дарга хариулна. Микрофон 1 дүгээр.

**Б.Батжаргал:** Гишүүний асуултад хариулъя. Даатгуулагчийн эрх, ашгийг хамгаалах гэсэн заалтыг оруулж өгөх боломжтой гэж үзэж байна. Энийг бол бас



дэмжиж байна. Зүгээр бодлого, стратегийн хувьд бол харьцангуй бас яам дээр гол бодлогууд гардаг. Тийм учраас бас энийг тухайлан бас оруулаагүй. Бид нар бас дэд ажлын хэсэг дээр ярилцсан. Тэгээд Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар бас яамны эрх, үүргийг заачихсан байдаг учраас энэ удаа бол оруулаагүй. Харин даатгуулагчийн эрх, ашгийг хамгаалах гэдэг бол боломжтой гэж үзэж байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тодруулга авах уу. Байхгүй. Ганмаа гишүүн асуултаа асууна.

**Д.Ганмаа:** Сайн байцгаана уу. Хэдэн асуулт, тодруулах зүйл байна. 3.2.4-д Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн төслийн нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын үнэт цаас, Монгол банкны үнэт цаас худалдан авах, тэгээд арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг хуульд заасан аргачлалаар тооцон батлах гэгчжээ. Тэгээд энэ аргачлал гэдэг хэсгийг тодруулмаар байна. Яг ямар аргачлалыг хэлж байгаа вэ.

Нийгмийн даатгалын тухай хуультай бас харьцуулан уншиж танилцсан болно. Тэгэхээр энэ дээр тодруулга авмаар байна.

2-т болохоор сайжруулаад, даатгалын үндэсний зөвлөлийн хажууд бас мэргэжлийн хорооны гишүүдийг ажиллуулахаар болж байгаа юм байна. Сая сайд танилцуулснаар. Энийгээ нээлттэй сонгон шалгаруулалтаа хийчихсэн юм байна. Энийг Үндэсний зөвлөл өөрөө нээлттэй сонгон шалгаруулалт хийгээд, үйл аж ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт, тэр байтугай гишүүдэд олгох урамшууллын хэмжээг зохицуулах журмыг Үндэсний зөвлөл нь батална гэж байна. Тэгэхээр зэрэг энэ мэргэжлийн хороо нь өөрөө Үндэсний зөвлөлөөсөө хараат бусаар, бие даасан байдлаар санал, дүгнэлт гаргах боломжтой юу. Энэ боломжийг яаж гаргаж өгч байгаа вэ.

Тэгэхээр бас давхар энэ үндэсний зөвлөлөөсөө гадна байгаа мэргэжлийн хороо үндэсний зөвлөлийг өөрийн ч гэсэн ер нь энэ ашиг сонирхлоос хол байлгах, энд автуулахгүй байх, зөрчлөөс хэрхэн сэргийлэх вэ гэдэг асуудал дээр 3 дахь асуулт олж тодруулъя.

Түрүүн сайд тайлбарласан олон нийтийн бас зөвлөлийг бий болгож байгаа гэж. Энэ ОНЗ-ийн дүрэм, журам, хяналт тавих механизм процедур нь тэгвэл байгаа юу. Ингээд 4 асуулт болгоё.

**Л.Энхнасан:** Батжаргал дарга 1 дүгээр микрофон дээр хариулна уу.

**Б.Батжаргал:** Ганмаа гишүүний асуултад хариулъя. Дүрмийн төслийн 3.2.4 дээр аргачлал гэсэн байгаа. Энэ дээр аргачлал гэдэг нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд зааснаар системийн ач холбогдол бүхий банканд 1 дүгээрт байршуулах ёстой. Системийн ач холбогдол бүхий банкнуудын төлбөрийн чадвар, баланс, аудитлагдсан баланс гэсэн бүх мэдээллүүдийг бид нар бол авахаар болсон.

2 дугаарт нь мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг тогтоохдоо эдгээр системийн ач холбогдол бүхий банкнуудыг нь арилжааны хэлбэрээ зарлаж байгаа 6 сарын хугацаатай, 12 сарын хугацаатай зарлаж байгаа хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийг нь жигнэсэн дундаж хувийг гаргаж, нийгмийн даатгалын

үндэсний зөвлөл баталсан. Энэ жилийн хувьд бол 13,7 гэж баталсан байгаа. Ийм аргачлалаар бол баталж байгаа.

2 дахь асуултын хувьд мэргэжлийн хороо хараат бус ажиллах боломж байгаа гэж гэж асууж байна. Тэгэхээр мэргэжлийн хороодын ажиллах журмыг бол бас Үндэсний зөвлөл батлаад мөрдөж байгаа. Тэгээд энэ дээр бол бид нар 3 удаа бас нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад, орон тооны бус мэргэжлийн хороо. Тэгээд мэргэжлийн хүмүүсийг бол голчлон шалгаруулж авсан. Энэ чиглэлээрээ нэлээн мэргэшсэн, зах зээл дээрх тоонуудыг бас нэлээн боломжийн уншчихдаг, баланс уншчихдаг, шинжилгээ хийдэг ийм актуарчууд, санхүүгийн менежментийн хүмүүсийг сонгож авсан байгаа. Тэгэхээр энэ хүмүүсийн хувьд бол нэлээн боломжийн ажиллах боломжтой гэж үзэж байгаа. Гэхдээ анх удаагаа бас хороо байгуулж байгаа учраас бид нар энэ жил л байгуулж байна. Анх удаагаа. 30 жилийн хугацаанд. Тэгээд бас боломжийн ажиллах болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Тэгээд алдаа гарвал бас залруулаад явах боломж байгаа.

Олон нийтийн хяналтын зөвлөл бол дотроо 3 бүрэлдэхүүн байгаа. Даатгуулагчийг төлөөлсөн, ажил олгогчийг төлөөлсөн, тэгээд төрийн байгууллагаас орж ирж байгаа ийм 3 төлөөлөлтэй. Тэгэхээр энэ 3 төлөөлөл бол бие биедээ бас хяналт тавихаар, дээр нь бас орж ирж байгаа саналууд дээр бас давхар хяналт тавихаар хөрөнгө оруулалтын саналууд дээр ийм журамласан зохицуулалтуудыг бас оруулж өгсөн байж байгаа. Тэгэхээр энэ олон нийтийн хяналтын зөвлөл өөрөө бас бие дааж ажиллахгүй. Энэ дээр мэргэжлийн хороод нь харилцан бас бие биедээ бас хяналт тавихаар ингээд журам дээр нь бас сөөлжүүлээд хяналтыг нь процессыг нь тусгаад өгчихсөн байж байгаа гэдгийг нь дурдъя. Тэгээд олон нийтийн хяналтын зөвлөл бол 7 гишүүнтэй, мэргэжлийн хороо бол 9 гишүүнтэй ийм 2 үндсэн бүрэлдэхүүн байна. Олон нийтийн хяналтын зөвлөл бол НДЕГ-ын үйл ажиллагаанд түлхүү хяналт хяналт тавина. Батлаад өгсөн бодлогыг яг яаж хэрэгжүүлж байна вэ гэдэг дээр. Мэргэжлийн хороо бол илүү бодлогыг шийдвэр гаргахад илүү мэргэжлийн тоонууд дээр ажиллана гэсэн ийм ажлын чиг үүрэг, журмаар бол зохицуулагдсан байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тодруулга.

**Д.Ганмаа:** Тэр аргачлалыг Монгол хэлэнд ойрхноор асууя даа. Арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг гэдэг дээр яг энэ мөнгөн хадгаламж байршуулахдаа тухайн банкныг хэрхэн сонгож байгаа юм. Банк нь ямар шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан банк бий болох юм бэ гэдэг талаас нь тайлбарлаж өгөх үү.

2 дугаарт би тэр мэргэжлийн багийг бол нөгөө Үндэсний зөвлөлийн өөрийн ч гэсэн ашиг сонирхлоос яаж хол байх вэ. Яаж урьдчилан сэргийлэх вэ гэж асууж байгаа. Түүнээс мэргэжлийн хувьд бол ажлаа хийж чадах эсэх энэ тал дээр бол та хэд мэдээж зөв шалгуурыг тавиад авч байгаа байх л даа. Тэр дээр тодруулъя. Ямар ч байсан энэ 2 дээр авчихъя.

**Л.Энхнасан:** Батжаргал дарга хариулна уу. 1 дүгээр микрофон.

**Б.Батжаргал:** Гишүүний тодруулгад хариулт өгье. Нийгмийн даатгалын ерөнхий хууль дээр системийн ач холбогдол бүхий арилжааны банканд хадгаламж байршуулна шүү гээд заагаад өгчихсөн. Тэгээд системийн ач холбогдол бүхий

банкийг Монгол банк зарладаг. Тэгээд бид нар Монгол банкнаас ямар ямар банк нь системийн ач холбогдол бүхий банк вэ гэдгийг бол бид нар 1 дүгээрт мэдээллээ авна. Гэхдээ энэ мэдээлэлтэй хамт тухайн банкны балансууд Монгол банкнаас тавьдаг бүх шалгуур үзүүлэлтүүд, төлөвлөлт түргэн гүйцэтгэх шалгуур үзүүлэлт гэдэг ч юм уу бүх шалгуур үзүүлэлтүүдийг нь аваад, тэгээд энэ банкнуудаас бас саналуудыг нь аваад, ямар хадгаламжийн бүтээгдэхүүн зарлаж байгаа юм бэ, хэдэн хувьтай гэдгээ аваад энэ зарласан хүнийх нь жигнэсэн дундаж нь хамгийн доод өгөөж байна гэдгийг бол бид нар батлах ёстой. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл баталчихсан байгаа. Энэ жилийн хувьд 13,07 байгаа юм. Нэг жилийн хугацаатай хадгаламжийг нь байршуулан гэх юм бол хамгийн доод хэмжээ бол 13,07 шүү гэсэн ийм хүүг бол энд батлаад, явж байгаа.

Мэргэжлийн хороон дээр бол яах вэ, энэ дээр нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон ямар нэгэн төрийн байгууллагын .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт цаг өгнө үү.

**Б.Батжаргал:** Ямар нэгэн төрийн байгууллагын шахалтад орохгүйгээр бие даасан хараат бус шийдвэр гаргах үндсэн зарчмыг л бүх гишүүддээ журмаар ингэж үүрэгжүүлж өгсөн байгаа. Өөрсдөө бас баталгааны хуудсаа өгөхөөр энэ журамласан ийм журамтай. Тэгэхээр одоо тэгээд нөгөө системийн ач холбогдол бүхий банкнаас энэ нь сайн гэдгийг зөвхөн баланс, төлбөрийн чадвар, үзүүлэлт, тоо баримт дээр тулгуурлаж л гаргана гэдэг л үндсэн зарчмаар л ажиллана гэж үзэж байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Сайд нэмэлт тайлбар өгье.

**Л.Энх-Амгалан:** Ийм л байгаа юм л даа Ганмаа гишүүн ээ, ингээд энэ хуулиараа бид нар чинь ингээд ерөөсөө сонголтгүй болчихсон байгаа байхгүй юу. Одоо эсвэл Засгийн газрын үнэт, эсвэл нөгөө Монгол банкны юу, мэдээж арилжааны банкнуудын зээлийн юу байгаа. Зээлийн хүүгээс гээд ингээд бодчихсон. Уг нь бол жинхэнэ сонгодгоороо болох юм бол бид нар чинь илүү хөрөнгийн зах зээл рүү орж урт удаан хугацааны хөрөнгө оруулагч нар болох ёстой шүү дээ. Жинхэнэ тогтолцоо нь бол. Угаасаа тэгэхээр бид нар чинь нэг талаараа зээлийн хүү бууруул гээд улс төрчид маань шахаад байдаг. Тэгсэн мөртөө нөгөө талаараа урт хугацааныхаа санхүүжилтийн эх үүсвэрийг өндөр хүүтэй зээлтэй оруул гээд хуучилчхаад байдаг ийм сонин тогтолцоо. Үүнийхээ бид нар ийм уяаг бид нар зөв тайлах ёстой л гэж ойлгоод байгаа байхгүй юу. Хэрэв бид нар өндөр хүүтэй арилжааны банкнуудын бүтээгдэхүүн, зээл рүү л оруулаад байх юм бол яагаад өндөр хүүтэй тэр зээл байгаад байгаа юм. Тэр чинь хамгийн эрсдэлтэй байгаа шүү дээ. Өндөр хүүтэй зээлийн бүтээгдэхүүн бол хамгийн эрсдэлтэй зээлийн бүтээгдэхүүнүүд байдаг. Тэгэхээр бид нар эрсдэлээ зөв жигнэх, цаашдаа бол нэгэнт энэ тэтгэврийн сан жинхэнэ утгаараа .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт цагийг нь өгье.

**Л.Энх-Амгалан:** Тэтгэврийн сан жинхэнэ утгаараа хөрөнгийн сан болж чадаад ингээд хөрөнгийн менежментээр явж чадах юм бол Монгол Улсад маш их том боломжууд байгаа болов уу л гэж би харж байгаа юм.

**Л.Энхнасан:** Тэгэхээр энэ өөрчлөлтүүд хуулийн шинэчилсэн найруулгад, эсвэл нэмэлт өөрчлөлт орох уу.

**Л.Энх-Амгалан:** Одоо энэ хувийн тэтгэврийн сангийн сайн дурын тэтгэврийн даатгалын хууль өргөн баригдаж орж ирнэ. Энэ дээр мэдээж холбогдоод нэгэнт тэр нь сайн дурын тэтгэврийн сан бий болж байгаа учраас тэр хөрөнгийн менежментийн асуудлууд, бүх зохицуулалтууд орж ирнэ. Эргээд дагаад бид нар тэтгэврийнхээ тогтолцоог зөв хийж, тэтгэвэр маань яг жинхэнэ хагас хуримтлалын тогтолцоо руугаа алхаж чадах юм бол хүссэн хүсээгүй хөрөнгийн менежментийг л хэрэгжүүлэхээс өөр арга байхгүй. Гэхдээ бид нар энийг заавал ч үгүй хэрэгжүүлэх албагүй. Бусад улс орнууд бол энэ гаднын томоохон хөрөнгийн менежментүүд авч хэрэгжүүлдэг ийм юунууд байдаг юм уу. Аль аль хөрөнгийг нийт хөрөнгийнхөө хэдэн хувийг Засгийн газрын бонд руу хийх вэ, хэдэн хувийг нь үнэт цаасаар баталгаажуулсан бонд руу хийх вэ, хэдэн хувийг нь И Кю Ти гэж ярьдаг хөрөнгө оруулалтад хийх вэ, хэдэн хувийг нь дэд бүтцийн бонд руу хийх вэ гэх мэтчилнээр энэ хөрөнгийн стратегиудаа, байршлын стратегиудаа зөв тодорхойлоод, тэгээд хөрөнгийн менежмент хийдэг нэг ийм Монголд байхгүй бид нарт тийм туршлага байхгүй шүү дээ. Тийм учраас бол хүссэн хүсээгүй бид нар гаднын томоохон зөвлөх компаниудыг авч ажиллуулах ийм нөхцөл байдлууд бий болно.

**Л.Энхнасан:** Эрдэнэбат гишүүн асуултаа асууна.

**С.Эрдэнэбат:** Үндэсний зөвлөл өөрөө бас нэлээн томоохон эрхтэй. Нэлээн томоохон мөнгөн дүнг захиран зарцуулах, бас алдсан нэлээн том сургамжтай байгууллага. Тэгээд энэ дүрэм нь өөрөө их чухал юм байгаа юм. Би энийг хэдэн ч Байнгын хорооны дарга байна. Дамнан өмнө нь өгч байсан юм. Оюунхорол даргаас хойш тэгээд ерөөсөө энэ Үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй яваад, одоо орж ирж байна л даа. Энэ дээр 1 дүгээрт бол зарчмын 2, 3 зүйлийг бол би асуумаар байна.

1 дүгээрт энэ Үндэсний зөвлөлийг зарим нь шаардлагатай тохиолдолд олон нийтийн даатгуулагчдын нийтлэг эрх ашигтай холбоотой асуудлаар яагаад нээлттэй хуралдаж болдоггүй юм бэ. Энийг яагаад оруулж ирэхгүй байгаа юм бэ гэж. Улсын Их Хурал өөрөө нээлттэй хурал. Одоо бид нарын Байнгын хорооны хурал хүртэл нээлттэй болж байна шүү дээ. Тэгэхэд манай бид нарт тайлагнагдах ёстой энэ байгууллагууд маань нээлттэй хуралдаад, энэ өөрөө эргээд үндэсний зөвлөлийн хүмүүст ч гэсэн их ойлголт өгнө олон нийтэд. Тэгэхгүй бол битүү хатуу ингээд л нэг юм яваад байгаа. Тэгээд сүүлдээ нийгмийн даатгал ер нь төлөх нь бараг ашигтай ч юм уу, үгүй ч юм уу гэдэг хандлага явах гээд байдаг. Гэтэл маш чухал төлөх ёстой татварын 1 байдаг. Энэ өөрөө энэ даатгуулагчдын итгэлтэй холбоотой учраас энэ дүрэм дээрээ оруулж өгөөч ээ. Би энийг бол өмнө нь 2, 3 удаа өгөөд ерөөсөө шийдэхгүй байгаад байсан.

2 дугаарт энэ материал би хурлын ерөнхийдөө юмыг мэднэ. Материалыг ерөөсөө 2, 3 хоногийн өмнө өгчхөөд, тэгээд асар их мөнгө төгрөгтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргуулах гээд дайрчихдаг. Энэ өөрөө эргээд алдааны асар том эх үүсвэр болдог. Гашуун сургамж байгаа. Хэдэн их наядаар нь, тэрбумаар нь хадгалах мөнгийг 3 хоногийн өмнө өгчхөөд тэр банканд байршуулна гээд тэр банкаа судалсан ч юм байхгүй, тэгээд үеийн үед бас энэ үндэсний зөвлөлийг толгойлж ирж байсан бас зарим хариуцлагагүй дарга нараас болж байсан энэ асуудал гарсан л даа. Тийм учраас тэнд байгаа бас гишүүд нь өөрсдөө бас зарим

талаар хариуцлагагүй байсан. Нэг бүхэл бүтэн том институт байгууллага төлөөлж ирчээд нөгөө байгууллагадаа ч тайлан тавьсан юм байхгүй, олон нийтдээ ч өгсөн юм байхгүй. Дараа дараагийнхаа хүмүүст хариуцлага нь хүртэл давхар ингээд тооцогддог ийм байдалтай байсан учраас энэ дүрэмдээ энийг ингээд оруулж өгөөч гэдгийг бол хэлмээр байна. Материал өгөхдөө дор хаяж энэ чинь 14 хоногийн өмнө байхгүй бол нөгөө төлөөлж байгаа байгууллага олон нийтээрээ хэлэлцүүлэх, саналыг нь авах гэдэг чинь асар их хугацаа хэрэгтэй. Тийм учраас ийм процедурын юм дээр бол та бүгд маань анхаарч өгөөч ээ гэдгийг бол хэлмээр байна.

Их Хурал тайлагнана гээд ингээд нэг юу яваад байдаг юм. Олон нийтдээ тайлагнана гэдэг юм хуульд байхгүй ч гэсэн олон нийтдээ тайлагнах бүр ийм заяагдмал үүрэгтэй. Энийгээ дүрэмдээ оруулж өгөөч. Болж өгвөл Байнгын хороонд жилдээ 1 удаа тайлагнах биш, хагас жилдээ 1 удаа сайн дураараа нөгөө даатгуулагч нь ажил олгогч нартайгаа олон нийтдээ ингээд тайлагнаад явж байвал энэ сангийн үйл ажиллагаа илүү нээлттэй ил тод болно гэж.

Дараагийн 1 асуудал нь болохоор төлөөлсөн байгууллагадаа олон нийтээсээ санал авах, тэд нарт тайлагнаж байх энэ юмыг тавьж өгөх хэрэгтэй байгаа юм. Хэдэн гишүүд томилдог, тэгээд бид нар бол онцгой бүрэн эрхтэй гэдэг байдлаар явж ирээд л тэгээд л хэсэг бүлэг хүмүүсийн .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт 1 минут.

**С.Эрдэнэбат:** Ийм асуудлаас болж байгаа юм. Тийм учраас би нөгөө дүрэм ярьж байгаа учраас үүнтэй холбоотойгоор бас ингээд энэ саналуудыг бол тавимаар байна. Үндэсний зөвлөлийн гишүүдийн эрхийг дүрмээр хаасан юм байна. Олон нийтэд мэдээлэл тавих нь хязгаартай, нууц, нууц, нууц гээд. Юм ярьж болдоггүй. Тийм яасан юм,, ийм яасан юм гэхээр нь танилцсан материал нууц учраас би танилцуулах болж байна уу, үгүй байна уу гэдэг ийм байдалтай даатгуулагч нараас нь өөрсдөөс нь нуудаг тийм нууц зөвлөлийн үйл ажиллагааг хязгаарласан хууль давсан ийм дүрэм гаргаж болохгүй. Энэ дээр бас байгаад байна. Хориглоно энэ тэр гээд зарим юмнууд ороод ирчихсэн. Тэгэхээр ийм юмнуудаасаа жоохон татгалзаад, тэгээд энэ дүрмийг батлах нь зүйтэй байх гэдгийг бол хэлмээр байна.

Тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд би тэр нээлттэй гэдгийг бол дахиад бас хэлээд байна. Үндэсний зөвлөл хааяа энэ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл ч гэсэн би дараа нь хэлэх гэж байгаа юм. Нээлттэй хуралдчихъя гэхээр хүмүүсийн нууц гээд байдаг байхгүй юу. Энэ чинь даатгуулагч нар өөрсдөө миний асуудлыг яаж шийдэх гэж байна вэ гэдэг зүйлийг сонсох хэрэгтэй шүү дээ.

**Л.Энхнасан:** Сайд хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Үндэсний зөвлөл бол мэдээж нийгмийн даатгалын үйл ажиллагаанд хараат бус, хариуцлагатай, нээлттэй, ил тод, даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, төр, хуулийн этгээд, иргэний тэгш оролцоог хангах, асуудлыг хамтын удирдлагаар хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэх ийм зарчмыг баримталж ажилладаг ийм зөвлөл. Мэдээж өмнө нь бол олон сул талууд байсныг үгүйсгэхгүй. Гэхдээ бүгдийг, бүх хүмүүсийг бас буруугаар бас

цоллож болохгүй. Яагаад гэвэл Монгол Улс зөвхөн шүүхээр шийдвэр гаргасан тохиолдолд л гэм буруутай нь тогтоогддог ийм Үндсэн хуультай улс орон байгаа.

Тэгэхээр мэдээж дэвшил бол гарч байна. Одоо ямар ч байсан хуучин бол Үндэсний зөвлөл нь хуралдаад, сая Эрдэнэбат гишүүний ярьж байгаа бараг хаалттай шахуу хуралдаж байгаа шийдвэр гаргаж байсан ийм тохиолдлууд, тэгээд энэ тодорхой эрсдэл үүсгэж байсан ийм тохиолдлууд байна. Байна. Энэ бол гашуун үнэн. Гэхдээ ямар ч байсан энэ удаа бол Үндэсний зөвлөлийн бүх хуралдааны үйл ажиллагаа, хуралдах үйл ажиллагаа бол бүгдээрээ ил тод байх ёстой гэдэг тал дээр би санал нэг байна. Бид нар эхний хурлаа бас ил тодоор хийж олон нийтэд видео, лайваар бас ингэж дамжуулсан. Цаашдаа ч гэсэн бид нар энэ хурлынхаа үйл ажиллагааг бол ингэж лайваар хийх, энэ дээр бол ямар нэгэн байдлаар үндэсний зөвлөлөөс энэ хурлаа, энийг нь хаалттай хийнэ, энийг нь нээлттэй байна. Энэ хурал дээр танилцуулагдаж байгаа материал нь энэ нь хаалттай, энэ нь нууцаар хэлэлцэгдэнэ гэдэг нэг ийм зарчим бол би үйлчлэхгүй болов уу гэж Үндэсний зөвлөлийн даргын хувьд бол бодож байна. Ийм зарчим барьж ажиллана гэж бас бодож байгаа.

Тэгээд мэдээж энэ давуу тал бол өмнөхөө бодох юм бол бид нар чинь мэргэжлийн зөвлөлтэй болчихлоо. Мэргэжлийн энэ 9 хүний зөвлөл бол дотроо бас тодорхой мэргэжлийн ийм зөвлөлүүд, багууд бас гарч ирж ажиллаж энэ Үндэсний хороогоор гарах гэж байгаа шийдвэрүүд дээр нэлээн мэргэжил арга зүйн зөвлөгөөнүүд өгч, тооцоо судалгаанууд өгч ингэж шийдвэр гардаг. Энэ бол маш том дэвшил. Нөгөө талаасаа олон нийтэд ил тод байлгах асуудал бол энэ олон нийтийн хяналтын зөвлөл байгаа юм. Энэ хяналтын зөвлөл маань өөрөө их сайн ажиллах ёстой. Хяналтын зөвлөл дээр бас энэ олон нийтийн төлөөллүүдийг бас бид нар оруулсан. Тийм учраас бид нар хяналтын зөвлөлийг бид нар бие дааж, ил тод ажиллах түрүүн Ганмаа гишүүн ч гэсэн асуугаад байна. Мэргэжлийн зөвлөл, хяналтын зөвлөл чинь тэр Үндэсний хорооноосоо хэр зэрэг бие даасан байж чадах юм бэ. Тийм шийдвэр гаргах та бүхэнд тийм зөвлөмж өгөх нэг ийм боломжууд нь байгаа юм уу гэж асуугаад байна. Ямар ч байсан бид нар анх удаа ийм зөвлөлтэй болж байна. Анх удаа мэргэжлийн хороотой болж байна. Анх удаа хяналтын зөвлөлтэй болж байгаа учраас үүнийхээ дүрэм журмыг нэг сайн гаргаад авах юм бол ямар ч байсан тодорхой дэвшлүүд, ахиц дэвшлүүд бол гарах болов уу гэж бас бодож байна. Тантай санал нэг байна. Одоо ямар нэгэн байдлаар энэ Үндэсний зөвлөл дээр гаргасан шийдвэрүүдийг бол нэгэнт Үндэсний зөвлөл нь өөрөө Байнгын хорооноос байгуулагдаж, үндсэн Байнгын хорооноос байгуулагдсан Үндэсний зөвлөлийн дүрмээрээ тоглоомын дүрэм нь ийм байгаа учраас бид нар бол Байнгын хороондоо улирал тутамд ч гэсэн энэ үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэрүүдийн мэдээллүүдийг бол нээлттэй мэдээлээд явах ийм бүрэн боломжтой гэж харж байгаа.

**Л.Энхнасан:** Тэгэхээр сайд аа, энэ нөгөө Эрдэнэбат гишүүний хэлж байгаагаар энэ үндэсний зөвлөлийн гишүүд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд иргэд, даатгуулагчид мэдээлэл хийхийг хориглоно гэсэн нэг заалт байгаад байгаа шүү дээ. Тэр нь бол хийнэ гэдгээрээ нээлттэй байна. Хуралдаан нээлттэй байна гэж өөрчлөлт орно гэж ойлгож болох уу. 4.2.7-д байна уу. Бие даан аливаа үйл ажиллагаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэд, даатгуулагчид мэдээлэл хийх үндэсний зөвлөлтэй зөвшилцөөгүйгээр бие даан аливаа үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно гэгчихсэн. Тодруулга.

**С.Эрдэнэбат:** Энэ дээр попрох асуудал биш ээ Ариунзаяа сайд аа. Тэр үндэсний зөвлөл дээр алдаатай шийдвэр гэдэг юм уу ямарваа нэгэн зүйл гарч байгаа бол тэрийг ярих л хэрэгтэй. Би энийг яагаад хэлж байна вэ гэхээр үүний өмнө хэзээ билээ нэрийн данс дахь хүү тооцох дээр бодлогын хүү 12 хувь байж байхад 9 хувиар тооцчихсон байгаа байхгүй юу. Бодлогын хүү буюу хамгийн доод талын хүүгээс 3 функтээр доошоо. Тэгээд энийг нь яриад хэлээд явъя гэхээр хамаагүй бас ингээд зөвшилцөхгүйгээр олон нийтэд тавих нь хориотой гээд. Энэ чинь өөрөө хүний мэдэх эрх. Даатгуулагчдын мэдээлэл авах эрхийг нь хаах гэдэг юмыг нэг дүрмээр оруулж ирээд хүмүүс попорчхож магадгүй гэдэг байдлаар хандвал болохгүй. Тийм учраас энэ тал дээр хуучин Үндэсний зөвлөлүүдийн явж ирсэн юм гэхээр мэдээллээ өгдөггүй нэг шалтгаан нь ерөөсөө энэ. Танилцсан материалынхаа нууцыг хадгална энэ тэр гээд тавьчихаж байгаа байхгүй юу. Үгүй ээ, тэр хүү тооцох дээр ухаан бодлоо уралдуулахад энэ нь буруу байна. Би ингэж үзсэн, би ийм байр суурьтай байсан гэдэг, тэгэхдээ энэ үндэсний зөвлөл дотор хамаагүй айхтар яриад байдаг хүмүүс бол байхгүй байх л даа.

**Л.Энхнасан:** Сайд асуултад хариулна уу.

**Л.Энх-Амгалан:** Энэ заалт заавал байх хэрэггүй байлгүй дээ. 4.7.2. Энэ чинь Үндэсний зөвлөл чинь аль болохоор нээлттэй, ил тод ажиллана гэдэг зарчим дээрээ ингэжхээд тэгээд, дараа нь энэ зүйлийг нь хуулиар. Энэ дээр яг ямар үндэслэлээр ийм заалт ороод байгаа билээ. Яг хариуцлагажуулж байгаа, яаж байгаа, ямар юм байгаа билээ. Энэ чинь Үндэсний хороогоор хэлэлцэж байгаа бүх асуудал бол нууцлаад байх асуудал ерөөсөө байхгүй шүү дээ. Даатгуулагчдын л хөрөнгийн тухай л асуудал ярих гээд байгаа шүү дээ. Энэ дээр Батжаргал дарга яг яагаад энэ ийм заалтыг оруулах шаардлага үүссэн гэдгийг.

**Л.Энхнасан:** Батжаргал даргын 1 дүгээр микрофон.

**Л.Энх-Амгалан:** Шаардлагагүй бол энэ заалтаа хасъя.

**Б.Батжаргал:** Эрдэнэбат гишүүний саналыг сайдын бас хэлснээр 4.2.7-г ер нь хасчхаж болохоор юм байна. Яах вэ нээлттэй гэсэн зарчмаа баримтлах үндсэн зарчмаа баримтлаад явах нь болох болов уу гэж бодож байна. Гэхдээ яах вэ нөгөө олонхоороо шийдчихсэн санал дээр бас зарим тохиолдолд нийгэмд бас буруу ойлголт өгөхүйц мэдээллийг өгсөн тохиолдол урьд нь гарч байсан юм байна лээ. Тэгээд яах вэ, нэгэнт шийдвэр гарчихсан асуудал дээр өөр мэдээлэл нийгэмд өгчихөөр бас ойлгомжгүй асуудал үүсээд байсан учраас энэ заалт орсон. Тэгээд хуучин дүрэм дээр бол байсан заалт. Тэгэхдээ яах вэ, нээлттэй гэсэн агуулгаараа энэ заалтыг бол хасчхаж болохоор юм байна гэдэг саналтай байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Зулпхар гишүүн асуултаа асууна уу.

**С.Зулпхар:** Байнгын хорооны дарга, гишүүд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. 2 асуулт байна.

Бид ямар ч байсан Нийгмийн даатгалын багц хуулийг 2023 онд батлаад, 2024 оны 1 сарын 1-ээс эхлэн хэрэгжүүлж эхэлж байна. Үүнтэй холбоотой холбогдох дүрэм журмуудыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам боловсруулж, эхнээс нь батлуулаад, хэрэгжүүлж байна. Энэ бол бас их сайшаалтай гэж байгаа юм. Ер нь хууль болон хуулийг дагалдаж гарах дүрэм журам бэлэн болж байж л

бидний хүлээж байгаа энэ тогтолцоо ажилладаг л даа. Тэгэхээр энэ тогтолцоо ажиллах бэлтгэлүүд бол их сайн хангаж байна гэж ойлгож байгаа юм. Өнөөдөр бас яах вэ, нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм орж ирж байна. Чиг үүргийнхээ дагуу, эрх үүргийнхээ дагуу Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор энийг хэлэлцэж бид бас батлах учиртай. Би тэгэхлээр яах вэ Байнгын хорооны ажлын албанаас асуулт байна. Одоо бид өнөөдөр ингээд холбогдох дүрэм журмуудаа баталчихна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлтэй холбоотой. Тэгэхээр үндэсний зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулалт явагддаг, сонгодог ийм бас ажил зохион байгуулагддаг. Энэ сонгон шалгаруулалт хэзээ явуулж бид энийг хэзээ хийх вэ гэдэг ийм асуулт байгаа юм. Ажлын албанаас энэ дээр бол манай Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаныхан их туршлагатай байгаа учраас хугацааг нь бас хэлээд өгөөч гэж байгаа юм. Угаасаа хуулиа хэрэгжүүлэхтэй холбоотой энэ их чухал бэлтгэл учраас гэж байгаа юм.

2 дахь асуулт бол би сайдаас асууя гэж бодож байна. Энэ хууль бол өөрөө нэг талаар их тийм дэвшилттэй хууль болсон. Энэ их олон жил судлагдсан, олон ч сорилтыг бид бас хамтдаа хэлэлцсэн. Зарим жишээ нь асуудлыг бол өөрийн болон өөр улсын туршлага дээр тулгуурласан байдлаар хэрэгжүүлж болох урьдчилсан судалгаанууд нарийн хийгдсэн. Энэ дотор бол засаглалтай холбоотой маш чухал зохион байгуулалт орж ирсэн. Энийг сая сайд ч гэсэн ярьж байна. Бид бол үндсэндээ бол энийг онцгой сайшааж байгаа юм. Мэргэжлийн хороод ажиллана. Олон нийтийн хяналтын зөвлөл ажиллана. Тийм мэргэжлийн хороод ажиллаж байгаа учраас саяын бидний бас ярьж байгаа, урьд нь бас тулгамдаж байсан янз янзын бэрхшээлүүд байгаад байгаа шүү дээ. Энийг бол бид даван туулна л гэж байгаа юм. Тэгэхээр энэ даван туулах боломж бол энэ хуульд бол өөрт нь бол байгаа. Үүний зохион байгуулалт нь бол өөрөө мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөл гэж. Сая та бас хэлж байна. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт хөрөнгийг удирдахад энэ хороо, зөвлөл бол их онцгой үүрэгтэй. Тэгэхээр энэ хороог бид байгуулаад, зөвлөлийг нь байгуулж байж саяын менежментийг сайжруулна гэдэг том зорилт тавьчихсан шүү дээ. Энэ чинь стратеги байхгүй юу үндсэндээ. Тэгэхээр энийг бид нар хэрэгжүүлж чадна л гэж ойлгож байгаа. Яах вэ явцад нь бол ахиад бид энийг илүү боловсронгуй болгох чиглэлийн шинэчлэлүүд хийгдэж болно. Тэртээ тэргүй шинэчлэл бол байнга л хийгдэж л байдаг юм чинь. Тэгэхээр сая бол бас та мэдээлэл өгсөн. Яг энэ хороо болон зөвлөлийг байгуулах ажил яг ямар түвшинд байгаа талаар та бас ахиад жоохон дэлгэрэнгүй мэдээлэл өгөөдөх үү. Энэ талаар бол бас Байнгын хорооны гишүүд маань их тодорхой мэдээлэлтэй болчихвол .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Үндэсний зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах энэ асуудлаар Байнгын хорооны ажлын алба Отгон зөвлөх хариулъя. 2 дугаар микрофон дээр.

**М.Отгон:** Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд бол зөвлөлийн ажил олгогч, даатгуулагчаас сонгогдох хүний нээлттэй сонгон шалгаруулалтыг холбогдох Байнгын хороо батална гэж заасны дагуу энэ сонгон шалгаруулалтын журам батлахаар орж байгаа. Хуулиараа бол ажил олгогч, даатгуулагчийг сонгон шалгаруулалтыг тухайн нэр дэвшүүлэгч байгууллагын гүйцэтгэх удирдлага нь өөрөө сонгон шалгаруулах баталсан журмын дагуу явуулаад, Улсын Их Хуралд ирүүлнэ. Нийгмийн бодлогын байнгын хороо ирүүлсэн материалыг нэр дэвшигчийн сонсгол хуулийнхаа дагуу сонсгол хийгээд, нэр



дэвшигдсэн хүнийг Байнгын хороо Их Хурал руу оруулахаар ийм процессын асуудлыг бид нар хуульчилсан байгаа.

**Л.Энхнасан:** Одоогийн байдлаар шинэчлэгдэх, өөрчлөгдөх гишүүд байгаа юу гэдгийг бүр тодорхой асууж байх шиг байна. Зулпхар гишүүн тодруулъя.

**С.Зулпхар:** Сонгон шалгаруулахтай холбоотой ер нь процедурыг нь бол мэдэж л байна л даа. Би зүгээр хугацаа товловол хэзээ вэ л гэж асууж байгаа юм. Хэзээ сонгон шалгаруулаад, хэзээ гишүүдээ бид сонгох вэ гэсэн ийм их тодорхой асуулт юм байгаа юм шүү. 2 дугаар микрофоныг өгнө үү.

**М.Отгон:** Хуулиараа бол сонгон шалгаруулалтыг тухайн ажил олгогч, даатгалыг төлөөлсөн олонхыг төлөөлсөн байгууллага нь нээлттэй сонгон шалгаруулалтыг олон нийт, хэвлэл мэдээллээр олон нийтэд зарлана. Цахимаар зарлана. Энэ цахимаар зарлаад нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулсны дараа энэ процесс нь явагдах юм. Одоогийн байдлаар бол нийгмийн даатгалаас 1 хүн дахин нэр дэвшүүлэхээр хүлээгдэж байгаа.

**Л.Энхнасан:** Хугацаа. Яг энэ ондоо багтаад өөрчлөх үү.

**М.Отгон:** Энэ ондоо багтааж журмаа батлаад, сонгон шалгаруулалтаа явуулна гэсэн үг.

**Л.Энхнасан:** Ажлын албаны дарга Банзрагч. 5 номер микрофоныг өгнө үү

**Г.Банзрагч:** Зулпхар гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагч, ажил олгогчийг төлөөлсөн 6 гишүүний маань 1 гишүүн Сүхбаатар гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон байж байгаа. Үлдсэн 5 гишүүний бүрэн эрхийн хугацаа бол дуусгавар болоогүй. Одоо томилогдоод 3 жил гаруй болоод хугацааны хувьд бол явж байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Энэ байнгын хороо дээр энэ Төр-Од гээд гишүүн ямар ч харьяалалгүй болсон. Энийг сольж өгнө үү гэсэн тийм хүсэлт ирсэн байгаа. Тэгэхээр энийг энэ жилдээ өөрчилнө гэж ойлгож болох уу. 1 дүгээр асуултад сайд хариулах уу.

**Л.Энх-Амгалан:** Банзрагч хариулчих. Нөгөө сая өнгөрсөн 7 хоногт хуралдсан Үндэсний зөвлөл дээр хийсэн мэргэжлийн холбооны сонгон шалгаруулалт, олон нийтийн хяналтын хороонд ажиллах хүмүүсийн сонгон шалгаруулалтынхаа явцаар товчхон мэдээлэл өгчих. Тэдэн хүнээс тэдэн хүн сонгогдсон, ингэсэн гээд. Сонгон шалгаруулалтуудаа яаж зохион байгуулсан, хэдэн хүн орсон. Ямар хэлбэрээр хийгдсэн, одоо яг хэдэн хүн сонгогдсон. Ямар ямар хүн сонгогдсон гээд нэрсийг нь бас хэлчихвэл зүгээр байна. Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын хороо 2-ыг. Ер нь олон нийтэд мэдээлнэ гэж би хэлсэн шүү дээ. Тэр мэдээллүүдээ тавьсан биз дээ.

**Л.Энхнасан:** 5 дугаар микрофон өгнө үү.

**Г.Банзрагч:** Хуульд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалтыг бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэгээд яам болон НДЕГ-ын цахим хуудсаар бол

нээлттэй зараа явуулсан. Зарын хугацаанд хангалттай материал бас хүрэлцэж ирээгүй учраас зарыг бол 2 удаа дахин сунгаад, ингээд нийтдээ 17 хүний материал ирснээс бол 2 иргэний материал шаардлага хангаагүй гэдэг дүгнэлтээр бол хасагдсан байж байгаа. Өнгөрсөн 11 сарын 8-ны өдөр бол Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хуралдаад, Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдээ нээлттэй хэлэлцээд, сонгосон байж байгаа. Мэргэжлийн хорооны гишүүнээр бол нийт 9 иргэн томилогдсон. Доржийн Далхжав, Бямба .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт минут. 5 дугаар микрофон.

**Г.Банзрагч:** Бямбажавын Энх-Амгалан, Готовын Отгонсүрэн, Ганбаатарын Батхуяг, Чимэдгочоогийн Өнөржаргал, Цогоогийн Дашдондог, Зандангийн Ядмаа, Галаагийн Бурмаа, Энх-Амгалангийн Сүхбаатар. Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдээр бол Шагайгийн Хонгорзул, Батхүүгийн Мөнхханд, Гандангийн Ганчимэг, Цогоогийн Дашдондог, Зандангийн Ядмаа, Содовын Ариунаа, Пүрэвийн Баянсан гэсэн гишүүд бол томилогдсон байж байгаа. Тэгээд бид нар бол өнгөрсөн Мягмар гарагт бол анхдугаар хуралдаанаа хийгээд, дүрэм журамд заасны дагуу анхдугаар хуралдаанаараа тус мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөлүүд бас даргаа сонгосон байж байгаа. Маргааш бас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр бас сайдтай уулзалт хийхээр товлоод, бас олон нийтэд нээлттэйгээр уулзалтаа хийгээд, мэдээллээ хүргэхээр бас төлөвлөөд ажиллаж байгаа.

**Л.Энхнасан:** Зулпхар гишүүн тодруулъя.

**С.Зулпхар:** Баярлалаа. Би тодруулга биш бас яах вэ зүгээр үг хэлчихье. Энэ их чухал юм болж байгаа гэдгийг зориуд дахин тэмдэглэмээр байна. Сая бид нар бас ярьж байна. Энэ нөгөө мэргэжлийн удирдлагагүй байснаас болоод улс төрийн нөлөөлөлд Үндэсний зөвлөл автчихсан юм уу, эсвэл зарим зүйлээ мэдсэн, мэдээгүй байдлаар шийдвэр гаргасан. Тэр нь өнөөдөр янз янзын үр дагавар дагуулчихсан. Санхүүгийн гэдэг юм уу, менежментийн гэдэг ч юм уу. Энийг бид ер нь даван туулна. Одоо бол жишээ нь би бас талархалтай байна. Сайд бол мэргэжлийн хороод болон хяналтын зөвлөлийг маш шуурхай байгуулж байгаа юм байна. Яг энэ чиглэлээр энэ ажил яваад саяын бидний зарим гаргах гэж байгаа, хүлээгдэж байгаа шийдвэрүүд гээд байна шүү дээ. Тэр шийдвэрүүд бол аяндаа бол хэрэгжээд явах байх. Тэрнээс гадна яах вэ, цаашдаа хийх тэр өөрчлөлтийг бол хэрвээ шинэ саналууд өөрчлөлт яриад байна шүү дээ. Саяын мэргэжлийн хороод болон хяналтын зөвлөлүүд ажлаа тодорхой хугацаа гаргаад, ямар үр дүн гарч байгаагаас нь шал шалтгаалж бас хийхгүй бол шууд өнөөдөр шинэчлэл хийхээд, маргааш ахиад нэг юм шинэчилнэ .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Баярлалаа. Үг хэллээ. Мөнхтуяа гишүүн асуултаа асууна уу.

**Ц.Мөнхтуяа:** Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн шалгаруулах шаардлага дээр ийм юм байгаа юм. Хууль, эрх зүй, санхүү эдийн засаг, удирдахуйн ухаан, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр бакалавр ба түүнээс дээш боловсролтой гээд заачихсан байна. Энэ нь өөрөө Үндсэн хуулийн ажил мэргэжлээр нь ялгаварлах энэ зарчмыг зөрчсөн харагдаж байна. Үндсэн хууль зөрчсөн харагдаж байна шүү. Яагаад энэ даатгуулагчид эмч, багш,

уурхайчин, жүжигчин гэх мэт мэргэжлийн төлөөлөл байж болоогүй юм бэ. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал нь даатгуулагчийг төлөөлнө гэхээр заавал яагаад МҮЭХ-ноос гишүүн ороод байдаг юм. Энэ ямар учиртай юм бэ гэдгийг бас тодруулж асуумаар байна.

3 дугаар асуудал нь болохоороо олон нийтийн хяналтын зөвлөл бол маш чухал. Гэтэл энэ олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулахдаа нөгөө үндэсний зөвлөл нь авчхаж байна шүү дээ. Тэгэхээр яаж хянах вэ. Яаж олон нийтийн хяналт болох вэ. Энэ дээр нэг тийм зөрчил харагдаад байгаа юм шиг санагдаад байх юм. Тэгэхээр энэ дээр бас тайлбар сонсьё гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Сайдын микрофоныг өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Олон нийтийн хяналтын зөвлөлийг яагаад Үндэсний зөвлөл нь шалгаруулсан бэ гээд байх шиг байна л даа. Одоо ингээд энэ чинь хэн нэгэн сонгон шалгаруулалт хийхээс өөр арга байхгүй шүү дээ. Тэгээд яг юугаараа нөгөө бид нарын хийсэн баталсан хуулиараа үндэсний зөвлөл нь олон нийтийн хяналтын зөвлөл, мэргэжлийн хороогоо байгуулна гэсэн ийм л хуулийн зохицуулалттай учраас л ингэж хийсэн. Тэгээд ерөнхийдөө сая яаж зохион байгуулсныг нэлээн л мэдээлэл өгчих шиг боллоо л доо. Ер нь бүх Байнгын хорооны гишүүдэд Банзрагчаа бүх Байнгын хорооны гишүүдэд сонгон шалгаруулалт хийсэн процесс, тэр бүх юунуудтайгаа мэдээлэл, тэгээд нөгөө сонгон шалгаруулагдсан мэргэжлийн хороонд сонгон шалгаруулалтад тэнцсэн, мөн олон нийтийн хяналтын зөвлөлд тэнцсэн хүмүүсийнхээ бүх дэлгэрэнгүй мэдээллүүдийг бүгдийг нь нэгтгээд өгчих.

Тэр яагаад ганцхан МҮЭ энэ Үндэсний зөвлөлд орох ёстой гэдэг чинь бол угаасаа хуулийн зохицуулалттай. Хөдөлмөрийн хуулиар заачихсан 3 талт хэлэлцээрт орох энэ эрх бүхий байгууллагууд ингээд тодорхойлогддог. Тэгээд би бол хэлээд байгаа шүү дээ Мөнхтуяа гишүүн ээ. Мөнхбаатар та хоёрыгоо бол би маш их дэмждэг. Тийм учраас та бүхэн аль болохоор ер нь бол энэ хэлэлцээрт ордог, 3 талын хэлэлцээрт ордог нэг ийм байгаач ээ. Энэ 2 үйлдвэрчний эвлэл нэгдээд хамтраад ингээд ажиллаач. Та бүхэн бол бүгдээрээ л нэг эрх ашгийн төлөө явж байгаа. Тийм учраас бол нэг жаахан тийм урагшаа харсан ийм бодлоготой байгаач. Багш нарыгаа битгий хуваагаач ээ. Тэгээд намынх нь харьяаллаар, үзэл бодлоор нь тийм ээ. Тийм учраас нэгэнт л багш нарын боловсролын байгууллагын эрх ашгийн төлөө явж байгаа үйлдвэрчний эвлэл аль болохоор дуу хоолой нэг байгаасай. Үүний төлөө би дуу хоолой нэг байлгахын төлөө өөрөөсөө шалтгаалах бүхнээ бас хийж ирсэн. Цаашдаа ч гэсэн Үндэсний хорооны даргын хувьд бол бас энэ оролцоог хангах хэмжээнд нэлээн санал санаачилгатай ажиллана л гэдгээ хэлье.

**Л.Энхнасан:** Мөнхтуяа гишүүн.

**Ц.Мөнхтуяа:** Ерөнхийдөө би энд оръё гээд байгаа юм биш л дээ. Монголын багш нарын үйлдвэрчин энд оръё гээд байгаа юм биш. Ер нь үйлдвэрчний эвлэл гээд л нэг байгууллага байгаад байдаг. Өчнөөн 100 жилийн түүхтэй л гээд гайхуулаад байдаг. Тэгээд үнэхээр яг энэ үйлдвэрчний эвлэлийн байгууллага энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын үндэсний

зөвлөлд ороод зөв зүйтэй ямар ажил санаачилж хийгээд энд ямар ноорхойг илрүүлээд шударга ажилласан юм бэ гэдгийг бас асуумаар байгаа байхгүй юу. Тэгээд л нэг юм болонгуут л дандаа МҮЭХ-ны төлөөлөл. Ийм монопол байгаа болио л гэж байгаа юм. Тэрнээс би оръё гээгүй шүү.

**Л.Энхнасан:** Сайд тайлбар хэлнэ үү.

**Л.Энх-Амгалан:** Манай 2 үйлдвэрчний эвлэл хамтарч ажиллах ёстой байх.

2-т бол манай Байнгын хороо дээр чинь Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль орж ирж байгаа шүү дээ. Ариунзаяа гишүүнээр ахлуулаад, энэ хууль орж ирж байгаа. Тийм учраас энэ хууль дээр та бүхэн сууж энэ тогтолцооныхоо асуудлуудыг зөв тодорхойлж, цаашаа оролцооныхоо асуудлыг ч гэсэн энэ хуулиар нэлээн ойлгомжтой болгох болов уу. Энэ дээр та бүхэн бас нэг санал санаачилгатай ажиллаасай гэж би хүсэж байна.

**Л.Энхнасан:** Ер нь бол энэ үйлдвэрчний эвлэл, эвлэлүүд хоорондоо бас холбоотой хамтарч ажиллах нь зүйтэй шүү. Ингээд энэ дээр бас анхаарна биз.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Үг хэлэх гишүүн байна уу. Журам дээр хэлэхгүй. Тэгвэл түрүүн гишүүдээс гарсан нэмэлт, өөрчлөлтийг оруулъя гэсэн редакцын өөрчлөлттэй, найруулгын өөрчлөлттэйгөөр журмыг өөрчлөлт оруулъя гэсэн дээр хамгийн эхлээд санал авсан нь зүйтэй байх. Ажлын хэсгээс Батжаргал дарга хариулъя. 1 дүгээр микрофон.

**Б.Батжаргал:** Гишүүний тодруулгад бас хариулт өгье. Энэ юун дээр бол яах вэ хуучин дүрэм дээр бол бас байсан. Тэгээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн бол Нийгмийн даатгалын сантай холбоотой нэлээн томоохон шийдвэрүүд гаргадаг. Энэ жилийн хувьд бол жишээлбэл манайх бол 5,7 их наядын зарлага гаргаж байна. Тэгээд ийм учраас бас мэргэжлүүдэд нь бас байвал зүйтэй гэж үзсэн. Ер нь бол ямар ч албан тушаалын тодорхойлолт дээр бол тухайн хүний мэргэжлийг нь бас зааж өгдөг. Тэгэхээр бол багшийн мэргэжил дээр бол жишээлбэл яг ийм хүн байна гэдгийг заадаг, жишээлбэл миний албан тушаал дээр бол эдийн засагч байх тухай заадаг. Тэгэхээр яг энэ зарчмаа бариад энэ дүрмийн төсөл дээрээ ийм мэргэжлийн хүмүүс байвал зүгээр байна гэсэн ийм заалтыг оруулж өгсөн. Бусад бас Үндэсний зөвлөлийн дүрэм дээр бас энэ шаардлага бас нийтлэг байдаг юм байна лээ. Тэгээд бид нар бас бусад дүрмүүдийг дүрмийн төслийг бас судлаад, дүрмийг судлаад энэ заалтыг оруулсан. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Нээлттэй юм байна гэж ойлголоо. Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах журам батлах тухай тогтоолын төслийг дэмжье гэсэн саяын гишүүдээс гарсан саналуудыг оролцуулаад тэгээд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт хийе.

Төхөөрөмж ажиллаагүй юу. Тэгвэл горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгохоор санал хураалт хийе. Тэгье энэ дээр хэлүүлчихье. Би өөрөө хэлчихсэн болохлоор. Хүчингүй болгох горимын санал дэмжигдсэн учраас дахиад тогтоолын төслийг гишүүдийн саналыг оруулаад гэсэн саналын томъёоллоор

санал хураалт дахин явуулъя. Дахиад санал хураалт. Хуралд оролцсон гишүүдийн 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Зулпхар гишүүн дэмжсэн. Мөнхтуяа гишүүн дэмжсэнээр тооцно уу. Баярлалаа.

13.40 цаг.

Дараагийн асуудал байгаа. Ажлын хэсэгт баярлалаа.

**Дараагийн асуудалд оръё. “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.4-д “Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн зөвлөлийн дарга дүрмээ шинэчлэн батлуулахаар ирүүлсэн байгаа. Үүний дагуу дүрмийн төслийг хэлэлцэж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулна уу. Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Өнөөдөр Мөнхсайхан сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга маань Сонгинохайрханд томуугийн вакцинтай холбоотой ажилтай байгаа учраас ирж чадахгүй болсон. Тийм учраас Очирбат дарга өнөөдөр танилцуулна.

Алтанхуяг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Баясгалан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Зоригоо Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Одонгуа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Гэрэлмаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Сарантуяа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, Хишигсүрэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны аудитор, Нямдаваа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны ажилтан.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүн Алтанхуяг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийн төслийг танилцуулах юм байна. 7 номерын микрофоныг өгнө үү.

**Б.Алтанхуяг:** Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, гишүүд ээ, та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгая.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14<sup>1</sup>.4-д “Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлуулахаар та бүхэнд танилцуулж байна.

Нэг.Дүрмийг шинэчлэн батлуулах үндэслэл, шаардлагын талаар:

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2015 онд батлагдсанаас хойш нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт оруулаад байна. Их Хурлаас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулиар санхүүгийн салангид эх үүсвэрүүд болох улсын төсвөөс хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэсэн. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хэлэлцэх асуудлын хүрээ, шийдвэр гаргах Үндэсний зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага үүссэн. Тухайлбал,

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох жагсаалтын нэр төрөл, даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг батлах,

2. Даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах,

3. Мэргэшсэн шинжээч, судлаачдаас бүрдсэн техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар шийдвэр гаргах заалтууд тус тус шинээр нэмэгдсэн.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын ангилал зэрэглэлийг төрийн захиргааны ангилал зэрэглэлд хамруулах, цалин хөлсийг төрийн захиргааны албан хаагчтай дүйцүүлэн олох эсэх асуудлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт хийх замаар шийдвэрлэхийг Засгийн газарт чиглэл болгосон.

Улсын Их Хурлын Тамгын газраас Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022-2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээ болон Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд ажлын албаны бүтэц, үйл ажиллагаа, хүний нөөцийн тогтвортой байдалд анхаарч, ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх талаар удаа дараа зөвлөмж өгсөн байдаг.

Улсын Их Хурлын 2023 оны 27 дугаар тогтоолоор шинээр томилогдсон Үндэсний зөвлөлийн гишүүд нь мөн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тус тус гаргасан болно.

Хоёр. Дүрэм боловсруулах үйл явцын талаар:

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг 2017 онд батлагдсанаас хойш 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм нь нийт 6 бүлэг, 33 хэсэг, 29 зүйл, заалттайгаар хэрэгжиж байна. Та бүхэнд танилцуулж байгаа шинэчлэлийн дүрмийн төсөлд энэхүү дүрмийн 23 заалтыг өөрчлөн найруулж, 17 заалтыг шинээр нэмж, 25 заалтыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон өөрчлөлттэй холбогдуулан хасаж, давхцал хийдлийг арилган боловсрууллаа.

Дүрэмд Үндэсний зөвлөлийн гишүүдээс 4 удаагийн санал авч, Эрүүл мэндийн яамны саналыг тусган гишүүдэд 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион

байгуулсан. Дүрмийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, журмын төслийг Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэн бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанаар өнгөрсөн 7 хоногт хэлэлцүүлсэн болно. Үндэсний зөвлөл нь байгуулагдсан цагаасаа хойш нийт 64 удаагийн хуралдаанаар 176 асуудлыг хэлэлцэж, 137 тогтоол баталж, 26 Захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгүүлж, өнөөгийн байдлаар Үндэсний зөвлөлийн 25 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Гурав.Дүрмийн төсөлд орсон гол өөрчлөлтийн талаар:

Эрүүл мэндийн салбарт 2021 оноос хэрэгжиж эхэлсэн хуулийн шинэчлэлийн хүрээнд Үндэсний зөвлөлийн хэлэлцэх асуудал, шийдвэр гаргалтын цар хүрээ, хариуцлага нэмэгдсэнтэй холбоотойгоор Үндэсний зөвлөлийн хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, мэргэшсэн шинжээч, судлаачдын дүгнэлт, зөвлөмжид үндэслэн шийдвэр гаргах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны талаар иргэд, даатгуулагчдад нээлттэй мэдээлэл өгөх зэрэг эрх, үүргийг өргөтгөсөн.

Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарах бөгөөд цалингийн сүлжил, албан тушаалын ангилал зэрэглэл зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байнгын ажлын албатай дүйцүүлэн Үндэсний зөвлөл тогтоохоор мөн тусгалаа.

Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Энэхүү дүрмийг шинэчлэн баталснаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, түүний ажлын албаны эрх, үүрэг илүү өргөжиж, Эрүүл мэндийн даатгалын хууль, тогтоомжийн хяналт, биелэлтэд хяналт тавих хяналт сайжирч, Эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талууд болох Засгийн газар, ажил олгогч, даатгуулагчийн тэгш оролцоог хангаж, нотолгоонд үндэслэсэн бодлогын шийдвэрүүд гарч, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй, хариуцлагатай болж, иргэд, олон нийтийн байгууллагын идэвх оролцоо нэмэгдэнэ хэмээн үзэж байна.

Та бүхэн дүрмийн төслийг хянан үзэж батлахыг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Үг хэлэх гишүүд бас хамтдаа. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна уу.

**Б.Бат-Эрдэнэ:** Энэ өдрийн мэнд хүргэе. Дүрмийг уншсан . Дүрмийн 1.3 дээр Үндэсний зөвлөлийн баримтлах зарчимтай холбоотой асуудлуудыг оруулсан байгаа. Энэ дээр хэд хэдэн санал байна. Санал хамт гэсэн учраас.

Хууль дээдлэх, шударга, мэргэжлийн ёс зүй гэдэг утга агуулгыг оруулж болох уу. Ялангуяа хууль дээдлэхтэй холбоотой асуудал бол энэ хуулийн хэрэгжилт сүүлийн үед маш хангалтгүй байгаад байна л даа. Тэгээд энэ хууль дээдлэх зарчмаа бид нар сүүлдээ болохгүй бол энэ дүрэм, журам дээр оруулж өгөхгүй бол цаашдаа энэ хууль гэдэг зүйл өөрөө ямар түвшинд ч очих юм. Ялангуяа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн маань дүрэм дээр энэ шударга ёс,

шударгатай холбоотой асуудлууд их зөв орох ёстой. Мэргэжлийн ёс зүйг их сайн зөв оруулж өгөх нь зөв болов уу гэж бодож байгаа. Тэр 2.7 дээр санал авахаар заасан бол гэдэг л утга юм шиг байна. Тэгээд “заасаг” бол гээд биччихсэн юм байна лээ. Тэр алдаагаа засна биз. Үндэсний зөвлөлийн үүрэг дээр би бас сая Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн асуудал дээр бас хэлсэн. Энэ бодлого стратеги боловсруулах үүргийг оруулж өгмөөр байна. Хууль дээрээ байдаг байх. Гэхдээ боловсруулах үүргийг оруулахгүй болохоор Үндэсний зөвлөл зөвхөн тодорхой хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хариуцсан агентлаг, яам өөрөө хийнэ гээд яваад байдаг асуудал байдаг. Үндэсний зөвлөлийн гишүүд дээр нэг эрхийг оруулж өгмөөр байна. Хөндлөнгийн үнэлгээ шаардах эрх. Энэ хөндлөнгийн үнэлгээг зайлшгүй хийлгэж байх шаардлагатай. Энийг нь Үндэсний зөвлөлийн гишүүд зайлшгүй шаарддаг баймаар байна.

Төгсгөлд нь хариуцлага дээр зүгээр энэ дүрмийг зөрчсөн хүн хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ гэдэг ийм ганцхан заалт оруулчихсан. Тэгээд энэ хариуцлагын асуудал чинь олон хариуцлага байгаа шүү дээ. Тэгээд зөвхөн хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгээд явна гэхээр маш бүрхэг байна л даа. Тэгэхээр энэ хариуцлагын асуудлыг жоохон задалж өгөх боломж байгаа юу. Хүлээлгэх хариуцлагыг маш ойлгомжтой зааж өгвөл Үндэсний зөвлөл маань, гишүүд маань өөрсдөө бас хариуцлагатай ажиллах болов уу. Эргээд та бүхний эрхэлж байгаа ажил, үүргийн хувьд бас бусад зүйлүүд маань бол нэлээн хариуцлагажих болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр хариулт авъя.

**Л.Энхнасан:** Алтанхуяг 7 дугаар микрофон хариулт өгнө үү.

**Б.Алтанхуяг:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд бол яах вэ хууль дээдлэх болон мэргэжлийн ёс зүй, шударга ёстой холбоотой асуудлууд бол бий. Гэхдээ мэдээж энэ дүрэм бол ажлын алба болон зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдож байгаа учраас энэ асуудлыг бас тэмдэглэлд тусгаад өөрчлөлт оруулахад бол татгалзах зүйлгүй.

2.7 бол тэр заасан гэдэг техникийн асуудлыг бол хүлээн зөвшөөрч байна.

Бодлого боловсруулах чиг үүргийн хувьд бол яах вэ, бид бол хууль тогтоомжид харьцангуй манай Эрүүл мэндийн даатгалын тухай хууль маань 2015 онд батлагдсан. 8 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ 8 удаагийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор яах вэ Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа процессын асуудлууд бол харьцангуй хуульдаа орчихсон байсан юм. Хуульдаа орчихсон байгаа учраас бид нөгөө Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулчихсан харилцааг журмаар зохицуулахгүй гэдэг асуудал бас ажлын хэсгийн 2 ч удаагийн хуралдаан дээр яригдсан учраас орхигдчихсон. Үнэхээр шаардлагатай гэвэл бас энэ асуудлыг оруулах боломжтой.

Тэр хөндлөнгийн үнэлгээ хийлгэх эрхийг бол энэ асуудлыг бодлогын хувьд бол дэмжиж байна. Хариуцлагын асуудал бас түрүүний хэлсэн Эрүүл мэндийн даатгалын тухай хууль дээр маань Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх, нөхөн сонгох, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалт нь маш тодорхой 6 заалтаар орчихсон юм. Жишээлбэл, 3 удаа хуралдаа суугаагүй бол ч гэдэг юм уу, хууль тогтоомжид заасан шүүхээр гэм буруу нь тогтоогдсон гэх мэтчилэн энэ процессын манай зөвлөлийн хувьд бол Эрүүл



мэндийн даатгалын тухай хуулиар процессын зохицуулалтууд нь нэлээн нарийн туссан учраас энэ төсөлд бол тусгаж оруулаагүй. 3 дугаар зүйлээрээ бол ерөнхий яг энэ дүрэм зөрчсөн хүн, хуулийн этгээд бол холбогдох хууль тогтоомжийн дагуу, ажлын албаны ажилтнууд бол холбогдох хууль тогтоомжоороо Үндэсний зөвлөлийн гишүүд бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан эгүүлэн татах нөхцөлтэй хариуцлагаараа явъя гэдэг ийм асуудлаар төсөлд тусгасан байгаа.

**Л.Энхнасан:** Тодруулга.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгээд яах вэ тэрийг ойлгоод л байна л даа. Би яах вэ зүгээр яагаад энийг дахин дахин яриад байна гэхээр танайх ингээд биччихсэн байгаа байхгүй юу. Энэ дүрмийн зорилго нь Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажиллах зарчим, бүрэн эрх, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлоход оршино л гэдэг ийм дүрэмтэй. Эргээд жишээлбэл Эрүүл мэндийн даатгалын сан, холбоо бүхий асуудал дээр тэгвэл үндэсний зөвлөлийн гишүүдээс хариуцлага хүлээсэн зүйл байгаа юу. Энэ маш тодорхой байх ёстой байхгүй юу.

Үндэсний зөвлөлийн гишүүд барьж ажиллаж байгаа дүрэм маань бид нар дүрмээрээ ажилладаг л гэдэг энэ зүйлийг яриад байгаа юм. Тэгэхээр хуулиараа та бүхэн олгогдсон нөгөө талдаа тогтоогдож байгаа хариуцлагын асуудал бол энэ дээр зайлшгүй хөндөгдөж байгаа.

**Л.Энхнасан:** Ажлын хэсгээс хариулт өгнө. 7 дугаар микрофон.

**Б.Алтанхуяг:** Өмнөх яг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар бол хариуцлагын асуудал явж байсан тохиолдол бол хараахан бол байхгүй. Ер нь бол яах вэ зүгээр Бат-Эрдэнэ гишүүний гаргаж байгаа саналтай зарчмын хувьд бол санал нийлж байна. Мэдээж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд бол хариуцлагатай, ёс, зүйтэй, шударга ажиллах нь бол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаас томилогдоход ч гэсэн ийм шаардлагуудыг тавьж байгаа. Зүгээр Хууль тогтоомжийн тухай хуулиар хуульд нэгэнтээ хариуцлагын асуудлыг зохицуулчихсан байгаа учраас дүрэмд техникийн хувьд шийдэх нь өөрөө Хууль тогтоомжийн тухай хуулийн үндсэн зарчмыг зөрчиж байгаа юу, үгүй юу гэдэг асуудал бол яригдаад байгаа юм.

Ер нь бол яах вэ яг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг энэ хариуцлага тооцох чөлөөлөхтэй холбоотой зохицуулалт бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.11.1-14.11.6 хүртэл 6 зохицуулалтаар бол .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Очирбат дарга хариу хариулах уу. Ганмаа гишүүн асуултаа асууна уу.

**Д.Ганмаа:** Ярьчих уу. Эсвэл Бат-Эрдэнэ гишүүн дуусгах уу.

**Л.Энхнасан:** Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Очирбат дарга 9 дүгээр микрофон.

**Д.Очирбат:** Би бас Төрийн нарийны зүгээс энд хариулах нь их зохимжтой бус байх л гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Тодруулах уу.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгээд яах вэ, хууль тогтоомжид заасныг ойлгоод байгаа л даа. Зүгээр нөгөө ганцхан л өгүүлбэр байгаад байгаа юм. Тэгэхдээ энэ хууль тогтоомжид заасан хариуцлагыг л хүлээлгэхээр энэ дээр орчхоод байгаа юм л даа. Мэдээж хууль зөрчвөл хариуцлагын асуудал хөндөгдөнө. Дээрээс нь Эрүүл мэндийн даатгалын тухай хууль дээр заасан заалтууд бол угаасаа хэрэгжих ёстой. Тэр дээр нарийвчлаад заачихсан гэдгийг ойлгож байгаа. Би нөгөө нэг ёс зүйн биш ээ, нөгөө юуны дүрэмтэй холбоотой асуудал дээр л гишүүдтэй холбоотой асуудлыг л хөндөөд байгаа байхгүй юу. Жишээлбэл, хариуцлагын асуудал дээр бид нар энэ гишүүд дээр ажлын үнэлгээтэй холбоотой асуудлууд зайлшгүй хөндөх ёстой асуудлуудын 1 мөн шүү дээ. Тэгээд энийг хуульд заавал зааж өгсөн байх ёстой юм уу. Энэ ажлын үнэлгээ дээр жишээлбэл тухайн зөвлөлийн гишүүн үүрэгт ажлаа чанартай цаг хугацаанд нь биелүүлж байгаа эсэхийг тогтмол үнэлэх үнэлгээ байгаа юм уу. Яг өнөөдрийн түвшин дээр тэгвэл ирцийн хяналт байгаа юм уу. Хуралдаанд оролцоно, оролцохгүй гээд л явж байдаг. Гэтэл нөгөө талдаа сая нийгмийн даатгал дээр ингээд харж байхад .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 6 дугаар микрофон. Одонгуа.

**Н.Одонгуа:** Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа саналыг зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Энэ бол маш тодорхой зааж өгч байж бид нарын нөгөө хариуцлагын асуудал бол хариуцлагын мэдрэмж гэх юм уу бас нэмэгдэх тал бий. Тэгэхээр бас гишүүн өмнө нь хэллээ шүү дээ. Хууль дээдлэх, мэргэжлийн ёс зүйг баримтлах гээд. Ялангуяа энэ мэргэжлийн ёс зүйн асуудалтай холбоотой хариуцлагыг өндөрсүүлж байж, тодорхой яг хариуцлагын дүрэмд тусгасан яг энэ чиг үүргийн дагуу хариуцлага хүлээх зүйлийг оруулах нь зүйтэй гэж бас хувьдаа бол дүгнэж байна. Тэгэхээр энэ асуудалд ялангуяа ёс зүйн асуудлууд, тэр ажил гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой хариуцлага хүлээх зүйлүүд дээр нэмэлт оруулахад бол боломжтой. Ирцтэй холбоотой асуудлууд бол Эрүүл мэндийн даатгалын тухай хууль дээр тусгасан байгаа учраас ирцийн асуудлыг бол даатгалынхаа хуулиар, бусад ёс зүйн болоод ажил гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой хариуцлагыг дүрмээр .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт, өөрчлөлтийг оруулах юм байна гэж ойлголоо. Ганмаа гишүүн асуултаа асууна уу.

**Д.Ганмаа:** Сайн байцгаана уу. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.4-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийн төсөлтэй танилцлаа. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн бас холбогдох заалтуудтай нь танилцсан. Ингээд хэдэн асуулт байна.

1 дүгээрт энэ Үндэсний зөвлөлийн эрх, үүргийг тусгаж өгсөн байна. 3 дахь хэсэгт энэ дүрэмдээ. Гэтэл Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8-д зөвлөлийн эрх, үүргийг мөн тус тус 14.9 дэх үүргийг нь, 14.8-д бол зөвлөлийн эрхийг заагаад өгчихсөн байгаа хуульдаа. Тэгэхээр зэрэг энийг ингээд сору paste маягаар яг адилхан, эсвэл ганц 2 нэмэлтээр ингээд оруулсны оронд харин дүрэм дээрээ бол энэ төсөлд нь хуульд заасан эрх, үүргийг арай дэлгэрэнгүй тусгаад, юу

гэдэг юм хуулийн дээрх зохицуулалтын дагуу хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд ямар журмаар жишээлбэл хэрхэн шийдвэрлэж байгаа юм, тус эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ яг ямар асуудлаар шийдвэр гаргах юм, тус шийдвэрийг хэрхэн хэрэгжих вэ зэрэг журмын төсөлд ийм дэлгэрэнгүй төсөлдөө тусгахыг санал гаргаж байна. Ингэснээрээ тус дүрмийн жишээлбэл 1.3-д заасан үйл ажиллагааны зарчмууд нь хангагдахаар харагдаж байна.

2 дугаарт бол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн төслийн 2.13-д яг уншихъя. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр тогтоож улирал тутамд олгоно. 2 дахь төсөл дээрээ 2.12 дээр болохоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн сарын урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож, улирал тутам олгоно гэсэн байдлаар тусгасан байна. Гэтэл Эрүүл мэндийн тухай хуулийн 14.6-д Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно гээд заасан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн төслөөс нь үзвэл Үндэсний зөвлөлийн гишүүний ажлын оролцоог хэрхэн харгалзаж байгаа буюу хэн, хэрхэн, яаж дүгнэх талаар ерөөсөө тодорхой тусгаагүй, их ерөнхий. Ажлын оролцоог харгалзан олгох урамшууллын интервал нь ямар байх нь ойлгомжгүй. Мөн хуулийн дээрх зохицуулалтыг яаж хангуулах талаар их тийм тодорхой зохицуулалт оруулаагүй учраас энийг нэмж оруулах ийм саналтай байна.

3 дугаарт Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эрүүл мэнд .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт цагийг өгье.

**Д.Ганмаа:** Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар ажлын албатай байх бөгөөд тус зөвлөл нь дүрмийн төслийн 5 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн ажлын албаны талаар зохицуулжээ. Тэгээд дүрмийн төслийн 5.3-д ажлын албаны бүтэц, орон тоог үндэсний зөвлөл батална. 5.4-д болохоор ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарах бөгөөд цалингийн сүлжээ, албан тушаалын ангилал, зэрэг дэвийг УИХ томилдог байгууллагын ажлын алдаатай дүйцүүлэн тогтооно гэж тусгасан байгаа байхгүй юу. Гэтэл тус зөвлөлөөс байгуулагдаж байгаа ажлын алба нь Улсын Их Хурлаас томилогдон байгууллагын төрөлд хамаарах эсэх нь тодорхой биш. Мөн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалуудыг төрийн захиргааны албан хаагчийн ангилалд хамааруулах төсөлд тусгасан боловч төрийн албан хаагчийн цалингийн шатлал, ангилалд хамааруулах төсөлд бас санал оруулсан эсэх нь ерөөсөө тодорхойгүй. Мөн ерөнхий.../минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт цаг өгье.

**Д.Ганмаа:** Мөн тус ажлын албаны ямар орон тоотой байх нь тодорхойгүй, чиг үүрэг, ажил үүрэг нь ийм дэлгэрэнгүй бас л тусгамаар байгаа байхгүй юу. Их ерөнхий болоод байна. Ингээд 4 дээр болохоор Эрүүл мэндийн үндэсний

зөвлөлийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн сэргийлэх вэ. Энийг би түрүүн өмнөх асуудал дээр бас хэлсэн. Адилхан асуулт.

5 дээр болохоор Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн гишүүдийн эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хариуцлагын талаар бас энэ дүрэм дээр би тусгуулах саналыг дэвшүүлж байна.

**Л.Энхнасан:** Ажлын хэсгээс Алтанхуяг дарга хариулна уу. 7 дугаар микрофон. Нэмэлт цагийг нь хамт өгөөрэй.

**Б.Алтанхуяг:** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8 болон 14.9-д заасан бүрэн эрхтэй холбогдуулж түрүүнд мөн хэлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулиар тодорхой заалтуудыг бол бид нар бол хасаж, өөрчлөн найруулалд бол хийсэн байгаа. Үндэсний зөвлөлийн эрх, үүрэгтэй холбоотой манай дүрмийн төсөлд бол илүү нөгөө процесстой холбоотой зохицуулалтуудаа бид бол ажлын хэсэг дээрээ ярилцсан. Мөн Байнгын хороо болон Улсын Их Хурлын тамгын газраас томилогдсон ажлын хэсэгтэй бас энэ асуудлыг зөвшилцөөд илүү процесс буюу тэр хууль тогтоомжид заасан 14.8 болон 14.9 дэх заалтуудыг хэрэгжүүлэх үйл явцдаа хэрхэн анхаарах вэ гэдэг асуудлыг бол оруулсан байгаа.

Урамшууллын хувьд бол Ганмаа гишүүний саналтай бол санал нэгтэй байна. Ер нь бол яах вэ, хуулиар бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар дээд хязгаарыг нь тогтоож байгаа. Мэдээж тодорхой ажил үүрэг гүйцэтгэж байгаа учраас Хөдөлмөрийн тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд хөдөлмөрийн хөлсний хамгийн бага хэмжээгээрээ тогтоогоод олгож байгаа процесс нь бол улиралдаа явъя. Харин Ганмаа гишүүний саяын хэлдэг оролцоо болон хүлээж байгаа үүрэг, хууль тогтоомжийн биелэлтэд хэрхэн оролцсон юм бэ гэдэг үр дүнд суурилсан Ки Пи Ай-ын асуудлыг бол ажлын албан дээр бол хэрэгжүүлээд явахад бол энд бол боломжтой зүйл байгаа.

Дараагийн асуудал энэ ашиг сонирхолтой холбоотой асуудал бол бид Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүний хувьд бол анх сонгон шалгаруулж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар томилогдохоос өгсүүлээд ашиг сонирхлын болон бүх мэдүүлгүүдээ, хөрөнгө оруулгын мэдүүлгүүд, жил тутамд ашиг сонирхолтой холбоотой асуудлуудаа АТГ-т бол мэдэгдээд явж байгаа. Зүгээр тэр түрүү Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг тэр мэргэжлийн ёс зүйтэй холбоод холбогдуулж энэ ашиг сонирхлын асуудал бол түрүүнд Байнгын хорооны дарга бол энэ асуудлыг нэмж томъёолж тусгая гэсэн учраас үүнтэй холбогдуулж оруулж болох байх.

Ажлын албатай холбоотой зохицуулалт бол энэ дүрэм дээр байгаа төсөл дээр байгаа тэр нэг гол асуудал нь ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарах бөгөөд цалингийн сүлжээ албан тушаалын ангилал, зэрэглэлд зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын ажлын албатай дүйцүүлэн тогтооно гэдэг нь өмнөх 2 удаагийн Үндэсний аудитын тайлан болон 2022-2023 оны Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал дээр хэлэлцэгдээд энэ зөвлөмж чиглэл нь ирчихсэн юм байна лээ. Тэгээд яг өнөөдрийн байдал дээр бол манай ажлын албаны ажилтнуудын ялангуяа эрх зүйн статус буюу эрх зүйн байдлын асуудал нь ойлгомжгүй. Үүнээс хамааруулаад хариуцлагын асуудал бас ярьж болдоггүй. Ийм төвөгтэй байгаа учраас бид ямар ч байсан энэ удаагийн дүрмийн шинэчилсэн найруулга дээрээ

бол ялангуяа энэ ажлын албаны хариуцлагыг тодорхой болгох 1 дүгээрт, 2 дугаарт статусыг тодорхой болгох, цалингийн энэ сүлжил асуудлыг нь бол тодорхой болгох зорилгоор бол дүрмийн төсөл дээр оруулж ирсэн байгаа. Энэ дүрмийн төсөл батлагдсанаар бид бол цаашдаа Төрийн албаны зөвлөлд бас энэ асуудлаараа саналаа хүргүүлэх юм. Аудитын зөвлөмж болон өмнөх Байнгын хороонуудаас өгсөн зөвлөмжүүд дээр бол энэ асуудал тусгагдчихсан байгаа учраас орж ирсэн байгаа.

5 дахь нь юу билээ.

**Л.Энхнасан:** 5 дахь асуудалд Одонгуа хариулах уу. 6 дугаар микрофон.

**Н.Одонгуа:** Ганмаа гишүүний асуултад бол сая Алтанхуяг ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд бол бүрэн хариулсан. Яах вэ, нэмж хариулах гол нэг зүйл юу байсан бэ гэхээр ажлын албаны яг хариуцлага өнөөдөр бол бид нар бүрэн ямар эрх зүйн хүрээнд ажлын албыг ажиллуулах, гүйцэтгэлийг нь хэрхэн үнэлэх, гүйцэтгэлтэй холбогдсон аливаа асуудал гарахад хэрхэн шийдэх вэ гэдэг нь тодорхойгүй явж ирсэн. Энэ хугацаанд бол манай ажлын албанаас бас төсөвтэй холбоотой зөрчлүүд үүсэж, эрүүгийн хуулиар зохицуулагдсан зүйл нь бий. Энэ дүрэмд тусгагдаагүй байсан учраас бид нар урьдчилж тухайн хүнийг тухайн ажлын байран дээр зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохицуулах тийм боломж нь бид нарт олгогдоогүй байсан. Тийм болохоор энийг ингэж Төрийн албаны тухай хууль болон бусад шатлалын дагуу .../минут дуусав/.

**Л.Энхнасан:** Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэбат:** Шууд санал хэлчихье дээ. Би бас өмнө нь энэ Үндэсний зөвлөлийн дүрэмд удаа дараа өгч байсан юм. Даатгуулагчдын нийтлэг эрх ашигтай холбоотой зарим асуудлаар энэ Үндэсний зөвлөл, хороод маань энэ нээлттэй хурал зарлаж байгаач гэдэг энэ юмыг оруулж өгөөч гэдэг саналыг бол хэлсэн. Энийг энэ төсөл дээр бол байхгүй байна. Тийм учраас энэ төсөл дээр бол оруулж өгөөч гэж. Материал өгөхөд ажлын 2 хоног гээд тавьчихсан байна. 5 хоног гээд. Яах вэ хоног хугацаа тавьж байгаа нь сайн. Гэхдээ бүхэл бүтэн том төсөвтэй болж орж ирдэг. Асар их судалгаа мэдээлэл, өвчний онцлогоос шалтгаалаад янз бүрийн өртөг тооцох гээд төвөгтэй маш олон асуудал байдаг юм. Нөгөө 13А гээд л сүүлд нь нийгэм даяар хэлэлцүүлэг энэ тэр болоод л ингээд асуудал болдог. Нөгөө даатгуулагчдынхаа санал, хүсэлтийг авч танилцуулах ийм боломж бололцоо бас гардаггүй байсан. Тийм учраас энийг бас нарийн төвөгшилтөөс нь хамааруулаад тэр ажлын 10 хүртэл хоногийн өмнө өгнө гэдэг байдлаар бас хугацааны хувьд тавьж өгөхгүй бол манай Үндэсний зөвлөлийн гишүүд маань өөрсдөө ч бүрэн танилцаж чадахгүйгээр чухал чухал шийдвэрүүдтэй холбоотой эрүүл мэндийн бас эрсдэлтэй ийм чухал асуудлуудаар шийдвэр гаргах гээд байдаг. Тийм учраас энэ бол нэг талаар бол бас ажлын алба болон бас төрийн байгууллагуудаас орж ирж байгаа энэ хариуцлагыг өндөржүүлэх бас нэг ийм чухал асуудал. Нөгөө талаар олон нийт бас саналаа өгөх, мэдээлэл авах ийм боломж бололцоогоор хангаж өгч байгаа ийм асуудал байгаа юм.

Дараагийн нэг асуудал нь Үндэсний зөвлөл зөвхөн Их Хуралд ажлаа тайлагнана гэхчхэн байгаа. Тэр дээр нэмэх нь олон нийтэд болон тайлагнаа гэдэг юмыг бол оруулж өгөөч. Ер нь бол энэ бол дүрэм журамдаа орсон ороогүй бол байх ёстой. Гэхдээ дүрэмд байхгүй гэдгээр олон нийтэд одоо яг Үндэсний зөвлөл

ажлаа тайлагнана гэдэг юм байхгүйгээс болоод заавал тайлагнах албагүй мэтээр бас ойлгож явж ирсэн юм байна лээ. Тийм учраас энэ бол хүний бүх 3 сая даатгуулагчидтай холбоотой, эрх ашигтай холбоотой асуудал учраас энэ тал дээр бол энэ олон нийтэд гэдгийг бол 4 дүгээр зүйлд оруулж өгөөч ээ.

Мөн төлөөлсөн байгууллага болон тэдгээр байгууллагууддаа бол танилцуулж тодорхой танилцуулсан байна гэдэг ийм зүйлийг хэлмээр байна.

Тэгээд 4 дээр тэр мэдээллийн нууцыг хадгалах гэдгийн цаана бас олон асуудал байгаад байдаг юм. Нууц нууц гээд зарим талаар бол үндэсний зөвлөлийн гишүүд маань зарим нэгэн болж бүтэхгүй гэдэг ийм асуудлуудыг бол тэр нууцыг нь хэн ч тогтоогоод байдаг юм. Тэгээд материал тараахдаа нууц шүү гээд нэг албан тушаалд нь өгчихдөг. Тэрийг нь олон нийтэд нь бас ингээд санал хураалт авъя гэхээр болдоггүй. Тэгэхээр тэр Нууцын тухай хуулиар хязгаарлахгүй бол энэ нууц гэдэг зүйлийг заавал хадгалах гэдэг юман дээр мэдээж байна. Гэхдээ үүнээс болоод Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа хаагдмал болчих вий гэдэг дээр бас болгоомжилж байгаа учраас энэ зүйлийг бол заавал энэ дээр ингээд мэдээлэл хийхийг бас хориглоно энэ тэр гээд бас тавьчхаад байна л даа. Тэгэхээр энэ тал дээр бас анхаараач гэдгийг бол хэлмээр байна. Ийм л санал хэлмээр байна.

**Л.Энхнасан:** Тэгээд Алтанхуяг дарга хариулна. 7 дугаар микрофон. Тэгэхдээ ер нь тэгэхдээ ер нь хариулсан нь дээр байх. Яг хүлээж авах уу, болох уу, болохгүй юу.

**Б.Алтанхуяг:** Эрдэнэбат гишүүний саналтай холбогдуулж бас 2 тодотгол тайлбарыг хэлэх гэсэн юм. Ер нь бол яах вэ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өмнө мөрдөгдөж байсан дүрэм дээр бол яг энэ Үндэсний зөвлөлийн даргын зөвшөөрөлгүйгээр гэдэг энэ хязгаарлалтууд бол байсан. Тэгээд бид бол энэ дүрмийн ерөнхий 1.3 дахь зарчим дээр бол тэр ил тод, нээлттэй гэдэг дээр бол ажлын хэсгийн бүх гишүүд болон Байнгын хороо болон Улсын Их Хурлын Тамгын газраас томилогдсон ажлын хэсгийн хүрээнд бол энэ зүйл дээр бол санал нэгдсэн. Эрдэнэбат гишүүний сая хэлдэг маш чухал асуудал. Өнөөдөр 3,5 сая даатгуулагч даатгуулсан бол даатгалын хөрөнгийн захиран зарцуулалт ямар байгаа гэдэг дээр. Энэ хүрээн дээр 1.3 дээр бол нээлттэй, ил тод байдал гэдгийг бол тодорхой оруулж өгсөн.

Мөн дээр нь 4.2.8 дээр Үндэсний зөвлөлийн хуралдаан, шийдвэрийн талаар иргэд, даатгуулагчдад нээлттэй мэдээлэл өгөх, зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах гэж ингэж оруулж ирсэн. Энэ шинэ заалт байгаа. Өмнө нь бол яг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны талаар нийгэмд гэдэг юм уу, даатгуулагчдад шууд нээлттэй үйл ажиллагаа явуулах нь зайлшгүй зөвлөлийн даргын зөвшөөрөлтэйгөөр гэдэг ийм асуудал байдаг байсан учраас одоо бид бол үйл ажиллагаа маань нээлттэй байх ёстой. Энэ хүрээндээ бол Үндэсний зөвлөлийн хуралдаан шийдвэрийн талаар иргэд, даатгуулагчид нээлттэй мэдээлэл өгөх гээд энэ нь бол нээлттэй орж ирсэн.

Харин гэхдээ нэг зүйлийг бол бид нар яах вэ ажлын хэсэг дээр ярьсан байгаа. Та бүхэн төсөл дээр харж байвал төслийн 4.2.9 дэх заалт дээр Үндэсний зөвлөлийн зорилго, зорилтод үл нийцэх үйл ажиллагаанд 1 дүгээрт оролцох, Үндэсний зөвлөлийн даргатай зөвшилцөхгүйгээр бие даан шийдвэр гаргах, амлалт өгөхийг хориглоно гэж. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн

бас мэргэжлийн ёс зүйн хувьд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд дээр хяналт шалгалтыг зохион байгуулах, тэрэнтэй холбоотойгоор даатгуулагч болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудаас амлалт авах, өгөх, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал дээрээ бол холбогдох хууль тогтоомжийг зөрчих ийм асуудлыг бол байж болохгүй гэж, энэ нь зөвхөн хууль болон дүрмийн зорилго, зорилтод үл нийцэх гэдгээр нь хязгаарлаж өгөөд, бусад нээлттэй байх асуудлууд нь бол шийдвэрийн дараа олон нийтэд талуудын төлөөллийн бүрэлдэхүүнүүд бол нээлттэй мэдээлэл өгөх асуудлыг бол оруулж ирсэн.

Тэр 10-аас доошгүй хоног гэдэг асуудлыг бас зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Бид нар бол яах вэ ажлын хэсэг дээр бол бас нэлээн ярьсан юм. Мэдээж яг Үндэсний зөвлөлийн шийдвэр гаргах хуралдаан товлогдлоо Үндэсний зөвлөлийн даргаас. Тэгвэл Үндэсний зөвлөлийн дарга руу тэр асуудал орохын өмнө ажлын алба хуулийн ажлын хэдэн өдрийн хугацаанд хянаж үзэж, гишүүдэд мэдээлэл хүргүүлэх юм. Ажлын алба руу мэдээлэл орохын өмнө энэ жил бид нар бас техникийн хороогоо байгуулсан байгаа. Техникийн хорооны маань үйл ажиллагааны санхүүжилтийн асуудал шийдэгдээд ирэх оноос бол үйл ажиллагаа нь жигдрээд эхэлнэ. Тэгэхээр ажлын алба руу орохын өмнө техникийн хороо ямар хугацаанд хянах юм. Техникийн хороо руу орохын тулд тухайн асуудлыг оруулж байгаа.../минут дуусав/.

**Л.Энхнасан:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байвал нэрсээ өгнө үү. Ариунзаяа, Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн үгээ хэлнэ үү.

**А.Ариунзаяа:** Үг хэлж, асуулт асуухлаар шүүмжилсэн болчих гээд байдаг. Дуугай байхаар дэмжсэн, зөвшөөрсөн болчих гээд байдаг. Яалт ч үгүй сонсож байгаад л тэгээд л эцэст нь үг хэлье гэж бодоод л үг хэлж байна л даа. Сайд нь байхгүй. Төрийн нарийн маань би хариулмааргүй байна гээд хэлчихлээ. Ажлын алба маань бидний статус тодорхой биш байна гээд л бас нэг юм ярьчих юм.

Эрүүл мэндийн даатгал, даатгалын сан. Энэ улаан, ногоон, шар гэрэл гэж байдаг бол улаан байтугай ер нь маш хүнд нөхцөл байдалд орчихсон. Ер нь энэ Эрүүл мэндийн даатгалыг Нийгмийн даатгалын зохион байгуулалт, менежментээс салгасан нь өөрөө буруу ч шийдвэр юм шиг санагддаг надад. Үнэхээрийн бэлэн биш байна. Эрүүл мэндийн яам өөрийнхөө өдөр тутмын ажилдаа хэт дарагдаж ачаалалтай байгаа учраас энэ Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаандаа үнэхээрийн анхаарч эзэн шиг эзэн болж чадахгүй байгаа юм уу даа л гэж харагдах боллоо.

Эртээр тайлангаа оруулах гээд бас тайлангаа тавьж чадаагүй 7 хоног хойшлуулсан. Миний санал бол журмыг нь бас 7 хоног хойшлуулаад, энэ гишүүдийн саналыг бас оруулаад нэлээд сайн чамбайруулж оруулж ирсэн нь зүйтэй юм болов уу л гэж харагдаад байна л даа.

Ер нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд, ажлын алба ажлуудаа жоохон чамбайруулна байгаа. Ер нь л жоохон шүүмжлэл дагуулаад байна шүү. Үнэхээрийн дуугүй байя гэхээр хэчнээн дэмждэг ч гэсэн дуугүй байя гэхээр бас арай л назгай байгаад байна.

**Л.Энхнасан:** Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

**Б.Бат-Эрдэнэ:** Та хэд маань бол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм гээд анхнаасаа ингээд оруулж ирээд, батлуулах гээд дэмжүүлэх гээд явж байгаа. Гишүүдийн хэлж байгаа саналыг аль болох тусгаж аваад явбал та хэдэд маань өөрсдөд нь маш хэрэгтэй байхгүй юу. Уг нь та нарын төлөө л хэлээд байгаа юм. Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой асуудлууд, хулгай луйвартай холбоотой асуудлууд хөндөгдөөд л байдаг. Зөвлөлийн гишүүдийн хариуцлагын асуудал юу вэ гэхээр Хууль тогтоомжийн тухай хууль гээд ойлгож байна. Тэр юмнуудыг бол ойлгоод байгаа юм. Тэгэхдээ явж явж яг ингээд эргээд харахаар даатгуулагчдын эрх ашгийг ер нь яг хэн хамгаалах ёстой юм. Хэрэглэгчийн байгууллага хамгаалах ёстой юм уу. Эсвэл та хэд Үндэсний зөвлөлийнхөө үүрэг дотор оруулаад, бид нар сая нийгмийн даатгал дээр ч гэсэн ярьсан л даа. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм дээр бид нар Үндэсний зөвлөлийн үүрэг дээр нь даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах үүргийг оруулж өгье гээд, оруулъя гээд авсан. Та хэд ч маань бас оруулчихвал зүгээр байх. Бид нар эрх зүйн хувьд ялангуяа энэ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээхтэй холбоотой асуудлуудыг хөндөөд явахаар түрүүн ч бас их л зөв л хариулж л байна лээ л дээ. Мэргэжлийн ёс зүйтэй холбоотой асуудал хариуцлагын асуудал яалт ч үгүй бас орж ирнэ гээд л. Тэгэхээр энэ даатгуулагчийн эрх ашгийг хамгаалж байгаа субъекттэй холбоо бүхий асуудал яалт ч үгүй л хөндөгдөх. Та хэд маань уг нь болж өгвөл яаж ийгээд л энэ Улсын Их Хурлын гишүүдийн орж ирж байгаа саналыг боломжоор нь аваад, нэмэлт, өөрчлөлтийг оруулаад, нэмэлт, өөрчлөлт ч юу байх вэ дээ оруулах ёстой өөрчлөлт байвал оруулаад, тэгээд л эцэслээд оруулаад ирвэл зүгээр юм болов уу л гэж бодож байна. Тэрнээс биш ингээд бид нар тэдэн удаа авч хэлэлцсэн юм гээд байдаг. Тэгээд ороод ирдэг. Нөгөөдөх нь бас тийм хангалттай түвшинд хариулт өгч чадахгүй байгаад байгаа нөхцөл байдал л байна л даа. Ийм л саналтай байна.

**Л.Энхнасан:** Гишүүд үг хэлж дууслаа.

Тэгэхээр ер нь би ойлгож байгаагаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйл бол нөгөө 14.1-ийн заалт нь нөгөө нийгмийн даатгалын ерөнхий хуультай уялдуулж өөрчлөлт орно гэж ойлгож байгаа. Өөрчлөлт орсны дараа бол энэ журам дүрэм бас дахиж өөрчлөгдөнө гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр бас энэ дүрэм журмаа бол эхний байдлаар батлаад явах нь зүйтэй юм уу гэсэн бодолтой байгаа. Саяын гишүүдийн оруулсан саналуудыг оруулаад. Яах вэ, бид нар Үндэсний зөвлөлийн тайланг сонссон шүү дээ. Тэгээд дүрэм журам Байнгын хороогоор олон удаа ороогүй, батлуулаагүй гээд. Энэ Үндэсний зөвлөлийг бас ажилд нь оруулмаар байна шүү дээ. Тэр техникийн хороог нь байгуулмаар байна. Тэгээд үнэхээр Эрүүл мэндийн яамнаас бас энэ хуульд өөрчлөлт ороод, дахиж нэмэлт, өөрчлөлт энэ журам дүрэм дээр орох учраас тэр үед нь дахиад сайжруулна гэж бодож байгаа. Хаврын чуулганаар бол орж ирэхээр байгаа шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр батлаад өгнө үү гэж та бүгдээс хүсье. Ингээд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг батлах Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоолын төслийг гишүүдийн саналыг тусгаад энэ томьёоллоор санал хураалт хийе. Дэмжье гэсэн саналаар санал хураалт хийе.



61,5 хувиар татгалзсан, зөвшөөрсөнгүй. Дүрмээ дахиж боловсруулж оруулж ирнэ үү. Сайдыг бас хуралд оролцуулах тал дээр анхаарна уу. Хурал дууссаныг мэдэгдье.

14.24 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*